



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**НЭГДСЭН ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

---

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9-73
<i>1.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 5 гишүүн 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	10-48
<i>2.Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахмал түлиний талаар” тавьсан асуулгын хариуг сонсох</i>	48-70
<i>3.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох</i>	70-73

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
11 дүгээр сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 44 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, П.Анужин, Б.Баттөмөр, Э.Батиугар, Б.Баярсайхан, Б.Бейсен, Х.Болорчулуун, Д.Ганбат, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Г.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Б.Саранчимэг, Н.Учрал, Л.Энх-Амгалан, Н.Энхболд, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Э.Бат-Амгалан, Ц.Мөнх-Оргил, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар;

Тасалсан: Ц.Идэрбат;

Хоцорсон: С.Батболд-40 минут, Х.Ганхуяг-06 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ш.Адъяа нараас албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ш.Адъяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Ч.Ундррам нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

**Нэг.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 5 гишүүн 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот

байгуулалтын газрын дарга Э.Батболд, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Хууль, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адьяа, Ц.Туваан, Ж.Батжаргал, Г.Ганболд, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Н.Ганибал, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Хууль, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Энхтуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, 12 цаг 22 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1</sup>.2.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу 100 мянгаас дээш санал авсан 3 өргөдөл байгаа талаар мэдээлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 14 цаг 23 минутаас хуралдааныг даргалав.

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахмал түлшний талаар” тавьсан асуулгын хариуг сонсох***

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч О.Номинчимэг, Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Б.Батшагай, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Б.Угтахбаяр, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, мөн яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунжаргал, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Б.Хангай, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Төрмөнх нар байлцав.

Асуулгын хариуг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Ж.Батсуурь, Н.Ганибал, М.Оюунчимэг, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч О.Номинчимэг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунжаргал, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн нар хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахмал түлшний талаар” тавьсан асуулгын хариуг сонслоо.

*Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар нар байлцав.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:*

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:51/

2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг санал хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:51/

3.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:51/

***Холбогдуулан боловсруулсан:***

4.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:52/

***Дагалдан гарсан:***

5.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:52/

6.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:52/

7.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:53/

8.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:53/

9.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:53/

10.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:53/

11.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

12.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

13.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

14.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

15.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

16.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

17.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

18.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн

найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:55/

19.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:55/

20.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:55/

21.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:55/

22.Геоземи, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:55/

23.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:56/

24.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:55/

25.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:56/

26.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:56/

27.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:56/

28.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс



эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:57/

29. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:57/

30. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:57/

31. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:57/

32. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:58/

33. “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:58/

34. “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:58/

35. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:58/

36. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:58/

37. “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:58/

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид болон Сүхбаатар сумын 5 дугаар сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Сарангэрэл, Т.Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн ахмадуудын төлөөлөл, Нийслэлийн 297 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, Байгальд ээлтэй залуусын чуулга уулзалтад оролцогч хүүхэд, залуучуудын төлөөлөл, Олон улсын парламентын холбооны хамтын ажиллагаа аргачлалын дагуу явуулсан өөрийн үнэлгээний үйл ажиллагаанд зөвлөхөөр ажилласан Их Британийн парламентын гишүүн, сайд асан хатагтай Мэг Манн, мөн холбооны Жендерийн түншлэлийн хөтөлбөрийн ажилтан хатагтай Мариана Дуарте, Хүний эрхийн асуудал эрхэлсэн ажилтан хатагтай Ботанья Ламхарзи нар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар Архангай аймгийн Тариат, Чулуут сумдын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрэм, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны Захирагчийн ажлын алба болон Соёлын төвийн албан хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 3 цаг 34 минут үргэлжилж, 72 гишүүнээс 42 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 02 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр,  
Баасан гараг Төрийн ордон “Их  
хуралдай” танхим 10 цаг 44 минут.

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Л.Мөнхбаатар:** Улсын Их  
Хурлын гишүүдийн амрыг эрье.

*Ирц хүрсэн байна.*

Улсын Их Хурлын 2023 оны  
намрын ээлжит чуулганы 11 дүгээр  
сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаан  
нээснийг мэдэгдье ээ. Чуулганы нэгдсэн  
хуралдаанаар хэлэлцэх асуудлыг  
танлицуулъя.

1.Газрын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл  
болон хамт өргөн мэдүүлсэн Тариа  
тариалангийн тухай хуульд өөрчлөлт  
орлуулах тухай хуулийн төсөл Улсын Их  
Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ,  
Ганзоригийн Тэмүүлэн, Лхагвын  
Мөнхбаатар, Наянтайн Ганибал,  
Чинбатын Ундрам нарын 5 гишүүн 2023  
оны 6 сарын 20-ны өдөр өргөн  
мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх шийднэ.

Үдээс хойших чуулганы нэгдсэн  
хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын  
гишүүн Одонгийн Цогтгэрэлээс Монгол  
Улсын ерөнхий сайдад хандан  
Улаанбаатар хотын утаа болон  
сайжруулсан шахмал түлшний талаар  
тавьсан асуулгын хариуг сонсоно оо.

Улсын Их Хурлын чуулганы  
хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т  
гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн  
хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон

асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх,  
асуудал нэмэх горимын санал гаргах бол  
Улсын Их Хурлын даргад нэгдсэн  
хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас  
өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр  
ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их  
Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар,  
Наянтайн Ганибал, Ширнэнбандийн  
Адъяа нараас тус тус ирүүлсэн албан  
бичгүүдийг танлицуулъя.

Улсын Их Хурлын дарга  
Гомбожавын Занданшатар танаа  
Миний бие 2023 оны 11 дүгээр сарын 24-  
ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы  
нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх  
асуудалтай холбогдуулан үг хэлэх  
хүсэлтэй байгаа тул зохих журмын  
дагуу зөвшөөрөл олгоно уу? Улсын Их  
Хурлын гишүүн Наянтайн Ганибал гэсэн  
байна.

Монгол Улсын Их Хурлын дарга  
Гомбожавын Занданшатар танаа  
Монгол Улсын Их Хурлын чуулганы  
хуралдааны дэгийн тухай хуулийн 13  
дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны  
дагуу Улсын Их Хурлын 2023 оны 11  
дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы  
нэгдсэн хуралдаанд хэлэлцэгдэх  
асуудалтай холбогдуулан үг хэлэх  
саналаа үүгээр хүргүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүн  
Ширнэнбандийн Адъяа. Ирчихсэн  
байгаа юу?

Монгол Улсын Их Хурлын дарга  
Гомбожавын Занданшатар танаа  
Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11  
дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы  
нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай  
холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно  
уу? Улсын Их Хурлын гишүүн  
Ганбаатар гэсэн байна. Улсын Их  
Хурлын гишүүн Наянтайн Ганибал үг  
хэлье.

**Н.Ганибал:** Бүгдэд нь өглөөний мэнд. Бид нар ер нь Их Хурал дээр зайлишгүй хэлэлцэх нэг асуудал байна аа.

Монголын МАА-н салбар ХАА-н салбарт тулгамдсан хамгийн чухал асуудал бол энэ жилийн өвөлжилтийн байдал цасны орсон байдал саяхан болсон 2 хоногийн өмнө болсон энэ цасан шуурганы улмаас олон иргэд бас төөрч түүнийгээ эрж хайх энэ асуудлууд бид бүхний хувьд өвлийн бэлтгэл ажил, энэ асуудлуудаа яаралтай цэгцлэх шаардлага харагдаж байна. Ер нь энэ саяын энэ цасан шуурганы үед малчид маань яагаад төр вэ гэдэг асуудлыг бүгдээрээ бас бодох ёстой.

Нэгдүгээрт малчид маань зарим малчид маань өвөлжөөндөө буух тэр шатахуунгүй байна шатахуунгүй байна. Өнөөдөр малчдын яг хэрэглээний хамгийн чухал хэрэглээ болох тэр портер бонгоонд хийх түлшгүй байна. Өнөөдөр өвөлжөөндөө буюгаагүй малчин малынхаа хашаа саравчиндаа малаа хийж чадахгүй. Тийм учраас малынхаа араас явган нүцгэн явж өнөөдрийн энэ төөрсөн байдал үүсэж байна. Ер нь ийм байдлаар асуудлуудаа шийдэхгүй бол энэ Засгийн газраас дараагийн энэ хүний амь эрсдэх нөхцөл байдал үүсээд байгаа. Эрсдсэн тохиолдолд Засгийн газраас нэхнэ шүү.

Тийм учраас энэ яг бензин шатахуунаа хэрэглэгчийнхээ эцсийг нь тэр малчдадаа хүргэж өг өө. Уул уурхай чинь хэвийн явж байна. Том үйлдвэрлэлүүд чинь хэвийн явж байна. Харамсалтай нь тэр яг жижиглэнгээр очиж байгаа хэрэглэгч дээрээ наад шатахуун чинь очихгүй байна. Энэ өвөлжилтийн энэ асуудалтай холбоотой бас гарч байгаа нэг асуудал бол тэр өвсний тээвэрлэлтийн асуудал дээр бас л шатахуунгүйгээс болоод малчид маань өөрсдөө өвөлжөөн дээрээ

өвс тэжээлээ буулгаж чадахгүй байна. Тэгээд ийм нөхцөл байдлыг өнөөдөр Монгол Улсын Засгийн газар бий болгочихлоо. Энэ дээр яах ёстой юм бэ? Хэдүүлээ энэ дээр Их Хурлын яаралтай тогтоол гаргах юм уу? Энэ жижиглэнгийн хуваарилалтууд чинь ямар байгаа юм? Энэ асуудалдаа анхаарал хандуулмаар байна.

Дээрээс нь үнэхээр энэ геополитикийн асуудал үүсээд байгаа бол тэрэн дээрээ бас арга хэмжээ аваач ээ. Дандаа л болох талаар л ярих юм. Яг бодит амьдрал дээр болж байгаа юм бас байхгүй байна аа. Өвөлжилттэй холбоотой гарч байгаа нэг асуудал бол махны нөөц бүрдүүлэлтийн асуудлууд их хэмжээгээр малчид маань малаа нядалж махны нөөцийг бүрдүүлж байна. Тэгэхдээ энэ асуудал дээр өнөөдөр Засгийн газар бас нэг байр суурь гаргамаар байна. Махныхаа экспортын асуудал дээр үнэхээр экспорт хийж байгаа үндэсний махны үйлдвэрүүд байвал эргэлтийн тэр зээлийн богино хугацааны зээлүүдийг гаргаж өгмөөр байна аа. Худалдан авах тэр чадамжийг нь нэмэгдүүлмээр байна. Экспортынх нь тэр бүх боломжуудыг ямар нэгэн хүнд сурталгүйгээр гаргах энэ боломжийг нээж өгөх зайлишгүй шаардлагатай байна.

Өнөөдрийг хүртэл бас энэ асуудлууд дээрээ энэ Хөдөө аж ахуйн яам бас бодит ажлуудыг хийхгүй 7 хоногийн өмнө л дөнгөж тэр экспортынхоо хуулиудыг нэг талд нь журамлаж байдаг. Ийм байдалтай бид нар явах юм бол энэ цаг үеэсээ хоцорсон бодит үнэнээсээ буруу шийдвэрүүд гаргасан ийм л байдалтай байна. Одоо тэр хүнсний хувьсгал гээд 1 их наядын алдарт эх зээлийн хөрөнгө хаана явна.

Тэр мөнгөнөөс өнөөдөр экспорт хийж байгаа үндэсний махны үйлдвэрүүдэд нэн яаралтай олгох хэрэгтэй. Ийм байдлаар асуудлыг хангахгүй ер нь болохгүй нь ээ. Саяхан бас зөвхөн Сүхбаатар аймаг гэлтгүй Архангай аймаг дээр ч гэсэн энэ асуудал яг бас адилхан л нөхцөлтэй байна. Малчдад түлш байхгүй, шатахуун байхгүй, өвс хадлан тэжээлээ өвөлжсөө рүүгээ татах тэр боломж нь хаалттай. Дээрээс нь их хэмжээний нядалгаа хийсэн. Тэр нядалгааг яаж борлуулах тал дээр өнөөдөр бас бүгд толгойгоо гашилгаад байж байна. Одоо бол яах вэ байгалийн хөлдөөгч ажиллаад эхэлчихсэн, цаг хугацааны хувьд бол энэ 3 сарын хугацаанд бол хэзээ ч зарахад боломжтой.

Харамсалтай нь тэр 3 сарын дараа яах вэ гэдэг асуудал хамгийн чухал асуудал болоод байна. Энэ жилийн хувьд бол маш онцлог жил явж байна энэ өвлийн хувьд. Гэнэтхэн хүйтэрч байна. Бас заримдаа дулаарч байна. Энэнээс болоод бэлчээр цас мөснөөс болоод бэлчээр их хэмжээгээр дарагдаж байна.

Дээрээс нь дулаарсан үед манай малчид маань бас дулаан хувцастай малдаа яваад байгаа энэ асуудлаас болж шуурганд төөрөхдөө бас даарах бээрэх асуудлууд үүсэж байгаа юм. Энэ дээр бас малчдадаа уриалахад ер нь өвлийн энэ цаг хугацаанд байнгын дулаан хувцастайгаа бас малаа маллаж байх.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьяаа үг хэлнэ.

**Ш.Адьяаа:** Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая аа.

Монгол Улсын Их Хурал Монгол Улсын гадаад дотоод бодлого дүгнэлт хийж үндэсний аюулгүй байдлын

асуудалд ч гэсэн хор хохирол учрахуйц ийм асуудлаар бид тодорхой шийдлийг гаргах ёстой.

Өнөөдөр Монгол Улсад хүний эрх, эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө, Үндсэн хуульд заасан хүний эрхийн асуудал бол энэ Монгол Улсын хэмжээнд бас нэлээн олон талаасаа ярьж шийдэх ийм асуудалтай байгаа нь бас их анхаарал татаж байгаа юм. Нөгөө талаасаа энэ хэвлэлийн эрх чөлөө хүний эрх гэдэг асуудлыг бид дэмжиж ардчилсан Монгол Улс бол хэрэгжүүлж ирсэн. Гэтэл өнөөдөр энэ хэвлэлийн эрх чөлөө, хэвлэл мэдээлэл, сошиал ертөнц гэдэг энэ чинь өнөөдөр хаашаа яваад байна аа.

Бага насны хүүхдийг гэмт хэрэгт уруу татахыг уриалсан, бэлгийн дарамтад оруулахыг уриалсан, хүчирхийлэл садар самуун энэ үндэстэн ястны хооронд яс хаясан Монгол Улсын тусгаар тогтнол гадаад бодлоготой холбоотой энэ асуудал дээр нийгмийн тархийг угаасан ийм юм өнөөдөр Монгол Улсад газар авлаа. Энэ хэрээс хэтэрч байна. Энд Монголын төр шийдвэр гаргаж энэ асуудалд дүгнэлт гаргахгүй юм уу? Бид нар одоо нэг хууль гаргаад л бөөн асуудал болоод л тэгээд л эргээд л Ерөнхийлөгч хориг тавиад л ингээд л цуцалж л байсан. Тэгээд одоо энэ асуудлаа шийдэхгүй бол бид яах вэ нэг хэдэн улс төрчид тэр уул усны зурагтай тэр хуурамч хаягаас муулуулж сайлуулах нь нэг хэрэг ээ.

Энд бол бид тэвчээртэй энэ дээр хандана. Гэтэл өнөөдөр энэ асуудал чинь бүүр хэтрээд геополитик Монгол Улсын гадаад бодлого энэ асуудал халиад орчихлоо. Энд хязгаарлалт тавьж болдоггүй юм уу? Бид нар Монгол Улсын үндэсний аюулгүйн асуудал, гадаад дотоод бодлогын асуудлаар шийдвэр гаргах энэ бүрэн эрх

нь байгаа гэж ойлгож байгаа. Энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүйгээс улс орныг ийм байдалд оруулах нөхцөлийг бүрдүүлбэл бид бас хариуцлага хүлээх ёстой гэж бодож байгаа. Энэ асуудлыг ер нь энэ Улсын Их Хурал дүгнэлт хийж энэ зайлиггүй шийдвэр гарах шаардлагатай байна.

Бид өнөөдөр бага насны хүүхдийг хучирхийлдэг садар самууныг сурталчилдаг энэ юм чинь хэрээс хэтэрлээ. Тэгээд тэр төлбөртэй, төлбөргүй бусдыг доромжилдог энэ юманд байдаг юм байна гэж боддог юм.

Гэхдээ нийт олонхын эрх ашиг нэг хүний эрхээс илүү нийт олонхын эрх ашиг гэдэг юман дээр чинь бид шийдвэр гаргана, хууль хэрэгжүүлнэ гэж ингэж л бид тангараг өргөж орж ирсэн шүү дээ. Бид өнөөдөр дүгнэлт хийж энэ улс орны чинь хаашаа яваа байдалд бид засаж залруулах ийм чадамж байгаа юм уу, байхгүй юм уу? Энэ дээр бид шийдэх ёстой гэж үзэж байгаа юм. Хүний эрх, эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг дэмжинэ, дээдэлнэ ээ. Тэгэхдээ хэмжээнээс хэтэрсэн улс орны аюулгүй байдал асуудал.

Монгол Улсын тусгаар тогтнолын асуудал геополитикийн асуудал шийдсэн ийм юмаар өнөөдөр нийгмээ талицуулаад хагаралдуулаад сүүлд нь ямар байдалд бид энэ ард түмнээ эх орноо авч орох гээд байна аа. Энэ дээр бид өнөөдөр яагаад шийдвэр гаргахгүй байна. Бид нар энэ шийдвэр гаргахыг яагаад хүсэхгүй байна. Энэ ямар нөлөөлөлд бид автаад байна гэдгийг бас бид бодох ёстой гэж бодож байгаа.

Би энэ хууль тогтоогчийн хувьд ард түмний төлөөллийн хувьд би энийг хэлж байгаа шүү. Тэрнээс биш энэ өнөөдөр нэг улс төрчид бид нарыг нэг

шоолоод муулаад сайлаад байна гэдэг асуудал биш. Бид нар нялх хүүхдүүдтэй. Бид ирээдүй болсон үр хүүхдүүдтэй. Энэ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, геополитик гэдэг юмыг чинь энэ Улсын Их Хуралд ярьж хэлж энд тодорхой хязгаарлалт тавьж засаж залруулахгүй юм бол бид нар энд суусны хэрэг гэж байгаа юм уу, байхгүй юм уу. Энэ дээр энэ Улсын Их Хурал, Улсын Их Хурлын удирдлага олонх, цөөнхийн бүлэг энд ярьж шийдэхийг би албан ёсоор шаардаж байна.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ЕБС-ийн багш ажилтнууд болон Сүхбаатар сумын 5 дугаар сургуулийн 12-ын А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөр, сурлагад нь өндөр амжилт сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлъя.

11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа төрсөн байна. Мөн энэ өдөр Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам нар төржээ.

Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа, Чинбатын Ундрам нарт төрсөн өдрийн мэнд хүргэж Монгол төрийн эрхэм түшээ ард түмний элч болсон та бүхэнд болон танай гэр бүлийнхэнд Улсын Их Хурлын

гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе өө.

Жаргалмаа гишүүн Сүхийн Бадарч, Чүлтэмийн Жижээхүү нарын айлын 5 дахь охин болон мэндэлсэн байна. Ундрам гишүүн, Чойжамцын Чинбат, Доржийн Тунгалаг нарын айлын том охин болон мэндэлсэн байна аа. Та бүхэнд сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар үг хэлнэ.

**Ж.Ганбаатар:** Дизель болоод 92 дээр асуудал байгаа. Тэгээд Засгийн газраас, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас энэ асуудлыг цэгцлэхээр ажиллаж байна. Би энэ 2023 оны 11 сарын 1-ээс 23-ны хооронд хилээр орж ирсэн мэдээлэл энэ гаалийн мэдээлэл шүү. Энэ мэдээллээр бол дизель түлш 95300 тонн хилээр орж ирсэн, 92-ын хувьд 50400 тонн. Энийг би яагаад үзүүлж байгаа юм бэ гэхлээр Монгол Улсын нийт хэрэглээ дизель түлшний хувьд бол сарын хамгийн ихдээ 92 мянга байдаг. 92-ын хувьд бол хамгийн ихдээ 52, 53 мянган тонн. Ингээд эхний 22 өдрийн байдлаар орж ирсэн гаалийн мэдээллийг би та бүхэнд үзүүллээ. Энэ тэгээд орж ирж байгаа юу гэдэг асуултад би хариулж байгаа юм шүү.

Тэгээд энэ бол нөөцийн мэдээ биш шүү. Тэгэхээр би энийг нөөцийн мэдээ биш гэдгийг хэлье. Энэ гаалийн мэдээ. Энийг үнэн зөв үү, Ганбаатарын үзүүлж байгаа мэдээ буруу юу, үнэн үү гэдгийг өөр эх үүсвэрээс шалгаж болно оо. Би энийг сэтгүүлч нарт байнга хэлж байгаа. Энэ ер нь асуудал юунаас үүдэлтэй вэ гэхээр өнөөдөр ОХУ-ын юу Засгийн газраас бүх дэлхийд шүү дээ тэ 2023 оны 9 сарын 21-нд хориг тавьсан. Дизелийн болоод авто бензиний. Энэ

хориг өнөөдрийг хүртэл үргэлжилж байгаа. Авто бензин дээр хориг 2 хоногийн өмнө цуцлагдлаа. Дизель дээр өчигдөр дөнгөж зуны түлш экспортлох процесс цуцлагдсан. Өвлийн түлш хоригтой хэвээрээ байна.

Монгол Улсын хувьд бол энэ хоригийг хязгаарлагдмал байдлаар Монгол Улсад тавигдаж байгаа. Яагаад хязгаарлагдмал гэхлээр Роснефть болоод Газпром нефть хими сервис гээд энэ томоохон компаниудаараа Монгол Улс руу экспортолж байна. Бусад жижиг компаниуд гэх юм уу трейдер компаниуд Монгол Улс руу экспортлох боломжгүй байна. Хоригоос хойш бид нар 21 хоног Ганибал гишүүн ээ, 21 хоног бид бүх нөөцөө шавхсан. Яг юу ч орж ирээгүй хилээр. Гэхдээ энэ хориг ганцхан Монголд тавьсан хориг шүү дээ та өөрөө сайн мэдэж байгаа. Их Хурлын гишүүний хувьд. Бүх дэлхийд тавигдсан хориг Дундад Азийн 5 улс л энэ хоригоос нөгөө Засгийн газрын хэлэлцээрийн үр дүнд ороогүй. Бусад бүх улс орон орсон. Тэгээд Монгол Улсын хувьд бол энэ байдлаас гарахын тулд БНХАУ-аас дизель импортолж байгаа. Энэ мэдээн дээр тодорхой байгаа. 92-ын хувьд бол ингээд байдал харьцангуй зүгээр сайжрах түвшиндээ байна. Тэгэхдээ асуудал болж байна. Би тэгээд сая гаалиар орж ирж байгаа мэдээллийг хэллээ. Энэ бол нөөцийн мэдээ биш шүү гэдгийг дахин хэлье.

Зарим хүмүүс нөөцийн мэдээтэй андуурч байгаа учраас би нөөцийн мэдээ биш гэдгийг хэлье ээ. Баруун аймгуудаар дизель түлш маш их хүндэрсэн байсан бол 2 хоногийн өмнөөс эхлээд Боршоо Цагаан нуур боомтуудаар дизель түлш орж ирсэн. Энэ бол Уул уурхайн яам, Роснефть компанитай болоод бусад компаниудтай нэлээн ажилласны үр дүнд орж ирсэн. Энэ үндсэн дээр баруун аймгуудын дизель түлшний хангалт

харьцангуй тогтворжлоо. Энэ тохиолдолд Улаанбаатараас баруун аймгууд руу явж байсан тэр түлш зүүн болоод одоо төв төвийн бүсүүдтэй үлдэх юм.

Бид Өмнөд байгаа бүсүүддээ таны ярьсан тэр уул уурхайн бүсүүдэд бол дизель түлшийг ялангуяа Эрдэнэс таван толгой, Оюу Толгой, Эрдэнэтэд бид Хятадаас түлш импортлоод Европ 5 стандартын түлш хэрэглэхийг шахаж байгаа юм. Бид ямар ч байсан БНХАУ-аас өнөөдрийн байдлаар 7.6 мянган тонн түлш импортолсон байна. Энэ түлшээр бид уул уурхайн томоохон компаниудаа хангаж байгаа юм. Саяын миний тэр хилээр орж ирсэн түвшин дотор энэ 7.6 тонн нь бол БНХАУ-аас бусад нь ОХУ-аас орж ирсэн. Ер нь энэ асуудлууд бол байгаа.

Таны түрүүний хэлсэн жижиглэнгийн үнээр зарахгүй байгаа гэдэг үнэн. Уул уурхайн яам бол тодорхой нөхцөл валютын ханш өссөн, эс үгүй бол биржийн үнэ өссөн, тээврийн зардал өссөн тохиолдолд үнэ нэмэгдэнэ үү гэхээс биш хомсдол үүсчихсэн тохиолдолд үнэ нэмнэ гэдэг бол байж болохгүй гэж үзэж байгаа юм.

Тийм учраас колонкуудаар үнэтэй бөөнөөрөө хямдхан болсон тохиолдол байна. Энийг бид Шударга бус өрсөлдөөний газартай хамтраад тэгээд колонкуудаараа заавал зар гэдэг шаардлагыг ААН-үүдэд тавьж байгаа юм. Энэ бол таны хэлж байгаа үнэн. Гэхдээ энэ үнэ өснө гэдэг өөрөө шалтгаантай байх ёстой.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүд үг хэллээ. Наянтайн Ганибал гишүүний тавьж байгаа асуудлууд байгаа. Өвөлжилт хүндэрсэн аймгуудтай холбоотой асуудлууд саяын цасан шуурга болсон тэдгээрийн хор

хохирлыг хэрхэн барагдуулахтай холбоотой. Мөн энэ түлшний нөөцтэй холбоотой энэ асуудлуудаар тавьсан асуудлууд байгаа. Өчигдөр бас Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилэйн Даваасүрэн бас энэ асуудлыг хөндөж тавьсан.

Ийм учраас ирэх 7 хоногийн Улсын Их Хурлын 5 дахь өдрийн Ерөнхий сайдын мэдээллийн цагаар энэ өвөлжилттэй холбоотой энэ асуудлуудтай холбоотой Ерөнхий сайдын мэдээллийг сонсохоор болсон гэдгийг та бүгдэд хэлье ээ.

Ганбаатар гишүүний хувьд бол энэ дизель түлш болон энэ шатахуунтай холбоотой асуудлуудаар бас мэдээлэл өглөө.

Ирэх 7 хоногийн 5 дахь өдрийн Ерөнхий сайдын мэдээлэлд мөн дэлгэрэнгүй мэдээллийг Ганбаатар гишүүн Уул уурхайн сайд бас нэмж өгөх нь зүйтэй гэж үзэж байна аа. Гишүүд үг хэлж дууслаа.

Хэлэлцэх асуудалдаа орёе. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар танилцуулгыг хийж байна.



ХАА-н газар нь манай орны газар ашиглалтын уламжлалтай холбоотойгоор газрын нэгдмэл сангийн дийлэнх хэсгийг эзлэх боловч сүүлийн жилүүдэд гарч буй газар ашиглалтын хэлбэр, зориулалт нэмэгдэж байгаатай холбоотой уялдан түүний хэмжээ ялангуяа бэлчээрийн талбайн хэмжээ байнга буурсаар байна.

Манай орны ХАА-н газрын хэмжээ сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд ойролцоогоор 10 орчим сая гагаар буурсан байна. 10 орчим хувийн. ХАА-н газар нь байгалийн унаган төрх нөөц чадавхаараа харилцан адилгүй тул ХАА-н үйлдвэрлэл гүйцэтгэх үүргээрээ бэлчээрийн газар тариалангийн газар, хадлангийн газар, ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар гэж хуваагдаж байна.

ХАА-н зориулалттай 119 сая га талбай байгаагаас бэлчээрийн талбай 116 сая га, хадлангийн талбай 634 мянган га, тариалангийн талбай 1 сая 171 мянга 512 га, атаршсан газар нь 238832 га, ХАА-н барилга байгууллын дэвсгэр газар нь 106339 га, ашиглалт муутай газар нь 475 мянган га гэсэн ийм тооцоо гарч байгаа. Газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн тайланг тайланд орсон. Улсын хэмжээнд 80 мянган га талбай бүхий өвөлжөө хаваржааны газрыг 137 мянган иргэн эзэмшиж байна.

Тариаланд эзэмшиж байгаа нийт талбайн хөрсний 36.2 хувь нь элсэнцэр, 53 хувь нь хөнгөн шавранцар, механик бүрэлдэхүүнтэй байна. Хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөрсөнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхдээ хөрс хамгаалах технологийг иж бүрэн хэрэгжүүлэхгүйгээс элэгдэж эвдрэлд орж байгаа гэсэн ийм тооцоолол гарч байгаа юм.

Бэлчээрийн мониторингийн 2020 оны мэдээллээр мониторингийн бүх цэгийн 42 хувь нь төлөв байдлын хувьд соргог буюу талхлагдаагүй, 13.5 хувь нь сул, 21.1 хувь нь дунд зэрэг, 12.8 хувь нь хүчтэй талхлагдсан, харин 1.3 хувь нь сэргээх боломжгүй гэсэн ийм тооцооллууд гарч байна. 2022 онд батлагдсан Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд иргэнд гэр бүлийнх хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр орон сууцын хашаа барих зориулалтаар 0.07 га-аас илүүгүй хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамлын тарих зориулалтаар 0.1 гагаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно.

Багийн иргэдийн нийтийн хурлын санал сумын ИТХ-ын шийдвэрийг үндэслэн тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэдэд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын талбай нь үр тариалангийн зориулалтаар 100 га хүртэл төмс ногооны зориулалтаар 5 га хүртэл байна гэж тус тус заасан байдаг.

Дээрх хуулийн заалтаас үзэхэд иргэн төмс, хүнсний ногоо, таримал ургамлын зориулалтаар олгогдсон газрын хэмжээ 0.1 гагаас илүүгүй байх бөгөөд зөвхөн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэн 0.1 гагаас илүү хэмжээгээр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй байна.

Өөрөөр хэлбэл иргэнд газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажиллаагүй бол 0.1 гагаас илүү хэмжээгээр газар үнэ төлбөргүй эзэмших эрх олдохгүй болоод байна. Мөн

Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт заасны дагуу атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх ашиглуулахыг хориглосон тул сум орон нутгийн иргэдэд төмс, хүнсний ногоо, таримал ургамал тарих зориулалтаар эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалт нь учир дутагдалтай. Өөрөөр хэлбэл боломжгүй байгаа юм.

ХАА-н газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн доройтол, хүнсний аюулгүй байдал, ХАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх иргэдийн амьдралын түвшнийг сайжруулахын тулд энэхүү хуулийн төслийг боловсруулаа.

Хуулийн төслийг Хуулийн хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулсан бөгөөд өвөлжөө, хаваржааны газрын эзэмшигч нь өвөлжөө, хаваржааныхаа газарт нэг га хүртэл газарт хэрэгцээнд нь зориулж төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалах боломж бүхий энэ хуулийн зохицуулалтыг оруулж ирж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлцэл шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн  
Ганибалын Амартүвшин,  
Даваажанцангийн Сарангэрэл,

Тогмидын Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна аа. Таныг индэрт урьж байна.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 5 гишүүнээс 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч ХАА-н газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн доройтлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах ХАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын түвшнийг сайжруулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Дээрх хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Parliament.mn цахим сайтад байршуулсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал газар

тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч нарт боломж олгох эсэх, атарисан газруудад хяналт хянан баталгаажуулалт хийж тэдгээр газрын тодорхой хэсэгт ногоон тэжээл тарих нөхцөлийг бүрдүүлэх, газар тариалангийн бүсээ дагуулж эрчимжсэн МАА-г уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат өвөлжөө хаваржаандаа гэр бүлийн хэрэгцээнд зориулж олон наст ургамал тарих нь яваандаа газрыг хаших асуудал үүснэ. Энэ нь хэр боломжтой эсэх малчдын бэлчээртэй хэрхэн уялдах талаар асуулт асууж, хариулт авсан болно оо.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун өвөлжөө, хаваржаандаа төмс, хүнсний ногоо, таримал ургамал тариалах иргэдийн эрх үүргийг төсөлд тодорхой тусгаж өгөх, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир бэлчээр хашаажуулах асуудлыг хэлэлцүүлгийн явцад нухацтай ярилцах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бусад Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй нэгтгэн хэлэлцүүлэх талаар санал хэлсэн болно оо.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай ас хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 54.5 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тухай хуульд нэмэлт, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүх бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Наранбаатар гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, Газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Эрдэнэбатын Батболд, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Хууль хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Дэндэвийн Энхтуяа нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Туваан гишүүн, Наранбаатар гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн асуултаа асууя.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа.

Газрын тухай хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлт бол 29 дүгээр зүйлд орж байгаа л нэмэлт, өөрчлөлт юм байна. Зөвхөн нөгөө гэр бүлийн зориулалттай өвөлжөө хаваржааны зориулалттай газрын хэмжээг

нэмэгдүүлж түүндээ төмс, хүнсний ногоо малын тэжээлийн ургамал тариалах ийм бололцоог гаргаж өгч байгаа юм байна гэж ойлгож байна.

Би хуулийн төсөлтэй холбогдуулаад нэг хэдэн саналаа хэлье гэж бодож байгаа юм аа. Ерөнхийд нь хуулийн төслийг дэмжиж байгаа юм аа. 3 зүйлийг энэ дээр хэлэлцүүлгийн явцад хориглох ёстой гэж ингээж бодож байгаа юм. Нэгдүгээрт бол энэ өвөлжөө, хаваржаа гэдгийг бол нэг цэг дээр нь л зөвшөөрмөөр байдаг юм аа. Өвөлжөө хаваржаа гээд хоёуланд нь тариалаад тариалж байгаа нэрийн доор хамгийн манай иргэдийн хамгийн их болгоомжилдог юм бол энэ бэлчээрийг хашихыг болгоомжилж байдаг байхгүй юу. БНХАУ-ын ӨМӨЗО бол хашаалсан явдал нь бэлчээрийн МАА-д тохиромжгүй болсон гэж ийм дүгнэлт гардаг байхгүй юу.

Тийм учраас бол би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр зөвхөн өвөлжөөнийхөө хэсэг дээр малын тэжээлийн ургамалд төмс хүнсний ногоо тариалахыг зөвшөөрдөг ч юм уу нэг цэг дээр нь. Тэрнээс хоёуланд нь ингээд өвөлжөө хаваржаанд нь тариалаад байвал энэ дэндүү өргөн газрыг хаших болно оо. Ингээж хязгаарлаж өгөх ёстой гэж хэлж байгаа юм.

Хоёр дахь юм бол боломж байвал хашаалахгүй байх чиглэл рүү явуулах ёстой юм. Хашаалахгүй байх чиглэл рүү.

3 дахь асуудал юу байна вэ гэхээр энэ хууль дээр ороод ирчихсэн иргэнд гэж байгаа юм. Иргэнд хэрэв бид нар 1.5 га газрыг өвөлжөө хаваржааны зориулалтаар өгнө гэвэл энэ Монгол Улсын бараг бүх нутаг дэвсгэр багтахгүй.

Тийм учраас энийг хэлэлцүүлгийн явцад өрх олгох ёстой, өрхийн хүрээнд. Өвөлжөө хаваржааг нь хязгаарлах хэрэгтэй. Манай малчид зарим малчин бол 2-оос 3 өвөлжөөтэй. Өвөлжөөгөө түрээсэлдэг ийм тохиолдлууд байгаа юм.

Тийм учраас нэг гэдгээ заавал хязгаарлах ёстой. Ийм нарийн нарийн зохицуулалтыг би хэлэлцүүлгийн явцад хийх шаардлагатай байна гэж ингээж үзэж байгаа юм. Зүгээр ажлын хэсэг энэ дээр санал хууль санаачлагч бас ямар саналтай байгаа вэ саналаа хэлнэ биз гэж бодож байна.

Хуулийг бол дэмжээд Их Хурал дээр өргөн баригдсан ажлын хэсэг гараад Тэмүүлэн даргаар ахлуулсан ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Газрын хуультай нэгтгээд Газрын хуулийн өөрчлөлттэй нэгтгээд ингээд гаргаад явахад болохгүй юм байхгүй юм. Хоёр л юмыг л хэлье. Иргэдэд нэг аягүй буруу ойлголт төрөөд байгаа юм. 1.5 га газрыг нэг удаа өвөлжөөний хаваржааны зориулалттай төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн ургамал тариалах зориулалтаар олгож байна гэхихтэй нь зэрэг л хаширч байгаа юм байна гээд л ингээд л тэгээд болгоомжлоод эхэлж байгаа байхгүй юу.

Тийм учраас газрын хууль дээр бол үнэхээр болгоомжилдог. Гэхдээ зохицуулалтыг их нарийн нэг бүрчлэн хийж байж бид нар энэ бэлчээрийн асуудал дээрт зохицуулалт хийж болох юм. Тэрнээс ерөнхий хийх юм бол энэ болохгүй юм шүү гэдгийг би зориуд хэлье гэж бодож байгаа юм. Баярлалаа. Тэгээд хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Тогтохсүрэн гишүүн дэмжиж үг хэллээ.

Гэхдээ их тодорхой хэдэн саналууд хэлсэн. Хууль санаачлагчийн зүгээс дараа нь нэгтгээд хариулчихгүй юу даа? Өнөөдөр хэлэлцэх эсэхийг ярьж байгаа. Хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа ажлын хэсэг байгуулагдаад анхны хэлэлцүүлэг хийнэ. Тэр үед Тогтохсүрэн гишүүний тавьсан 3 асуудлыг анхаарч үзэх боломж бас байгаа гэдгийг хэлье. Хууль санаачлагч Бат-Эрдэнэ хариулья.

Жадамбын Бат-Эрдэнэ  
гишүүний микрофоныг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тогтохсүрэн гишүүн хуулийг ерөнхийд нь бол дэмжиж байгаа юм байна. Тэгээд үнэхээр бас жоохон анхаарахгүй зүйлүүд анхаарах нь зүйтэй байх гэсэн ганц 2 зүйлүүдийг хэлж байгаа юм.

Нэгдүгээрт бол өвөлжөө хаваржааны аль нэг дээр нь гэсэн ийм санал бас оруулах гээд. Бид яах вэ тухайн үед бол ярилцаж байсан юм. Аль нэг дээр нь шүү гэсэн байдалтай. Гэхдээ хуульд бол нэг га газар Газрын тухай хуульд өөрөө бол өвөлжөө хаваржааны зориулалттай газар эзэмшиж буй иргэн эзэмшлийн нэг га газартаа гэр бүлийн хэрэгцээнд гэдэг чинь өөрөө аль нэгэнд байх юм шүү дээ гэсэн ийм ойлголтыг төрүүлнэ гэсэн нэг ийм газрынхантай ярьж байхад бол албаны хүмүүстэй ярьж байхад ийм зүйл хэлж байсан юм. Тэгээд гэхдээ энийгээ бол бас хэлэлцүүлэх явцад ажлын хэсэг гарах байх. Энэ ажлын хэсэг дээр засаад явах байх. Ер нь зүгээр миний өөрийн бодол бол аль нэг дээр нь гэж бас бодож байгаа юм. Тийм.

Хоёрдугаарт бэлчээр хашихтай холбоотой манай малчид маш их эмзэг байгаа. Энэ бол бэлчээр хаших асуудал биш. Бэлчээр хаших асуудал биш. Угаасаа бэлчээр хомсдолтой байгаа ийм

нөхцөл байдал харин өвөлжөө хаваржааныхаа газарт нөгөө нэг шарилжинд идэгдээд байдаг халгай шарилжаар дүүрчихсэн байдаг. тэгээд хашааныхаа хөлд бууц бас хаягдлаа хаячихсан байдаг жорлон бас аж ахуйн хашаанууд барьчихсан тугалын хашаа гэх мэтчилэн ийм хашаа барьчихсан байдаг. Ийм газраа ашиглаад өөрөөр хэлбэл өнөөдөр бол малчид маань 0.5 га дунджаар бол 0.5 га дээр байгаа шүү дээ. Эзэмшиж байгаа.

Тэгэхээр энэ дээр нь нэг гаг нь өгье. Тэр хаягдсан байгаа, тэр шарилж ургачихсан байдаг энэ талбайгаа л ерөөсөө өвөлжөө хаваржаанаасаа цаашаагаа нэмэгдээд л нэг өвөлжөө хаваржаа эзэмших газар чинь өөрөө 1.5 га байя. Одоо эзэмшиж байгаа 0.5 дээрээ нэг гаг нэмье. Тэр нэг га-гаа ямар нэгэн байдлаар ашиглаач. Одоо энэ төмс, хүнсний ногоо тэгээд таримал ургамал өөрөөр хэлбэл хамгийн гол нь бид нарт бол таримал ургамлаа тарих нь бол маш чухал болчихоод байгаа шүү дээ.

Тэгээд бэлчээр бол хашаалахгүй. Хашаалахгүй байх гэдэг дээр бол яах вэ мэдээж өөрсдийн эзэмшлийн өөрөө эзэмшиж байгаа амьдарч байгаа өвөлжөө хаваржаа гэдэг бол бас тодорхой хэмжээний малын хашаа энээ тэрээ байгаа шүү дээ. Тэгэхээр малын хашаагаа л цаашаагаа дахиад нэг хашаалчхаж байгаа болохоос биш тэнд очиж нэг тийм га газар эзэмшээд, га газар хагалаад тэгээд тэрийгээ хагалаад байгаа асуудал биш юм гэдэг ийм тайлбар хэлье ээ.

Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Зочин  
танилцуулъя аа.

Нийслэлийн 297 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөрт нь хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе өө.

Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьшаа:** Энэ Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын Бат-Эрдэнэ нарын өргөн барьсан энэ хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд бол хэлэлцэхийг дэмжиж байгаа юм.

Энэ бол бас цаг үеэ олсон ялангуяа энэ газар тариалангийн салбар дамжиж жижиг дунд бизнес эрхлэх орлогоо нэмэгдүүлэх түүнчлэн энэ хөрсний бохирдол агаар цөлжилтөөс хамгаалах ч гэсэн энэ тодорхой хэмжээний үр дүнгээ өгсөн ийм цаг үеэ олсон хууль гэж ойлгож байгаа. Ийм учраас би энийг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ дээр бол бас энэ хэлэлцүүлгийн явцад түрүүн Тогтохсүрэн гишүүн хэлсэн. Тогтохсүрэн гишүүнтэй санал нэг байгаа. Өрх гэдэг үгийг зайлиггүй оруулах ёстой. Тэрнээс биш нэг ам бүлтэй айл нэг га авахад 5 ам бүлтэй айл 5 га авна л гэх юм бол энэ чинь асуудал үүснэ.

Хоёрдугаарт энэ хашаална, хашаалахгүй гэдэг асуудлыг энэ хуульд ингэж зааж өгсөн үр дүн бас их буруу зүйл бас харагдаж болзошгүй байгаа шүү. Өнөөдөр үнэхээр тэр малчид өвөлжөө хаваржааны дэргэд хүнсний болон бусад ургамал тэжээл тарих гэж байгаа юм бол хашаалахгүй бол яаж энэ ургамал тэжээлээ хамгаалах юм. Энэ болохгүй асуудал байна шүү дээ.

Өнөөдөр тэрийг хашаалж болохгүй гээд тэр чинь нөгөө газар тариалан, хүнс ногоо, малын тэжээл тарь тарих боломж байхгүй шүү дээ. Ийм учраас тэр хашаална, хашаалахгүй гэдэг юмыг нь тавьж болохгүй. Хашаалах ёстой гэдэг ийм боломжийг нь энэ хуулиар нээж өгөх ёстой шүү гэдэг ийм байр суурьтай байна.

Дээр нь бол ингээд энэ Монгол Улсын хэмжээнд энэ хууль чинь мөрдөгдөх ёстой. Монгол Улсын хэмжээнд хэрэгжих ёстой. Өвөлжөө хаваржаагүй ийм иргэд энэ газар эзэмших ийм хүсэлт гаргавал яах вэ гэдэг энэ шийдлийг энэ хууль тогтоогчид хуулийн төсөл өргөн барьсан хүмүүс ямар ойлголттой байна. Энэ талаар нэг хариулт авъя л гэсэн ийм бодолтой байна.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн гишүүдээс бас хариулж болно. Гэхдээ яах вэ энэ хуулийн төслийн хувьд бас хэд хэдэн төслүүдээс бас ялгаатай гэдгийг нь бас хэлэхгүй болохгүй юм шиг байгаа юм. Энэ Бат-Эрдэнэ нарын 5 гишүүний санаачилсан энэ хуулийн төсөл бол ерөөсөө малчдад өвөлжөө хаваржаандаа 1.5 га газарт өвөлжөө, хаваржаанаас 200 метрийн радиусын дотор жимс жимсгэнэ, хүнсний ногоо, таримал ургамал буюу нөгөө ногоон тэжээлээ тарих боломжийг нь л олгох талаар яасан хоёрхон заалттай ийм хууль байгаа юм.

Гэтэл энэнээс гадна бас нэг бэлчээрийн тухай, бэлчээрийн асуудлыг зохицуулсан газрын хуульд оруулж байгаа бас томоохон өөрчлөлт байгаа. Энэ бол Тогтохсүрэн дарга санаачилсан гишүүдийн санаачилсан хууль байгаа. Нөгөө нэг хууль нь бол Хөрөнгө оруулалтын хуультай холбогдуулаад санаачилсан бас хуулиуд байгаа. Эдгээр 3 өөр хууль байгаа шүү гэдгийг бол хэлэх

нь зүйтэй. Энэ бол нь малчдынхаа ногоон тэжээлээ тарих жимс хүнсний ногоогоор тарих боломжийг нь л хангахад одоо зориулагдсан ийм хуулийн төсөл байгаа шүү гэдгийг бас онцолж хэлье.

Ажлын хэсгийн гишүүн, хууль санаачлагч хууль санаачлагч Ганибал асуултад хариулъя.

**Н.Ганибал:** Адьшаа гишүүний асуултад хариулъя.

Ер нь өнөөдөр бэлчээрийн МАА дээр тулгамдаж байгаа хэд хэдэн асуудлууд байгаа. Энэний хариулт болгоод энэ хуулийг санаачлан өргөн барьсан байгаа.

Ер нь манай бүс нутгаар нь харах юм бол хээр талд зайлиггүй тодорхой хэмжээнд хавар төллөх малаа эхтэй нь оруулчих бага хэмжээний хагсан бэлчээр нь хамгаалагдсан талбай зайлиггүй хэрэгтэй болж байна аа. Энийг бол өнгөрсөн жил бид бүхэн бас тал хээрийн бүс нутаг говийнхон маань амьдрал дээрээ тууллаа харлаа. Яагаад гэхээрээ жижиг жижиг умгар хонины хашаан дотор малаа бөөнөөр нь хагсанаас болоод хаврын шуурганд малаа цасанд даруулсан ийм асуудал үүссэн. Энэнээс л гарах гэсэн гол бас ийм зарчмын ойлголт байгаа л даа энэ дээр. Тэгэхээр энэ дээр нэг га гэдэг нь хангалттай тэрийгээ бас бэлчээрийг нь хамгаалсан зайлиггүй байх ёстой.

Ингээд хамгаалж байж тэнд бас малаа оруулаад орсон мал маань шуурганд дарагдахгүйгээр тодорхой хэмжээнд байгалийн эрсдэлтэй өдрүүд хоногуудыг шуургыг даван туулах ийм боломжоор нээгдэж байгаа юм.

Тариалангийн бүс нутагт мэдээж манай малчид маань бас хөрс нь

сайхан учраас тэрэн дээр ногоо жимс, жимсгэнэ тариад эндээсээ бас өрх өөрөө үйлдвэрлэгч болоод өөрийнхөө өрхийн хэрэгцээг хангах ийм боломжоор хангагдаж байгаа юм. Тэгэхээр энэ бүгдийг л шийдсэн ийм шийдэл байгаа юм. Ер нь зүгээр манай хангайн бүсийн Архангай, Өвөрхангайн аймгуудын сумдууд, малчид маань яг энийг бодит амьдрал дээр хэрэгжүүлээд эхэлчихсэн. Энийг нь албан ёсны хуулийн боломжоор л нээж өгч байгаа л асуудал байхгүй юу тийм ээ. Одоо энэ хэрэгжээд эхэлчихсэн асуудал. Тэгэхээр хүн энийгээ бодит хуулиараа, энэ хуулиар энийгээ баталгаажуулж авч байгаа л асуудал. Ийм байдлаар л асуудалд хандаж байгаа. Энэ зүгээр Монгол Улсын иргэн болон Улаанбаатар хотод 0.07 гэдэг юм уу сумын төв дээр бүгдээрээ ингээд иргэд маань бүгд газартай болсон.

Малчид маань яг өөрсдийнхөө хэрэгцээнд хуулийн дагуу хэрэглэдэг газар гэж байхгүй байгаа. Зөвхөн өвөлжөөний хаваржааны байшин барилгын доод тал газраа л гэдэг асуудал байгаа. Энэ нь хүртэл тодорхойгүй явж байгааг бодит болгож өөрийнхөө хэрэгцээнд хэрэглэж болох ийм байдлаар асуудлыг хангаж байгаа. Тэгээд Адьшаа гишүүний хэлж байгаа ногоо тарьж байгаад бэлчээрийг хамгаалах энэ тохиолдолд бол мэдээж хашина, хаших л ёстой л доо тэгээд энэ чинь нэг га гэдэг маань хүмүүсийн ойлголтод буруугаар ойлгуулаад байгаа нь нийт бэлчээрийг юу гэдэг юм 50, 60 мянган га-гаар нь хаших гэж байгаа юм шиг ойлголтыг өгөөд байгаа л даа. Энэ нь өөрөө буруу ойлголт. Энэ өөрөө нэг га-гийн хэмжээнд буюу сумын төвийн хашаанаас 2 дахин том газрын л тухай л ойлголт шүү дээ. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Наянтайн Ганибал гишүүн бас их тодорхой хариуллаа. Энэ Адьшаа гишүүн ийм юм

байна. Одоо яах вэ бодит байдал дээрээ өвөлжөө хаваржаан дээрээ ингээд тодорхой ногоон тэжээл ингээд жишээлбэл тариад байдаг. Гэтэл энэ өөрөө Тариалангийн тухай хуулийг зөрчөөд байгаа, зөрчөөд байгаа юм. Яагаад гэвэл Тариалангийн тухай хуулиар атар газрыг чинь эзэмших асуудал бол Засгийн газрын тогтоолоор ингээд шийдвэрлэгддэг тоо хэмжээ хязгаарыг нь зааж өгдөг. Гэтэл одоо бодит байдал дээр ингээд яваад байгаа.

Тийм учраас энийг л өөрийг нь бас хуулийн дагуу болгож хуульчилж өгөх гэсэн энэ санааг сая Ганибал гишүүн хариулж байгаа юм. Ингээд цаашаа явах уу? Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлье.

**Ц.Туваан:** Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Тэгэхдээ 1 зүйл байна. Энэ газар гэдэг бол бид нарын амьдарч байгаа Монгол Улсын хилийн дотор байгаа энэ бүх 1 сая 565 мянган км квадрат газар. Тэгээд энэнтэй холбоотой маш олон тусдаа жижиг жижиг энэ хуулиуд орж ирээд байна тийм. Тэгээд л энэ дотор чинь энэ Гаднын хөрөнгө оруулалтын тухай хууль дотор ингээд л газрын асуудал орж ирж байна. Тэгээд тэр нөгөө бэлчээрийн асуудал зохицуулах Тогтохсүрэн даргын ярьж байгаа тэр хууль орж ирж байна. Дахиад энэ нийслэлийн энэ утаа түгжрэлтэй холбоотой асуудал дээр ч газар орж ирж байна.

Ахиад өнөөдөр энэ Газрын тухай хууль гээд. Ингээд энэ Газрын тухай хууль чинь ингээд нэг ийм олон газар сэглэгдсэн байдалтай ингэж яваад байна. Тэгэхээр энэн дээр Улсын Их Хурал ер нь анхаараад энийгээ нэг ажлын хэсэг гарвал нэгдмэл байдлаар энэ чинь Газрын зургууд чинь бүгдээрээ

дээр дээрээсээ ингээд калькан цаас шиг давхарлагдаад л явж байгаад л давхцал энэ тэр зөндөөтэй л ийм л асуудал шүү дээ.

Тэгэхээр энийг яагаад нэгдмэл байдлаар ингэж харахгүй байгаа юм бэ? Ийм цаг нь болчихсон юм биш үү гэдэг нэг ийм зүйлийг хэлье.

Мөнхбаатар дарга бас саналаа хэлчихнэ биз.

Хоёрдугаарт, нь энэ өвөлжөө хаваржааны газар гээд. Энэ бодитой. Одоо энэ нэг га гээд л. Би энэ ажлын хэсэг энэ тэр дээр нь Байнгын хороо энэ тэр дээр хэлнэ. Нэг га бол бага байна. Яг ний нуугүй хэлэхэд бага байна. Хоёрын хооронд байна. Жишээлэх юм бол иргэнд 0.1 га төмс, хүнсний ногоо гэж ярьчихаад, дээрээс нь газар тариалангийн салбарт олон жил ажилласан хүнд 5 хүртэл га гэж ярьчихаад. Малчдад болохоор аль нэг газарт нь тэгээд бүүр гэр бүлийн хэрэгцээнд нь нэг га гэдэг бол бага байна. Энэ дээр юу ч хийж болохгүй. Нэг га-тай хүн яах юм. Уулын мухарт техник түрээсэлж очоод ногоон тэжээл тарих юм уу яах юм. Ядаж 3 га энэ тэр байвал 2-ыг нь өөртөө хэрэглэхээд нэгийг нь борлуулчихдаг ч юм уу иймэрхүү асуудлууд үүснэ ээ.

Дээрээс нь энэ нөгөө хадлангийн газрууд гээд хүмүүс энд тэнд хашиж байгаа. Энэ дээр энэ хууль санаачлагчид ер нь ямар бодолтой байна аа. Энэ хадлангийн газар бэлчээрээ хадлангаа хамгаалах гээд тэртээ тэргүй энд тэнд явж байхад талбайнуудыг хашаад эхэлчихсэн. Энэ эрх зүйн асуудал юу байна.

Энэ дээр нэг хууль санаачлагч нэг хэлээд өгөөч. Энэ юунууд өвөлжөө хаваржаан дээр бас нэг асуудал үүсэж



байгаа юм. Юу вэ гэхлээр эзэмшиж байгаад энэ хүмүүс чинь өөрөө зөвхөн өвөлжөөнийх нь доод талын газар, гэрийн буйрных нь доод талын газар л орж байгаа. Уяа тэр юу байдаг юм жорлонгийн асуудал энэ тэр ч гэсэн тэр эзэмшлийн талбайдаа орохгүй л байгаа асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээр нэг миний түрүүний хэлсэн тэр нэгдмэл байдлаар энд нь хандаж нэг Газрын тухай хуульдаа нэгдмэл байдлаар хандаж энэ зохицуулалтыг нь хийж өгөхгүй бол бас болохгүй байгаа. Тэгээд орон нутагт энэ өвөлжөө хаваржаатай холбоотой асуудал дээр эзэмшиж байгаад л тэгээд цааш нь эзэмилээ шилжүүлэх нэрээр зарж борлуулж байгаа асуудал ч гэсэн нэлээн хавтгайрчихсан байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлыг энэ тэр гээд ер нь бол миний санал зөвхөн ингээд жижиг жижиг зохицуулалтуудаар нь биш ер нь газрын асуудлуудыг нь яримаар байгаа юм. Хөдөө орон нутаг дээр энэ зөвшөөрөлгүй атар газрыг тариалангийн тухай хуулийн 5.5-аар хязгаарласан л гээд байгаа юм. Зөндөө л хагалж байгаа шүү дээ. Ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй. Тэгээд л зарим нэг баг сумын дарга нь ойр орчны иргэд нь нэг тухайн үедээ нэг жоохон гомдоллож байгаад л ингээд өнгөрчхөөд байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг ч гэсэн бас энэ энэ хуулийг дагаж энэ тариалангийн тухай хуульд өөрчлөлт орж ирж байгаа юм байна. Тэгэхээр энэ асуудлыг ч гэсэн асуудал дээр ямар хууль санаачлагчид маань байр суурьтай байгаа юм бэ гэдгийг тодруулъя.

**Л.Мөнхбаатар:** Хууль санаачлагчийн хувьд Бат-Эрдэнэ гишүүн хариулна.

Гэхдээ Туваан гишүүн бас сая хандаж асуусан учраас бас хэлье. Ер нь энэ өвөлжөө, хаваржааны газрынхаа яг ойролцоо буюу 200 метрийн радиусаас илүүгүй газар эдгээр газар олгоё гэж байгаа юм. Тэгэхгүй бол энд тэндгүй өвөлжөө хаваржаа гэж нэрлээд тэрнийхээ ойролцоо энд тэндгүй хэрвээ газар хагалаад ирэх юм бол нөгөө бэлчээрийн асуудал чинь хүнд болно. Түрүүн Тогтохсүрэн дарга бас харуулж хэлээд байгаа тэр зүйлүүд рүүгээ орох юм.

Тийм учраас тодорхой радиусыг нь зааж өгье гэсэн нэг агуулга байгаа юм. Нөгөөтээгүүр энэ газар тариалангийн энэ бүс нутагт бэлчээрийн МАА газар тариалангийн эрхэлж байгаа хүмүүсийн хооронд их томоохон зөрчил үүсдэг. Энэ бол ерөөсөө маш төвөгтэй байдлуудыг үүсгээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг ийм зүйл баймаар юм байна лээ Туваан гишүүн ээ.

Ерөөсөө мэдээж бэлчээрийн МАА чинь тариалан руу нь ороод байдаг энэ асуудлаа шийдэхийн тулд нэг тодорхой гарцуудад нь бас дэмжлэг үзүүлмээр юм шиг байгаа юм. Яагаад вэ гэхээр атар тодорхой газрыг хагалах, эзэмших, ногоон тэжээл тарих асуудлуудыг тухайн багийнх нь гэдэг юм уу, сум багийнх нь хэсэг хэсэг айлуудынх нь малчдынх нь асуудлыг ногоон тэжээлээр нь хангах таримал ургамлаар ингээд хангах асуудлуудыг нь нэг мөр олгох асуудал байгаа юм. Энийг Засгийн газраар хэмжээ хязгаарыг нь тогтоодог. Энэ дээр нь бүүр тусгайлан зааж өгөхгүй бол дуудлага худалдаагаар явна л гэх юм бол тариалан эрхэлж байгаа хүмүүс тэрнийхээ хэмжээгээ нэмээд л яваад байгаа юм. Өөрсдөө нэмээд. Малчдад очихгүй.

Тийм учраас энэ дээр нь тусгайлсан байдлаар ийм зохицуулалт хийгээд өгөх юм бол бас энэ газар тариалан эрхэлж байгаа бэлчээрийн МАА эрхэлж байгаа малчдын маань хоорондын зөрчил бас арилгах эдгээр асуудлуудад тариалан эрхэлж байгаа хүмүүс нь техник хэрэгслээрээ тусалдаг. Ингээд бас нэг юуны бэлчээрийн аж ахуй, МАА-гаа ч аваад явдаг. Тариалан эрхэлж байгаа хүмүүс маань ч гэсэн үйл ажиллагаа явуулдаг энэ тал руугаа явах нь зүйтэй юм байна лээ гэдгийг хэлье.

Одоо ингээд хууль санаачлагч Жадамбын Бат-Эрдэнэ нэмж хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ хуулийг миний бие тэгээд Мөнхбаатар, Тэмүүлэн, Ганибал, Ундрам гишүүд хамтарч санаачилсан юм аа. Тэгээд Мөнхбаатар гишүүн бас нэлээн дарга тодорхой бас хариулт өгчих шиг боллоо. Ер нь бол энэ Туваан гишүүний хэлсэнчлэн яг амьдрал дээр бол бид нар зөвхөн тэр нэг гэрийн буурь тэгээд нэг байшин бол байшин. Тэгээд хажууд нь байгаа тэр нэг өвөлжөө хаваржаа, энэнийхээ кадастраар л явж байгаа шүү дээ. Тэгээд үндсэндээ бол бид нар бол өвөлжөө, хаваржааны газар бол тэнд очоод нэг жорлон, тээр тэнд очоод хогоо асгачихсан, тэнд очоод нэг тугалын хашаа, тэнд очоод нэг бууц юмаа асгачихсан гээд ингээд үндсэндээ бол бид нар чинь бараг л ч 1.5 битгий хэл газрыг малчид маань эзэмшээд байгаа шүү дээ.

Тэр ойролцоо хэн ч очиж буухгүй, хаяа дэрлэж хэн ч очихгүй. Тэгэхээр энд хуулийн төсөл бол үндсэндээ ерөөсөө одоо байгаа газраа бол нэгдүгээрт баталгаажуулаад авчихъя. Өвөлжөө хаваржаагаа ер нь кадастраар эзэмшилд хийсэн кадастрыг нь авсан, хийлгэсэн газар өрх малчид бол ховор

байгаа. Тэгэхээр нэг мөр ерөөсөө 1.5 га гэдгээр өвөлжөө хаваржааг нь ерөөсөө томсгоод өгчихье гээд.

Хоёрдугаарт бол ерөөсөө Ганибал гишүүний хэлсэнчлэн үнэхээр нэг өмгөр хашаан дотор бол тэр малаа даруулаад цасанд даруулаад байгаа ч асуудал байгаад байгаа шүү дээ. Нөгөөтэйгүүр ХАА-н бодлогын хувьд бид нар чинь эрчимжсэн мал аж ахуй руу очих гээд байгаа биз дээ. Энийг чинь сүүлийн 20, 30 жил л ярилаа шүү дээ.

Тэгэхээр эрчимжсэн МАА руу очих гэж байгаа бол тэр МАА эрхэлж байгаа хүмүүс чинь нэг өмх газраа эзэмшээд олигтойхон шиг бас тэнтэй суурьшаад суурин бий болгоод, яваандаа суурин бий болгож байгаа бол өвөлжөө хаваржааны аль нэг газар дээрээ л бид нар суурин бий болно. Тэнд малын аятайхан хашаатай байх хэрэгтэй болно. Аятайхан худаг усаа гаргах хэрэгтэй болно, тог цахилгаан татах хэрэгтэй болно.

Тэгэхээр тэнд өвөлжөө хаваржааныхаа ойролцоо байж байгаад хог бууцаа асгачихсан байгаа газраа ашиглаад тэрийгээ нэг га болгож аваад өвөлжөөтэйгөө нийлүүлээд хаяа дэрлүүлээд, тэгээд тэрийгээ зохих хэмжээнд нь бол хагалаад сайхан эзэмшээд ногоон тэжээл тарих ийм боломж бололцоог нь л олгоё гэж байгаа шүү дээ. Хамгийн гол нь энэ дээр бас ногоон тэжээлээс гадна тэр төмс хүнсний ногоог нь оруулчихъя л даа тийм биз дээ. Төмс төмсний ногоог нь оруулчихъя жимс жимсгэнэ гэсэн үг үсгийг нь оруулчихъя заавал тэрийг боогоод ногоон тэжээл гээд ингээд боомлоод байж яах вэ.

Тэгэхээр энэ талаар нь оруулчихаж байгаа юм. Тэгээд Газрын тухай хууль бол мэдээж бид нар

хэлэлцэхдээ бол нэгтгээд бол оруулчих байх аа. Ер нь бол Засгийн газраас дахин өргөн барихдаа бол Газрын тухай хуулийг бүгд том хэмжээгээр нь оруулж ирье гэж байгаа. Тэгэхдээ Улсын Их Хурал дээр гарч байгаа Тогтохсүрэн гишүүний л санаачилсан бас нэг Газрын тухай хууль байж байгаа. Хориод гишүүн бас оролцсон байгаа. Энэ хуультайгаа бол нэгтгээд ингээд хэлэлцээд явах нь зүйтэй байх гэж бодож байгаа юм. Тэр хашаалахын хувьд бол мэдээж бэлчээр хашаалах эсвэл энэ хадлангийн газар хашаалах гэдэг чинь бол арай ондоо том асуудал шүү дээ. Энэ дээр бол бид нар тийм том бодлого гаргаж бол болохгүй гэж бодож байгаа.

Бэлчээрийг хашаалж болохгүй, хадлангийн газар хашаалж болохгүй гэж бодож байгаа. Энэ бол зөвхөн өвөлжөө хаваржаа дээрх газраа л хашаалъя гэсэн асуудал л яригдаж байгаа юм шүү.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.

Тэгэхээр хуулийг үзэл баримтлалынх нь хувьд хэлэлцэхийг дэмжье.

Гэхдээ бидэнд хэлэлцүүлгийн явцад анхаармаар зүйлүүд байгаад байгаа юм байна лээ. Энэ уламжлалт харилцааг эрх зүйн харилцаа болгож оруулж ирж байгаа явдал л даа эд ер нь. Тийм учраас нэр томъёоллынхоо хувьд ч гэсэн бас бодмоор эргэж хармаар зүйлүүд нэлээдгүй байгаа. Тэр өвөлжөө хаваржааны газрыг зөвхөн малчид мал бүхий иргэдэд л өгнө. Энэ үгээ тодотгохгүй бол болохгүй болчихоод

байгаа юм. Иргэд гээд хэлчих юм бол энэ чинь болохгүй болчихоод байгаа юм.

Хоёр дахь зүйл. Энэ өвөлжөө, хаваржаан дээр таримал ургамал тарих асуудал өөрөө өвөлжөөний хөл гэж Монголчуудын уламжлалт хэллэгээрээ. Үндсэндээ малын өтөг бууц малын хөлөөр газрынхаа релефийг дагаж тогтож байгаа үүсмэл хөрс байхгүй юу. Энэ бууцны хөл гэдэг бол. Энэ дээр таримал ургамал ургах бололцоо нь байгаа. Энийг тариад, ургуулаад, аваад өөрсдийнхөө амьдрал ахуй аж ахуйдаа хэрэглээд байгаа улсууд байгаа. Энийг л бид эрх зүйн хувьд зохицуулж өгөх гэж яваад байгаа зүйл ээ. Тэнд учиргүй газар хагалалт атар хагалалт энэ тэр байдаггүй угаасаа бууцаа өөрийг нь сийрэгжүүлээд л үрээ цацаад л ингээд л угаасаа ногоон тэжээлээ тарьчихдаг ийм л юм бид нар тарьж бас үзсэн л улсууд.

Тэгэхээр энийг нэлээн тийм зөв өнгө байдлаар нь зохицуулж шийдэх ёстой асуудал байна. Орж ирсэн төсөл дээр бол юу орж ирээд байгаа юм байна лээ. Таримлын нэр төрлүүд орж ирээд байгаа юм байна лээ. Тэгэхээр хэрвээ үнэхээрийн таримал ургамал тарихыг нь зөвшөөрч байгаа бол ер нь таримал ургамал тарих гэдэг байдлаар нь хэлчихсэн нь дээр байх аа. Нэр усаар нь явчихаар зэрэг тэрэнд ороогүй нь хуулиараа хязгаарлагдах гээд ч байгаа юм шиг ийм юм болчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг төмс хүнсний ногоо тарьж болдог юм байж. Тэгээд ногоон тэжээл тарьж болдог юм байж. Өөр тарьж болдог юм байвал тарина шүү дээ тэр улсууд чинь. Тэгэхээр зэрэг тэрүүнийг нь хаамгүй байна гэж нэг ийм зүйл хэлмээр байна.

Хадлангийн газар гэдэг газрын нэгдмэл сангийн ангилал дотроо бүүр тов тодорхой заагдсан газар байдаг аа.

Тийм учраас тэр газрыг бид нар энэ орж ирж байгаа хуулийн төсөлтэй уялдуулж хөндөж болохгүй. Энэ бол тэр тусгай зохицуулалтаараа явдаг ийм зүйл гэж. Тариалангийн хуульд бол тодорхой энэ хуулийг дагуулж хөндөж байгаа асуудал байгаа юм байна лээ. Одоо өнөөдөр тариалангийн хуулиар 5 га-аас дээш хэмжээний атар хагалах гэж байгаа бол Засгийн газрын шийдвэрээр хагалдаг ийм тов тодорхой хуулийн зохицуулалттай. Энэн дотроо бол орон нутгийнх нь шийдэл юмнуудаараа асуудлаа зохицуулаад явдаг. Газар тариалангийнхаа бүстэй эрчимжсэн МАА-н үйлдвэрлэлээ хослуулах тухай л асуудал бидэнд байгаад байгаа.

Тийм учраас тариалангийн хуулийг энэ хөндөж байгаа сэдэв, асуудал дээрээ эрчимжсэн МАА-н хослолоо яаж авч явах вэ гэдэг заалтаа харин зөв зохицуулсан байдлаар тодотгох нь би зөв болов уу. Энийг хэлэлцүүлгийн түвшинд эргэж харах ёстой байх гэж би ингэж ойлгоод байна. Их Хурал дээр өргөн баригдаад ороод ирчихсэн хэлэлцэх эсэхийг нь дэмжчихсэн хэд хэдэн хуулиуд байгаад байгаа юм аа. Энэ газрын харилцаатай холбоотой. Тогтохсүрэн даргын санаачилсан нэг хуулийн төсөл байгаа. Тэр бол үндсэндээ бэлчээрийн газрын харилцаагаа илүү тодотгож зохицуулсан ийм зүйл байгаа. Тэрэнтэй нь энэ хуулиа нэгтгэж авч үзэж хэлэлцэх нь би зөв болов уу гэж ингэж ойлгож байна.

Тийм учраас ийм байдлаар ойлголцоод ингээд энэ хуулийн.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Хууль санаачлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя, ажлын хэсэг бас нэмж хариулж болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батжаргал гишүүний хэлснээр үнэхээр энэ бид ч бас туршаад яваад байгаа л даа. Одоо жишээ нь хангайн зарим аймгуудад бол нэг битгий хэл га-г хагалаад ингээд таримал ургамал тариалчихсан тэр дотроо бол өөрсдөдөө хэрэглээд үлдсэнийг нь зарим хүмүүстээ зарж борлуулаад ашгаа олоод явж байгаа ч ийм тохиолдлууд байгаа.

Тэгэхээр энийг нөгөө хууль эрх зүйн үндэслэл рүү нь оруулж өгөхгүй бол Тариалангийн тухай хуулиар атар газар эзэмшсэн гэсэн ангилалд ороод энэ хүмүүс чинь бас тодорхой хэмжээний хуулийн хариуцлага хүлээх дээр оччихоод байгаа байхгүй юу. Тийм болохоор одоо бид нар бол ерөөсөө тэнд байгаа нөгөө нэг хашааныхаа хэмжээгээр өвөлжөөнийхөө хэмжээгээр хаваржсааныхаа хэмжээгээр л бид нар кадастр эзэмшиж байгаа болохоор тэрнээс гадагшаа гарахаар л нөгөө атар газар эзэмшсэн гэдэг ангилалд орчихоод тэгээд болохгүй. Хууль эрх зүйн хувьд болохгүй болчихоод байгаа болохоор энийг нь хууль эрх зүй талаас нь бол ингээд засаж өгч байгаа юм аа.

Нөгөөтээгүүр төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ таримал ургамал гээд яагаад ингээд бас нэр төрөл заачихсан юм бэ гэхээр Газрын тухай хуульд угаасаа иргэнд 0.1 га газрыг төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тарих, тарихад эзэмшүүлж болно гэсэн ийм заалт байгаад байгаа юм. Тэгэхээр энийг авчихсан юм. Үгүй яах вэ тэнд чинь бас хүн л амьдарч байгаа юм чинь фермер цаашидаа бол фермер болно л гэж л дүрсэлж хараад байгаа шүү дээ. Бид нар малчдыгаа.

Тэгэхээр тэр дотор заавал таримал ургамал гээд байх юм биш. Нөгөө нэг Газрын тухай хуульд орчихсон

жимс жимсгэнээ тариг л дээ. Нөгөө нэг чацаргана юмнуудаа тариг нэг буланд нь. Эсвэл хүнснийхээ ногоог бас нэг хэсэгт нь тариг. Тэнд чинь нөгөө нэг бид нар чинь жишээ нь хот хөдөөгийн сэргэлт гэсэн нэг том зүйл яриад байгаа шүү дээ. Улсын Их Хурал болоод Засгийн газрын бодлогын хүрээнд. Магадгүй эндээс улсын ерөөсөө Улаанбаатар хотоос очоод тэнд суурьшаад, тэгээд тэнд өөрийнхөө өвөлжсөө хаваржааныхаа газар дээр бас нэг таван төмсөө тариад ингээд амьдрах боломж бололцоогоо нэмэгдүүлээд явах хүмүүс бас үгүйсгэхгүй л байхгүй юу даа. Тэгээд тэр утгаараа бол энэ үг үсгийг нь ингээд оруулчихсан юм.

Тэгээд ажлын хэсгийн явах явц ажлын хэсэг ажиллах явцад бол энэ зүйлүүд дээр бас саналаа хэлээд тэгээд засаад явах боломж бололцоотой гэж үзэж байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах юм байгаа юу гишүүд. Тэгвэл тэрэн дээр нь нэмэлт юу яах уу? Тэгье. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн нэмээд хариулчихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ер нь бол бас орон нутгаар явж байхад 1 дүгээрт дэмжээд байгаа юм. Хоёрдугаарт асууж байгаа асуулт нь бол одоо энийг чинь зараад зарж бариад ингээд явчихвал яах юм бэ. Газрын юугаар уул уурхайн чиглэлээр нэг компани хүрч ирээд худалдаад авчихвал яах юм бэ. Доодхыг нь ухаад хаячихвал яах юм бэ гэсэн нэг ийм юм бас яригдаад байгаа юм. Тэгэхээр таны хэлдэг саналыг бол ажлын хэсэг дээр аваад явчих нь зүйтэй юм шиг байна лээ шүү. Энд бол өвөлжсөө, хаваржаа гэдэг бол малчдадаа л олгогдоно. Мал бүхий иргэндээ л олгогдоно.

Тэгэхээр мал бүхий малчид гэсэн ийм тодорхойлолтыг оруулаад тэд зөвхөн малчдад гэх юм уу тэ. Тэгээд өрхөд нэг байхгүй бол өвөлжсөө хаваржаан дээрээ бүгдэд нь хагалаад байж бас болохгүй болоод. Тийм болохоор тэр малчдад гэдэг үгээ малчин малчин бүхий иргэн гэдэг юм уу тэр мал бүхий иргэн гэхээр чинь бас болохгүй болчихоод байна лээ шүү. Ер нь бол сумдууд дээр хараад байхад бол мал бүхий иргэн чинь өөрсдөө болохоор сумандаа оччихоод малаа бол тэр өвөлжсөө хаваржаан дээрээ өөр хүнээр маллуулаад авхуулчихаад байгаа юм байна лээ.

Тэгэхээр яг малчин гэдэг энэ нэг ойлголтыг энэ дээр бас үг үсгийг нь засаад явах нь бол зүйтэй байх гэж таны саналыг бас энэ дээр нь авъя авъя. Тийм баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Нийслэлийн 297 дугаар цэцэрлэгийн багш ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөрт нь өндөр амжилт, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Гочоогийн Ганболд асуултаа асууя.

**Г.Ганболд:** Говийн болон тал хээрийн манай Өвөрхангай шиг ч юм уу аймгуудын хувьд бол иргэд малынхаа өвөлжсөө хаваржааныхаа хөлд тариалан эрхлэхэд нэг их хуульчлаад байх шаардлагагүй л явж байгаа л даа. Тэгэхдээ энэ хууль өргөн барьсан гишүүд нь энэ Сэлэнгэ, Булган гээд газар тариалан бүхий бүсээс сонгогдсон

гишүүд өргөн барьж байгаа учраас тэнд бол проблем их байдаг юм шиг байна аа. Энийг бол тэгэхдээ хэдүүлээ бас сая гишүүдийн хэлж байгаа саналуудыг харгалзах нь бол зөв. Энэ хуультай харин нэг хууль хамт өргөж орж ирэх ёстой юм байсан юм байна даа гэж би ингэж бодож байгаа юм. Хамгийн гол юм юу гэхээр зэрэг энэ Тусгай хамгаалалттай газар нутагт амьдарч байгаа хөдөөгийн малчин өрхүүд өвөлжөө, хаваржаагаа эзэмшиж болдоггүй.

Тэгэхээр энэ хуульд тэр тусгай хамгаалалттай бүсэд амьдарч байгаа малчдын өвөлжөө хаваржааны газар орох уу? Энийг яг яаж зохицуулах вэ? Ер нь бол хөдөө энэ тусгай хамгаалалттай газар амьдарч байгаа малчдын зүгээс ямар хүсэлт тавьдаг вэ гэхээр зэрэг ядаж энэ нэг өвөлжөө хаваржааныхаа газрыг нэг баталгаажуулж нэг гэрээ гэрчилгээ авах ийм эрх зүйн орчин бүрдүүлж өгөөч гэдэг зүйлийг байнга яриад байгаа юм тэгээд. Энийг энэ хуультай бас тусад нь өргөн бариад хамтатгаад хэлэлцээд явчих ийм боломж байгаа болов уу? Энийг судалсан уу? Энэ дээр бас хууль санаачлагчид болон энэ Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрынхан, Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан ер нь ямар бодолтой байгаа вэ? Энэ асуудлыг яг цэгцлэхгүй бол энэ тусгай хамгаалалттай газар дээр чинь юм тариад байж болохгүй бас төвөгтэй асуудал үүссэн л дээ. Гэтэл тэнд өчнөөн олон хүмүүс өвөлжөө хаваржааны газартай ингээд суурьшмал ингээд ажиллаад амьдраад яваад байдаг. Энийг ер нь яаж зохицуулах вэ?

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Хууль санаачлагч хариулаад дараа нь ажлын хэсэг нэмээд хариулчхаарай. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт

оруулах асуудлыг Засгийн газрын хэмжээнд ямархуу байдлаар авч үзэж байгаа талаар ажлын хэсэг нэмж хариулна шүү.

Хууль санаачлагч Жадамбын Бат-Эрдэнэ асуултад хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ газар тариалантай холбоотой бүс нутгийн гишүүд гээд яг энэ өнцгөөс нь бас харж болохгүй юм аа. Ер нь бид нар чинь энэ газрын элэгдэл, бэлчээрийн элэгдэл тэгээд МАА гээд байгаа. МАА бол Монголын гол үндсэн суурь бол байдгаараа байна шүү дээ. Тэгээд цаашидаа энэ МАА-гаа тэжээх энэ аманд нь хийх өвс тэжээл юм нь олдохгүй болчихоод байгаа шүү дээ. Энэ өнцгөөсөө л хараад байгаа юм аа.

Хамгийн гол нь тэр говийн бүсэд ч гэсэн тэгээд улам л улам л элэгдээд л ургамал тариа авах, хадлан авах ийм боломж бололцоо маань улам л хомсдоод байгаа шүү дээ. Тийм болохоор малынхаа аманд хийх, малаа тэжээх ямар нэгэн байдлаар таримал ургамлаар ургамлаар баяжуулах тэжээлийн ургамал тариалах, малдаа өгөх, малаа тэжээх гэсэн энэ өнцөг бол тэртээ тэргүй цаашидаа бол явна. Малчид бол ер нь энэ рүүгээ их хардаг болчихоод байна шүү дээ. Ер нь бол жоохон тийм суурин маллагаа руугаа орж байж тэжээх, малаа тэжээдэг болгох эд нар гэсэн энэ өнцгөөс нь харж энэ хуулийг бол санаачилж байгаа юм гэж.

Тэгэхээр тусгай хамгаалалттай газар байна уу, хаана байна тэр тухайн хуулийнхаа дагуу Газрын тухай хуулийнхаа дагуу өвөлжөө хаваржааны газрыг сумын иргэдийн хурлаар батлуулаад сумын Засаг дарга олгож байгаа шүү дээ. Тэгээд энэ хуульд бол нэг их хөнддөөгүй явчхаж байгаа юм. Нэгэнт

тэнд шаардлага байгаад сумын иргэдийн сумын засаг захиргаанаас энэ газар нь олгож л байгаа бол тэр газраа зөвхөн малаа маллах биш ээ.

Мал маллахаас гадна олгож байгаа бол тэр олгогчид газартаа бас нэг тодорхой хэмжээний нэг га газартаа бол бас эзэмшээд тэндээ бол ургамал тариа, жимс ногоо, таримал ургамлаа тариад ингээд аж ахуйдаа эрхлэх боломж бололцоог нь олгох энэ өнцгөөсөө л энэ орж ирж байгаа юм шүү. Энэ хуулийн гол логик нь бол. Яг тэр юутай холбоотой хуулийн төсөлтэй зөрчигдсөн зүйлүүд байна уу, үгүй юу. Энэ яамнаас хариулна уу гэж хүсэж байна.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Байгальд ээлтэй залуусын чуулга уулзалтад оролцохоор 21 аймаг, 9 дүүргээс ирсэн хүүхэд залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Хүүхэд, залуучууд та бүгдэд ажил хөдөлмөрийн өндөр амжилт сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгээс нэмээд хариулчихъя. Ажлын хэсгийн хэддүгээр микрофон. 85 дугаар микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

**Д.Энхтуяа:** Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын Хуулийн хэлтсийн дарга Энхтуяа.

Тусгай хамгаалалтад авахаас өмнө олгогдсон байсан өвөлжөө, хаваржааны зориулалтаар олгож байгаа газруудыг ашиглах эрхээр ашиглаад, иргэд маань ашиглаад явж

байгаа. Тусгай хамгаалалтад авсны дараа Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулагдах учраас яг тэрэн дээр нөгөө өвөлжөө, хаваржааны зориулалтаар олгох эрх зүйн үндэслэл одоохондоо байхгүй байгаа.

Тэгэхээр тухайн хуулийн төсөл нь шинэчилсэн найруулга явж байгаа. Тэрэн дээр бол тусгах бололцоотой гэж харж байна.

**Л.Мөнхбаатар:** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль дээр яах юм шинэчилсэн найруулга хийгдэж байгаа юм уу тэ? Ахиад тодруулж Гочоогийн Ганболд дарга юу яачих тодруулаад асуучих саяынхаа асуултад нэг тодорхой хариулт тавихгүй бол энэ Тусгай хамгаалалттай газар нутагтай их олон аймгуудад байгаа асуудал шүү дээ тийм ээ. Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя.

**Г.Ганболд:** Би ийм л юм л асуусан л даа. Өмнө нь тусгай хамгаалалтад орохоос өмнө эзэмшиж байсан юмнууд л тэгээд яах вэ зүгээр ашиглаж л байгаа болохоос биш гэрээ гэрчилгээ гэж юм байхгүй шүү дээ албажуулж авах боломжгүй байхгүй юу тэр ашиглаж байгаа хүмүүс нь. Тэрнээс хойш бол орон нутаг тэр тусгай хамгаалалттай газар чинь өвөлжөө хаваржааны газар олдох боломжгүй шүү дээ. Бат-Эрдэнэ дарга тусгай хамгаалалттай газар энэ Байгаль орчны яамнаас л тэр зөвшөөрөл өгдөггүй. Ингээд нэг ийм асуудал үүсээд байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо бид нар чинь энэ хууль гаргачихдаа зэрэг өвөлжөө хаваржааны тэр нөгөө нэг өмнө нь тусгай хамгаалалтад орохоос өмнө ашиглаж байсан нөхдүүд байна шүү дээ. Өвөлжөө хаваржаатай. Тэр нөхдүүд чинь яг энэ хуулийн хүрээнд ингээд 1.5 га-гаа хагалаад тарьж болох

юм уу? Тэрийг л асуугаад байгаа шүү дээ би.

Тэгэхээр эсвэл энэ хуулийнхаа хүрээнд.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Монгол Улсын Их Хуралд хүний эрхийн талаарх өөрийн үнэлгээгээ дэлхийн бүх парламентууд дундаас анх удаагаа хийж жендерийн эрх тэгш байдлын талаарх өөрийн үнэлгээг хийсэн 13 дахь парламент боллоо. ОУПХ-ны хамтын ажиллагаа аргачлалын дагуу явуулсан энэхүү үнэ өөрийн үнэлгээний үйл ажиллагаанд зөвлөхөөр ажилласан Их Британийн парламентын гишүүн сайд асан хатагтай Мэг Манн, ОУПХ-ны Жендерийн түншлэлийн хөтөлбөрийн ажилтан хатагтай Мариана Дуарте, тус холбооны хүний эрхийн асуудал эрхэлсэн ажилтан хатагтай Ботанья Ламхарзи нар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаатай танилцаж байна аа.

Парламентын өөрийн үнэлгээг хийхэд туслалцаа үзүүлж хамтран ажилласан ОУПХ, тус холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Мартин Чун Ган болон зөвлөхүүд мэргэжлүүдийн цаашидын ажилд амжилт хүсэж, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн парламентын ардчиллыг бэхжүүлэх шударга ёс хүйсийн эрх тэгш байдлын мэдрэмжтэй ажиллах талаар гаргаж буй Монгол Улсын Их Хурлын хүчин чармайлт идэвх санаачилгыг ямагт дэмжиж байдагт гүн талархал та бүхэнд илэрхийлье ээ.

Асуултад нэмж хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсгийн 85 дугаар микрофон өгөөрэй.

**Д.Энхтуяа:** Ганболд гишүүний тодруулсан асуултад хариулъя. Тусгай хамгаалалтад авахаас өмнө эзэмших эрхээр олгочихсон байсан өвөлжөө хаваржааны газрыг эзэмших эрх нь хүчинтэй хэвээрээ мэдээллийн санд бүртгэлтэй хэвээрээ эзэмшээд явж байгаа. Тусгай хамгаалалтад авснаас хойш болохоор тусгай хамгаалалтын тухай хууль, нутаг дэвсгэрийн хууль үйлчлээд явах учраас яг энэ хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлтөөр бол 1.5 га-га нэмж авах боломжгүй байгаад байгаа. Тэгэхээр тусгай хамгаалалтын тухай хуулиар зохицуулагдаж явж байгаа, хэвээрээ хүчинтэй байгаа. Хэвээрээ эзэмших эрхээр мэдээллийн санд бүртгэлтэй байгаа.

**Л.Мөнхбаатар:** Ер нь бол Ганболд гишүүний хөндөж тавиад байгаа асуудал их чухал асуудал байгаа. Энийг та холбогдох гишүүдтэй хамтраад хууль санаачилж өргөн барьж болно. Шаардлагатай бол эхлээд асуулга тавьчихмаар юм шиг байгаа юм тийм ээ энэ асуудлаар. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээллийг сонсох нь зүйтэй. Ер нь бол хууль өргөн бариад энэ асуудлыг ер нь цогцоор нь шийдэж болно шүү.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар асуултаа асууя.

**Н.Наранбаатар:** Тэгэхээр энэ Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд малчид маань бас МАА-гаа эрхэлж орлого олохоос гадна бас газар тариалан эрхлэх, малын тэжээл тариалах ийм боломжийг нь бас нээгээд тэгээд хууль эрх зүйн орчныг нь нээгээд өгчхөж байгаа нь бол бас малчдад маань хэрэгтэй, бас сөрөг зүйлүүд бас гарч магадгүй гэж бас



*болгоомжилж байгаа юм. Одоо малчид маань ингээд отор нүүдэл хийгээд явахад очоод өвөлжих хаваржих өвөлжөө бууц олддоггүй.*

*Бүгдийг нь эзэмшээд авчихсан малчид ч байна, мал бүхий иргэд, зүгээр иргэд ч сумын төв аймгийн төвүүдэд эзэмшээд авчихсан байж байдаг. Тэгээд очоод өвөлжье хаваржъя гэхээр өндөр үнэ хэлээд ингээд очих буух газар байхгүй ийм хүнд асуудал байна. Ялангуяа энэ говийн аймгууд, тал хээрийн бүс нутгуудаар бас ийм асуудлууд гарч ирж байгаа юм.*

*Тэгэхээр энийг далимдуулаад малчид гэдэг нэрийн доор, мал бүхий иргэд гэдэг нэрийн доор цаашаа иргэд энэ өвөлжөө хаваржааны газруудыг их хэмжээгээр олноор эзэмшээд явчих вий. Мал бүхий иргэд гэдэгт бол сумын төв дээр байгаа хүмүүс бүгд л орно шүү дээ. Бүгд малтай байгаа. Тэгээд энэ улсууд чинь нээгдээд бүгдээрээ өвөлжөө хаваржаан дээрээ нэг га газрууд аваад ингээд хаших юм бол хаа сайгүй хашсан бараг бэлчээр хашсан дайны сүүлдээ бүүр ийм замбараагүй их захгүй гажуудал гараад тэгээд өнөө нүүдлийн МАА нөгөө отор нүүдэл хийх боломж нь байхгүй болоод отор нүүдэл хийгээд очсон газар нь энд тэндээс одоо эзэд гарч ирээд өвөлжөө бууц хондны эзэмшигч нар гарч ирээд хөөж туугаад аль эсвэл өндөр үнэ хөлс нэхээд ийм замбараагүй юм цаашидаа газар авчих вий. Үүнийг яаж хаах вэ? Энэ хуулийн төсөл дээр бол иргэн гээд л ингээд л явчихсан л байна. Тэгэхээр энэ дээр онцгой анхаарахгүй бол энэ бол цаашидаа олон жилийн дараа маш их хэмжээгээр магадгүй цаашаа худалдаад борлуулаад ингээд зах хаяа нь нийлээд ингээд бүүр бэлчээр хаших хэмжээний ийм асуудал гарах вий гэдэг дээр тодруулга авъя.*

**Л.Мөнхбаатар:** *Асуултад хариулъя. Хууль санаачлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя. Нэмээд бас хууль санаачилсан гишүүд хариулж болно шүү.*

**Ж.Бат-Эрдэнэ:** *Газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн тайланд дурдсанаар улсын хэмжээнд 80 мянган га талбай бүхий өвөлжөө хаваржааны газрыг 137914 иргэн эзэмшиж байгаа юм. Тэгэхээр ер нь бол цаашидаа нэг их айхтар нэг их өвөлжөө, хаваржаа аваад л ингээд шуураад авах нь бол гайгүй болов уу гэж бодож байгаа юм. Одоо жишээлбэл зүгээр хангайн бүс манай аймгаар бодоход бол авах нь аваад тэр хавь чинь өөр буух газаргүй болчих гээд л байна шүү дээ.*

*Ер нь бол жилээс жилд малын тоо хэмжээ нэмэгдэж байна. Жилээс жилд өрхүүд нэмэгдэж байна. Тэгээд одоо тэр бэлчээрээ л яаж хадгалах вэ гэдэг л асуудал. Ганц болчихоод байна л даа. Тэгэхээр бэлчээрээ хадгалахын тулд дахиад л тэрийг та бэлчээр нэг жоохон бэлчээрээ тойруулаад л айл болгонд өвөлжөө, хаваржаа зоогоод байвал энэ чинь бүүр болохоо байчихна гэдгийг бол орон нутаг маань өөрсдөө бас энийгээ мэдээд хамгаалалттай хийчхээд байна л даа.*

*Тэгэхээр яах вэ зүгээр энэ дээр нэг зүйл. Тэр гишүүд ч бас Батжаргал гишүүн ч ярилаа Тогтохсүрэн гишүүн ч ярилаа. Малчин өрх гэдгийг нь хэлэхгүй бол мал бүхий иргэн гэдэг яг тантай адилхан сум дээр байгаа бас нэг 5 малтай айл мал бүхий иргэн болчихоод байгаа байхгүй юу.*

*Тийм болохоор ерөөсөө өнөөдөр өвөлжөө хаваржаа эзэмшиж байгаа гэх юм уу эсвэл бас нэг ажлын хэсэг дээр энийг анхаараад нэг өөрчлөлт оруулъя. Тэгээд өвөлжөө, хаваржаа эзэмшиж*

буй малчин өрхөд нэг удаа аль нэг дээр өвөлжөө хаваржааны аль нэг дээр гэдэг юм уу нэг ийм үг үсэг оруулаад явчихвал бас цаашаа нэг их олон хаяа дэрлэсэн өвөлжөө хаваржаа болоод байхгүй гэсэн нэг ийм ойлголт гарах юм болов уу гэсэн ойлголт бодож байгаа шүү.

**Л.Мөнхбаатар:** *Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.*

**Н.Наранбаатар:** *Зүгээр санал байна. Энэ хуулийн төсөл дээр бол 1.5 га гэж байгаа тийм ээ хязгаар нь эзэмшүүлэх. Тэгээд үүнийг бол түрүүн бас нэг гишүүн хэлж байсан бас багадна. Яг амьдрал дээр бол нэгхэн га дотор бол олигтой юм хийж чадахгүй өрхийн орлогоо дэмжих хэмжээний юм хийж чадахгүй бас ядарсан төл мал эх малыг бас оруулаад хавар бол оруулчих хэмжээнд байж чадахгүй учраас бас энийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн ийм санал байна. 3 хүртэл гагаар ч юм уу.*

**Л.Мөнхбаатар:** *Наранбаатар гишүүн бас чухал асуудлууд асуугаад байна. Бат-Эрдэнэ гишүүн бас хариулчихъя тийм ээ энэ дээр нь. Ер нь бол 1.5 га гэдэг чинь 150 метр шүү дээ тийм ээ. Ингээд бодох хэрэгтэй тэ.*

*Асуултад хариулъя. Ганибал гишүүн бас нэмж хариулж болно шүү.*

**Ж.Бат-Эрдэнэ:** *Бид яг амьдрал дээр нь ерөнхийдөө үзээд хараад байгаа юм л даа. Бид одоо яг ингээд хавар цаг хүнд хүндэрсэн үед нэг хэдэн портёр, хэдэн ачаа машин өвс энэ тэр тараагаад л бас нөгөө тусалж дэмжлэг үзүүлдэг шүү дээ. Тэгээд 1 айлд нэг 10 боодол л очдог шүү дээ яг үнэндээ. 20 боодол ч очиж чаддаггүй. Тэгэхэд л тухайн үед ядарсан үед бол их юм болдог шүү дээ. Нэг га дээр бол одоо жишээ нь Булганд тариалсан ийм*

*турирлагууд байж байна. Нэг гагаас бол 200 боодол авч байгаа юм 200 боодол нь ногоон тэжээл авч байгаа юм. 4 портёрыг авчаж байгаа юм. Тэгээд энэ бол амьжиргаандаа бас хөөрхөн болчих болов уу гэж бодож л хийсэн юм байгаа юм.*

*Ер нь бол анхны миний боловсруулж байснаар бол 2 га гэж явсан юм уг нь бол. 2 га гээд. Тэгээд 2 га гээд тэгэхээр нэлээн хүндрэлтэй тулгарчих болов уу. Энэ маань бас буруу тийшээгээ халбийчих юм болов уу даа гэсэн бодлоор л татаад л 1.5 га болгож байгаад л тэгээд тэр дотроо нэг га дээр нь гэсэн юм. Гэхдээ ямар ч байсан яаж ч энэ цаг агаарын хүндэрсэн нөхцөл байдал энээ тэрээ боллоо гэхэд бол бас нэг тодорхой хэмжээнд 200 боодол ногоон тэжээл аваад боогоод тавиад байчихсан байхад бол малчдад нэлээн зүйл болчихно шүү. Нэлээн хэмжээтэй тус дэм болчихно шүү. Мянган малтай мянган хонь ямаатай айлд бол нэлээн зүйл тийм дэм тус болчих болов уу гэсэн бодлоор оруулсан юм.*

*Ер нь бол 2-оос л эхэлж байсан юм л даа. Энийг ажлын хэсэг дээр бас хараад гишүүд бас үзээд явчих нь зүйтэй байх л гэж бодож байгаа юм.*

**Л.Мөнхбаатар:** *Тийм ажлын хэсэгт Наранбаатар гишүүний тавиад байгаа асуудал их чухал зүйл хөндөж тавиад байна шүү дээ. Хэдэн малтай хүн, хэдэн га-д ногоон тэжээл тариаллаа гэж бодоход тэр нь нөгөө өвлийг өнтэй давчих хэмжээний байх вэ? Энийгээ шийдүүлэх хэмжээ мөн юм уу гэж асуугаад байна шүү дээ. Тийм болохоор энэ хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа ажлын хэсэг дээрээ Наранбаатар гишүүн бас ажлын хэсэгт та бас орж ажиллаад энэ асуудлаараа саналуудаа тусгаад явах нь зүйтэй байх гэж би бодож байна.*

*Зочин танилцуулъя аа.*

*Байгальд ээлтэй залуусын чуулга уулзалтад оролцохоор 21 аймаг 9 дүүргээс ирсэн хүүхэд залуучууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Хүүхэд залуучуудад та бүхэндээ ажил хөдөлмөрт нь сурлагад нь өндөр амжилт сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. Манай хүүхэд залуучуудын төлөөлөл бас 2, 3 хуваагдаж орж ирээд байгаа. Тэгэхээр аймгуудын төлөөллүүд бол ээлжээрээ ингээд орж ирж байгаа гэсэн үг. Өвөрхангайгаас байна уу? Манай хүүхэд залуучууд Төрийн ордонтой танилцаж байна аа.*

*Асуулт хариултаа үргэлжлүүлнэ. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуултаа асууя.*

**Б.Бат-Эрдэнэ:** *Баярлалаа.*

*Би 2 санал хэлээд орхиё. Нэгдүгээрт бол бидний өвөг дээдэс энэ улс үндэсний тулгуур газар юм гэж. Энэ улс үндэсний оришхуйн үндэс нэг газар хүн ард гэсэн ийм 2 тулгууртай байна гэж ингэж сургаж энэ зарчмыг л үеийн үедээ баримталж ирсэн. Ингээд 1990 оноос хойших энэ зах зээлийн харилцааны нийгэмд ер нь хаашаа маягтай болчхов оо? Энэ ажил хариуцаж байгаа улсуудад тодорхой хариулт өгөх бололцоо байх уу? Тухайлах юм бол газар өмчлөх тухай ийм хууль баталсан.*

*Газрын харилцааг зохицуулж байгаа оочин цоочин хоорондоо зөрчилтэй цоорхой ийм хуулийн зохицуулалтууд байна уу? Зүгээр улс орны сая таван зуун хавтгай дөрвөлжин километр нутгийн хил энэ 2 том хөрштэй бид нар чинь айл хөри оришж*

*байгаа шүү дээ. Хилийн будилаан байхгүй. Энэ бидний ахмад үеийн байгуулсан гавьяа гэж хэлэх ёстой гэж ингэж ойлгож байгаа юм. Ямар нэгэн зөрчил маргаан байхгүй.*

*Өнөөдөр бол энэ дэлхийн бүс нутгуудад болж байгаа дайн байлдаан мөргөлдөөн бол ер нь л ихэвчлэн л газар нутгийн маргаантай байдлаас болж л бий болж байгаа шүү дээ. Палестин энэ Газрын зурвасыг хар. Украин, ОХУ өөр юу байдаг юм тийм ээ? Тэгэхээр энэ бол бидний өвөг дээдэс энэ ахмад үеийнхэн үнэхээр гавьяа байгуулсан гэж хэлэх гээд байгаа юм. Гэтэл бол энэ дотооддоо улс орныхоо дотор энэ бид нар энэ үеийн үедээ улсын үндэс газар гэж бодлого баримталж ирсэн энэ Хүннү их гүрний 2 мянга гаран жилийн түүхэнд Хүннү их гүрнээс хойш л үеийн үедээ энийг барьж ирсэн байна шүү дээ. Гэтэл энэ ашиг арилжаа хөөсөн энэ зах зээлийн харилцааны нийгэмд шилжээд ерөөсөө гучхан жилийн хооронд ер нь хаашаа болгоод байна аа? Энэ дээр тодорхой хариулт өгөх тийм бололцоо байх уу? Нэг хариулт авмаар байна.*

*Энэ гишүүдийнхээ санаачилж байгаа хуулийн төслийг зарчмын хувьд нь дэмжиж байгаа юм аа. Энэний цаад талд газар бэлчээрийг эзэн суучихсан хашаажуулсан ийм буруу чиглэлийн сөрөг үр дагавар юм хум гарах уу, үгүй юү? Тэрийг нь та нөхдүүдэд маань тооцож байгаа зүйл байна уу? 2012-оос 2016 онд энэ Бэлчээрийн тухай хуульд өөрчлөлт оруулна гээд нэг том асуудал босож ирсэн шүү дээ.*

*Тэгээд тухайн үед бол томоохон эрдэмтэд иргэний нийгмийн төлөөлөл мэргэжлийн хүмүүсийг оруулж байгаад бүүр ӨМӨЗО-оос яг энэ чиглэлээр олон 10 жил судалгаа хийсэн ийм профессор эрдэмтдийг урьж оруулж ирж байгаад Төрийн ордонд томоохон хэлэлцүүлэг*

юм хийсэн. Өвөр Монголын эрдэмтдийн тавьж байгаа асуудал хаашаажуулж хэрхэвч болохгүй шүү. Энэ газрыг бүүр ингэж хөдөлгөөнгүй эзэмшүүлнэ гэдэг бол энэ нүүдлийн ахуй соёл, энэ л улс үндэстний чинь дархлаа баталгаа болсон энэ ахуй соёлыг чинь тэр чигт нь үгүй болгоно шүү.

Энэ нүүдлийн МАА гэдэг юм чинь бол цаашаа явах тийм бололцоо байхгүй болно шүү гэдэг ийм асуудлуудыг тавьсан. Харин тэгээд бид хэдийн энэ хэлэлцүүлэг бас нэг хэрүүл тэмцэл хийсний үр дүнд бол тэр бэлчээрийн тухай хууль бол тэгсхийгээд нэг юм намжсан ийм дүнтэй юм аа. Ингээд бол би та нөхдүүд маань энэ манай Хэнтий аймгийн Цэнхэрмандал зэрэг сумдад бол 50-аас 100 га газарт нэг баг нийлээд багийн өрхүүд ногоон тэжээлээ тариад хуваагаад авчаж байна. Ийм сайн жишгүүдийг та нөхдүүд маань судалж байгаа ийм зүйл байна уу?

Нэг минутаа би үргэлжлүүлээд авбал сайн байна дарга аа.

#### **Л.Мөнхбаатар:**

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ бас хэд хэдэн зүйлийг тодруулж асууж байна. Энд нь хариулъя. Хууль санаачлагч Бат-Эрдэнэ, Ганибал нар хариулъя тийм ээ. Жадамбын Бат-Эрдэнэ хариулаад дараа нь Наянтайн Ганибал гишүүн нэмж хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ Өвөр Монголд байгаа асуудлыг нааш нь татаж авчирч бас болохгүй ээ, Бат-Эрдэнэ гишүүн ээ. Тэнд чинь бол бэлчээр хашихаад байгаа байхгүй юу даа. Бэлчээр хашиж болохгүй гэдгийг бол бид бүхэн та бүхэн ч, та ч зөвшөөрч байгаа. Бид бүхэн бүгдээрээ зөвшөөрч байгаа. Бэлчээрийг бол ерөөсөө хашиж

болохгүй. Энэ бол нийтийн эзэмшлийн талбай. Энэ хашина гэдэг ойлголтыг бол зөв хэдүүлээ ярихгүй бол бас буруу тийшээгээ ингээд халбийчих гээд байгаа юм. Энэ одоо жишээ нь бид нар 5 малаа өвөлжөө, хаваржаан дээрээ бол хашиж байгаа шүү дээ. Энэ хашаатай адилхан энэ хашаагаа цааш нь үргэлжлүүлээд л нэг га-д нь үргэлжлүүлчихнэ гэсэн ойлголтоор бид нар ярьж байхгүй бол ерөөсөө тэр өвөлжөө хаваржааныхаа хавийг нь лав хашаад хаячих юм шиг л нэг ийм ойлголт малчдын дунд яваад байгаа юм энийг би жишээ нь уулзалт хийх үедээ бол хэлээд яриад энд тэр малчдын бэлчээрийг чинь хаших асуудал яригдаагүй, огт яригдаагүй шүү. Зөвхөн өвөлжөө хаваржааны газарт та бүхний хэрэглэж байгаа, ашиглаж байгаа, төрөөс олгочихсон, ашиглаж байгаа энэ газарт чинь тодорхой хэмжээгээр ашиглаж байгаа газрыг чинь нэмэгдүүлъя.

Тэгээд тэндээ бол мэдээж малаа хашиж байгаатай адилхан жимс ногоо тэгээд таримал ургамал тариалсан бол мал нь ороод идчихгүйн тулд нэг хаших асуудал бол гарч л таараа шүү дээ. Тэр бол нэг га-г бол хашиж л таараа. Мэдээж таримал ургамал тарьчихсан л юм бол хаших асуудал байгаа байх. Тэгэхээр энэ бол ерөөсөө бусад газар жишээ нь хангай бүсийн энэ асуудлаар бол ингээд тариад тариад явж байгаа юм бол турилага амьдрал дээр байгаад байгаа юм. Тэр хоршоолол болоод жишээ нь манай Булган дээр бол хоршоолол болоод 20 өрх нэгдээд тэгээд сум нь тодорхой газар өгөөд ингээд өгсөн явдал зүйл яригдаж байгаа болж байгаа энэ бол.

Тэрэнд нь бол жишээ нь манай Шинэ хөдөө хөтөлбөрөөс тодорхой хэмжээний тоног төхөөрөмж, трактор, хадуур тармур боогч эд нар өгөөд дэмжээд ингээд явж байгаа. Энэ

бол цаашаа явах ёстой асуудал. Энэ бол ингээд явж байгаа.

Гэхдээ энд түрүүн босоо Ганбаа гишүүн нэг аятайхан сайхан үг хэлж байсан. Энэ хууль эх оронч хууль юм гээд бас надад урам өгнө лээ. Эх оронч хууль юм энэ. Иргэн болгон өөрөөр хэлбэл малчин иргэн болгоноо дэмжих, малчин өрх болгоноо дэмжих, ААН болгож хөгжүүлэх, цаашидаа тогтворжссон МАА-гаа аваад явахад нь бол дэмжлэг болсон хууль. Тийм болохоор ерөөсөө л тэр аж ахуйг нь дэлгэрүүлэх, аж ахуйг нь сайжруулах тэр өмнөх газар 0.5 байгаа эзэмшлийг нь л хашаад тэрэнд нь 1.5 болгох л асуудал бол яригдаж байгаа юм шүү.

Энийг бас бид цаашаа ингэж засаж ярьж байхгүй бол иргэд маань үнэхээр газраа хамгаалах газраа энэ чинь тусгаар тогтнол улс орны эрх ашигтай холбоотой асуудал ч юм уу асар өндөр хэмжээнд бол газартай холбоотой асуудал хүн болгоны зүрхэнд явж байдаг болохоор энэ газрыг ингээд хөндөөд ярихаар зөв ойлгуулахгүй бас буруу тийшээгээ явчих гээд байдаг нэг ийм тал бас харагдаад байгаа юм шүү гэж хариулъя аа.

**Л.Мөнхбаатар:** Одоо санал хураалт явагдана. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд танхимдаа орж ирье. Санал хураалтад бэлтгэе. Ганибал гишүүн нэмж хариулъя. Яах юм хариулсны дараа ярих юм уу та тодруулах юм уу?

**Н.Ганибал:** Энэ хуулийн санаачилга бэлчээрийн МАА-г үгүй хийх гэсэн биш энийг харин бэлчээрийнхээ МАА-г авч үлдэх гэсэн л санаачилга байгаа юм. Энэ өнөөдөр бид нарт тулгарч байгаа хамгийн чухал асуудлууд маань бид нар энэ өвөл давахаасаа бүүр өвлийг яаж давах вэ гэдэг энэ айдас бол

манай энэ тал хээрийнхний хувьд маш их айдастай боллоо. Энийгээ даван туулахад бид нар бэлтгэлтэй байх ёстой. Энэ бэлтгэлийг хангахын тулд тодорхой хэмжээнд бас нэг хаврын тарчиг цагт нэг жоохон газрыг энэ ядарсан малдаа л бэлтгэж байгаа асуудал байхгүй юу. Энэний төлөө л энэ хуулийн санаачилга явж байгаа. Тэрнээс бол одоо их хэмжээгээр нь бэлчээр хашаад Өвөр Монголтой адилхан болох гэж байгаа асуудал биш л дээ.

Тэгээд Бат-Эрдэнэ гишүүнд хэлэхэд сум болгонд энэ боломжууд байхгүй. Та бол саяынх бол танай Өмнөдэлгэр сум дээр гарч байгаа энэ асуудал дээр магадгүй яг хуулийг нь сөхөөд үзэх юм бол тэнд хэдий хоршоолол хоршоогоор хоршоо байгуулаад 20 га дээр малчид маань ногоон тэжээл тарьж байгаа нь аягүй хууль зөрчсөн байгаа байх. Хууль зөрчсөн байгаа байх. Яагаад гэхээрээ Монгол Улсад байгаа 1 сая га талбайг л атаршсан болон одоо газар тариалангийн зориулалтаар ашиглаж байгаа тэр талбайг л хагалах тэгээд ногоон тэжээл тарих ийм л боломж байгаа юм. Бусад нь эрүүл газрыг ямар нэгэн байдлаар хагалах нь бол бүрэн хуулиар хаалттай байгаа.

Тэгэхээр өнөөдөр нэг малчин өрхийн хэрэгцээнд шаардлагатай ногоон тэжээл гэдэг маань 2 га-д тарьчихсан ногоон тэжээл бол нэг малчин өрхийг бүрэн хангах ийм боломж бол бас байгаа. Тэгэхээр энийг л нийлүүлээд яг албан ёсны хууль болгох ийм л зорилт тавьж байгаа. Тэрнээс зарим нь давуу эрх эдэлдэг. Зарим нь хууль зөрчдөг. Ер нь сүүлийн үед бол ер нь ихэнх малчид маань бол энэ хуулийг зөрчөөд ногоон тэжээл тарих ийм явдал газар авч байгаа. Тэгэхээр эд нарыг бол энэ зохион байгуулалттай яг хуулийнх нь энэ хүрээнд нь л бий болгох хууль

зөрчүүлэхгүйн тулд л бараг энэ хууль араас нь гарч байгаа гээд хэлэхэд бараг гарч байна даа. Тэгж ойлгоход болно доо.

**Л.Мөнхбаатар:** Бат-Эрдэнэ гишүүн тодруулахаас өмнө зочдоо танилцуулчихъя. Тэгээд Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна.

Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэнгийн урилгаар Архангай аймгийн Тариат, Чулуут сумдын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөрт нь өндөр амжилт сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе. Тариат, Чулуут сумдын сумдын иргэдийн төлөөлөл.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Гишүүд танхимдаа орж ирээрэй.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгэхээр манай хуулийн төсөл санаачлагч манай гишүүд бол жаахан зөрүүтэй ойлголттой байх шиг байна шүү. Би энэ хуулийн төслийг чинь дэмжихгүй гэж хэлээгүй. Цаана нь дагаж гарах сөрөг үр дагаврыг нь та нар сайн тооцож үзээрэй гэж ингэж хэлж байгаа шүү. Энэ улсын чинь энэ оршихуйн үндэс газар. Би дахиад хэлье. Улс оршихуйн үндэс газар шүү. Нэмэлт тэр хариултыг өгөөрэй. Би энэ мэргэжлийн ажлын хэсгийн улсуудаас асуусан шүү. Тэр газрын газар өмчлүүлэх хууль энэ газрын харилцааг зохицуулсан хуулийн чинь өнөөдөр ямар хүчин чадалтай байгаа юм бэ? Энэний дундуур хил нь баталгаатай байдаг энэ

улс орны чинь дотроосоо энэ хууль, эрх зүйн орчин, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх энэ юманд чинь аюулгүй байдал тусгаар тогтнолын чинь асуудал алдагдахаар ийм түвшинд хүрч байгаа юм биш биз?

Энэ дээр тодорхой хариулт өгөөч гэж. Нөгөө нэг юм бол наад төслийн чинь энэ санааг чинь тэр байтугай одоо энэ нэг фермерийн аж ахуй тийм ээ, төв суурин газрын хүнсний сүүний хэрэгцээг хангаж байгаа энэ газар.

**Л.Мөнхбаатар:**

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн яг энэ тухайн хуулийн төслийг дэмжиж байгаагаа хэлсэн шүү дээ. Гэхдээ энэ дээр ийм анхаарах зүйлүүд байна. Хамтад нь бас та нар цогцоор нь бодож байгаа юу гэсэн ийм асуудлуудыг тавьж байгаа юм. Энэ дээр нь ажлын хэсгээс хариулчихъя. Ажлын хэсгийн хэддүгээр микрофон вэ? 83 дугаар микрофоныг өгье. Асуултад нэр албан тушаалаа хэлээд хариулаарай.

**Э.Батболд:** БХБЯ-ны Хөгжлийн бодлого газрын харилцааны бодлогын газрын дарга Батболд Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя аа.

Бид бүхэн Газрын тухай хуулиараа одоо бол шинэчилсэн найруулгыг өргөн бариад бэлдээд явж байгаа. Энэ дээр бол газрын бүх бодлого зохицуулалт маань өөрөө газрын нэгдмэл сангийн нэгдсэн удирдлагатай байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Үүнтэй холбоотойгоор цаашидаа газартай холбоотой газрын ангилуудыг хооронд нь давхардуулах гэдэг асуудлыг бол энэ хуулийн зохицуулалтаар бол байхгүй болгож тухайн газрыг тухайлсан зориулалтынх нь дагуу л зөвхөн ашигладаг энэ нөхцөл боломжийг бүрдүүлэх энэ зохицуулалтын асуудлыг бол оруулаад явж байгаа юм.

Тэгэхээр цаашидаа тусгай хамгаалалттай газар нутаг мөн уул уурхай, бэлчээр, газар тариалан, ойн сав газар гэх бүх газрууд маань өөрсдөө зөвхөн тусгайлсан нэгдмэл сангийн удирдлагаараа заасан бүстэй байж тэрэн дээр нь давхардуулсан үйл ажиллагаа явуулахыг бол хориглох энэ хууль эрх зүйн орчныг бүрдүүлээд явж байна. Газар өмчлөхтэй холбоотой асуудлыг бол зөвхөн Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар зөвхөн газар өмчлүүлдэг зохицуулалтыг бол оруулсан. Түүнээс бол бусдад зориулалтаар газрыг өмчлүүлэхгүй зөвхөн ашиглуулах эзэмшүүлэх энэ хууль эрх зүйн орчинтойгоо ингээд энэ зохицуулалтаар хангаад явж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуултаа сууж хариулт авч дууслаа.

Уг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн уг хэлье. Ингээд дараа нь санал хураалт явагдана, гишүүд танхимдаа орж ирээрэй.

**Л.Мөнхбаатар:** Хуулийн төслийг бол дэмжиж байгаа юм зарчмын хувьд. Тэгэхдээ 3 санал байгаа юм. Та бүхэн хууль хэлэлцэх үедээ бас анхаараад өгөөрэй гэж. Бид нар энэ баруун бүс дээр яг ингээд бэлчээрийн менежментийн асуудлаар ингээд л хэлэлцүүлэг хийгээд явж байхад нэг зүйл яригдаж байсан юм л даа. Та бүхэн бол 1.5 га газрыг бол ингээд жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо тариад тэгээд өрхийнхөө хэрэгцээг хангаад илүү бас борлуулчихъя тэгээд 1 ногоон тэжээлээ тарьчихъя гэж байгаа юм байна л даа.

Залуу малчид хүмүүс нэг зүйл хэлж байгаа юм. Яг газрын нүдийг олоод

буусан, усны эхэнд буусан, уулын ам хаашаад буучихсан өвсний соргог дээр буучихсан ийм айлууд чинь нүүхгүй байна аа. Одоо нөгөө өвөлжөө хаваржаа гэдэг юмандаа нүүхээ болиод суурьшичихсан. Тэгээд том байшин бариад суучихсан. Тийм тэнд чинь одоо бид нар ингээд бэлчээр ингээд явах малаа бэлчээх, услах ийм юмнууд чинь улам хомс болоод байна аа. Тэд нарын мал нь улам өсөөд байдаг нэг өрх бүлээсээ 200, 300 мал таслаад ингээд шинээр гэр бүл болчихсон хүмүүст нэлээн хүндрэлтэй байна гэж байгаа юм.

Тэгэхээр энийг нь цаашидаа яах вэ гэдэг дээр нэгдүгээрт анхаарах ёстой юм байгаа юм.

Хоёрдугаарт түрүүн бас Тогтохсүрэн гишүүн хэлж байсан. 2-оос 3 өвөлжөөтэй болчихоод тэгээд өвөлжөөгөө түрээслээд яваад байдаг сумын төвийнхөн байна. Мал бүхий иргэд гэдэг дотор орчихоод байна аа. Энийг нэг цэгцлэхгүй бол тэрүүгээрээ бизнес хийдэг болчихоод нөгөө малтай жинхэнэ мал маллаж байгаа хүмүүстэй ингээд цаашаагаа ингээд малаа маллаад явахад нэлээн хэцүү болоод байна гэдэг нэг ийм юм ярьж байгаа юм.

Гурав дахь нь бол ингээд усалгаатай тариалан МАА-тай хамтарч эрхлэхгүй бол ерөөсөө болохгүй байна гэж байгаа юм. Тэгэхгүй бол нөгөө бэлчээрийн даац улам муудаад цөлжөөд ирэхийн алдад бол усалгаатай тариалангийн асуудал дагаж явахгүй бол энэ өвсний гарц энэ муу байгаа зуншлага муу байгаа энэ үед бол малыг тарга тэвээрэг авхуулахад их хүндрэлтэй байна шүү.

Тийм учраас энэ усалгаатай тариалангуудад дагасан хөдөлмөр хорисон юм хийгээч гээд байгаа байхгүй

юу. Түрүүн бас гишүүдээс санал гарч байна лээ. Тэр нэг багт нь тодорхой хэмжээгээр газар өгөөд тэгээд багийн малчид тэндээ тэр ногоон өвсөө тариад малын тэжээлээ тариад хамтарч хөдөлмөрөө хоршоод тэндээсээ тодорхой орлогоо олоод дээр нь бол бас өвөл хэрэглэх малынхаа тэжээлийг бэлтгээд явах ийм бололцоо байна шүү дээ гээд байгаа юм. Энэ бол нөгөө дан дангаараа биш хөдөлмөр хорших асуудлыг бас давхар явахгүй бол ялангуяа баруун бүсэд энэ говийн бүсэд тал хээрийн бүсэд ч хэцүү байгаа юм аа. Яах вэ хангайн бүсэд тэгээд сайхан ургадаг бор хөрстэй газар болдог л байх. Бусад газар чинь нэлээн асуудалтай байгаа учраас энийг тэр усалгаатай тариаланг нь давхар хөгжүүлэх талд нь бодохгүй бол тэр хатуу ширүүн уур амьсгалтай газар чинь нэг малчин ганцаараа 1.5 га газар дээр ингээд ногоон тэжээлээ тариад бүх юмаа хийгээд биеэ даагаад явах бас тийм бололцоо боломж нь хомс юм билээ.

Тэгэхээр тэрийг чинь бас нэг харж байдаг, манаж байдаг хүн хэрэгтэй учраас хөдөлмөрийг нь хоршоод хийвэл их зүгээр байна шүү гэдэг юм хэлж байсныг та бүхэн энэ дээр бас хууль боловсруулахдаа хуулийн хэлэлцүүлэг яваад эхлэхээр бас анхаараарай гэж хэлэх гээд байгаа юм. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Энх-Амгалан гишүүн тодорхой саналууд хэллээ. Хэлэлцүүлгийн явцад анхаарах нь зүйтэй.

Одоо санал хураалт явагдана. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Яах вэ энэ хуулийн гол зорилго нь ийм л байна шүү дээ. Малчид тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах, түүнээс гадна өвөлжөө хаваржаандаа 200 метрийн радиусын дотор 1.5 га-д таримал

ургамал, жимс жимсгэнэ, хүнсний ногоогоо тариад өөрсдийнхөө хэрэгцээг хангах, түүнээс гадна бас нэмэлт орлоготой болгох нөгөөтээгүүр бас энэ суурин энэ МАА эрхлэх бас урьдач нөхцөл нь болох ийм зүйл бас харагдаад байгаа. Ийм учраас энэ хуулийн төсөл их чухал хуулийн төсөл болжээ гэж манай гишүүд бас дэмжиж байна.

Ингээд санал хураалтыг явуулъя аа. Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ. Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөж байна.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан тавьсан Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахмал түлшний талаар тавьсан асуулгын хариуг сонсоно оо.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

12.22 цагт



## ЗАВСАРЛАГА

**Г.Занданшатар:** Өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганых 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан тавьсан асуулгын хариуг сонсоно. Энэний өмнө мэдээлэл хийх зүйл байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгаад Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>2</sup>.2, 39<sup>1</sup>.2.3, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын дарга иргэдийн өргөдөл гомдлыг 100 мянга хүрсэн бол 3 хоногийн дотор Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулах үүрэгтэй гэж заасан. Парламентын ардчиллыг төлөвшүүлж хөгжүүлэхэд хамгийн үнэ цэнтэй асуудал бол иргэдийн дуу хоолой, хүсэл тэмүүллийг сонсдог, оролцоог хангадаг байх ёстой явдал юм. Мөн иргэдийнхээ үндсэн эрхийг хүндэтгэж, судалгаа тооцоолол, бодит мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргадаг байх ёстой.

Монгол Улсын Их Хурлын *D-irgudul*-ийн системд нийтдээ 549 иргэн 630 нийтийн өргөдөл санаачилснаас 549 иргэний ийм өргөдөл гомдол ирснээс 111 иргэний 120 нийтийн өргөдөл шаардлага хангасан тул албан ёсоор байршуулаад байна. Эдгээрээс 3 өргөдөл 100 мянгаас дээш санал авсан байна. Энийг одоо Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup>.2.2-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу та бүхэнд мэдээлж байна.

Монгол Улсын иргэн Раднаабазарын Цэндсүрэн. Цалинтай ээж гэж нэрлэгдэж буй 50 мянган төгрөгийг нэмэхийг та дэмжиж байна уу гэсэн гарчигтай цахим өргөдлийг *D-irgudul*-ийн системд гаргасан. Энэ бол 100 мянга болон түүнээс дээш иргэдийн санал авсныг хуулийн дагуу Тамгын газраас Улсын Их Хурлын даргад ирүүлснийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна аа.

Өргөдлийн агуулга нь цалинтай гэж нэрлэсэн мөртөө энэ 50 мянган төгрөгийн цалин хаана ч хүрдэггүй. Нэг бол нэрийг нь солих хэрэгтэй. Нэг бол нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн үндсэн үндэслэлээр бичсэн.

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хувь хэмжээг нэмэх, НДШ, ХХОАТ-ын шимтгэлийг өөрчлөх гэсэн 2 өргөдөл гаргасан. Энэ татварын цогц шинэчлэл хийх ажлын эхлэл болж Улсын Их Хурал, Засгийн газар уг асуудлаар хамтран ажиллаж байна. Улсын Их Хурлаас ажлын хэсэг гаргасан.

Улсын Их Хурлын даргын захирамжаар 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдөр энэ татварын цогц шинэчлэлийн асуудлыг нарийвчлан судалж, дүгнэлт шинжилгээ хийж, хаврын чуулганд багтааж Улсын Их Хуралд танилцуулахыг үүрэг болгосон боловч энэ хэрэгжээгүй байсан. Тэгээд энэ ажлын хэсэг ч гэсэн үргэлжлүүлэн ажиллаж байгаа. 100 мянгаас дээш авсан энэ 3 өргөдлийн хувьд бол бас энэ нэг талаас энэ төрийн санхүүгийн бодлогыг, нийтийн санхүүгийн бодлогыг шинэчлэх эрх шинэчлэлийн нэг эхлэл болох ёстой гэж үзэж байгаа юм. Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлсэн, ахуй амьдралд нь нэмэр болсон ажлын байр нэмэгдүүлсэн ийм шийдвэрийг төр

засаг гаргах ёстой болжээ гэдэг нь тодорхой байна.

Нийтийн санхүү ч гэсэн энэ халамжийн бодлогыг цэгцтэй тодорхой болгох ёстой. Зарлага талаа, төсвийн зарлага талаа оновчтой шинэчлэх ёстой. Төсвийн орлого талаа бас оновчтой шинэчлэх ёстой. Ийм учраас одоогоос 9 сарын өмнө Улсын Их Хурлын дарга захирамж гаргаж 2023 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр 37 дугаар захирамжаар татварын орчинд дүн шинжилгээг санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол татварын суурь шинэчлэл хийх шийдвэрийн төсөл боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэнгээр ахлуулан байгуулсан. Ажлын хэсгүүд сая бид бас хөдөө орон нутагт ажиллалаа. Үндэсний үйлдвэрүүдийн ажилтай танилцаж байна. Ер нь бодит шаардлага дээр үндэслээд иргэдийн өргөдлийг Байнгын хороо, чуулганаар хэлэлцэж байгаа нь өөрөө ардчилал юм. Ард түмний засаглах эрхийг хэрэгжүүлж байгаа төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлж байгаа хэлбэр юм, илэрхийлэл нь юм.

Ийм ч учраас хагархай цонхны онол гэж байдаг. Одоо нэг цонх хагархай байгаад л байх юм бол бусад цонх хагарна аа. Замын хөдөлгөөн зөрчөөд л байх юм бол бусад нь зөрчдөг болно оо. Тэгээд НӨАТ-ын хууль гэхэд 50 хувь нь хэрэгжүүлдэггүй. Ийм загвар, эмх замбараагүй байдал тогтох юм бол улам гүнзгийрнэ гэж үздэг. Ийм учраас энэ иргэдийн санал бодлыг бид зайлшгүй харгалзан үзэж шинжлэх ухааны үндэслэлээ судалж бодитой шийдвэр гаргах шаардлагатай.

Ийм ч учраас хуулийн шаардлага хангасан 100 мянгаас дээш хүний санал авсан энэ 3 өргөдлийн талаар та бид

холбогдох журмын дагуу хэлэлцэж шийдвэр гаргаж гаргаж иргэддээ хариуг нь өгөх ёстой гэдгийг онцлон тэмдэглэе.

Энэ дашрамд Монгол Улсад парламентын ардчиллыг төлөвшүүлэх түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх үйл хэрэгт чухал хувь нэмэр оруулсан явдал энэ 7 хоногт бас тохиож байгааг мэдээлье. Монгол Улсын Их Хурал ОУПХ-той хамтран 2022 оны 8 дугаар сард байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд жендерийн болон хүний эрхэд эрхийн мэдрэмжтэй парламентын өөрийн үнэлгээг хийж байна.

Олон улсын парламентын холбоо жендерийн мэдрэмжийн өөрийн үнэлгээг сүүлийн 10 жилийн хугацаанд бусад улстай хамтран зохион байгуулсан бол хүний эрхийн мэдрэмжийн өөрийн үнэлгээг анх удаа Монгол Улсад зохион байгуулж байгаа юм аа. Иймээс хүний эрх жендерийн асуудлаар ямар үр дүнд хүрсэн, цаашид юунд анхаарах шаардлагатай байгааг хөндлөнгийн мэргэжсэн олон улсын шинжээчидтэй хамтран үнэлгээ хийх боломжийг олгосон ОУПХ-нд талархал илэрхийлье.

Монгол Улсын парламентын нэн шинэ түүхийн анхдагч хуудсыг бичиж буй Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын ажилтнууд, холбогдох байгууллагад баяр хүргэе. Энэ манай парламентын түүхэнд орох ийм чухал үйл явдал болж байна гэдгийг тэмдэглэн хэлж байна. Улсын Их Хурлын гишүүд бас идэвхтэй оролцсонд талархал илэрхийлье ээ.

Өнөөдөр бас энэ хүний эрх, жендерийн мэдрэмжийн асуудлаарх

үнэлгээний дүгнэлттэй бид танилцах байгаа. Өнөөдөр 3 цагаас.

Ингээд гол нь ажлын хэсэг байгуулагдсан энэ 3 өргөдлийн асуудлаар нийтийн санхүүд реформ хийх, татварын цогц шинэчлэл хийх асуудлаар Засгийн газартай хамтран ажиллаж энэ талаар Засгийн газрын холбогдох байгууллагууд томоохон судалгаа хийж танилцуулж байгаа. Худалдаа аж үйлдвэрийн танхим, хувийн хэвшилтэй бас нягт хамтран ажиллаж ойрын үед санал санаачилгаа бодит ажил хэрэг болгох талаар ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгож байна аа. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно оо.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэлээс Монгол улсын ерөнхий сайдад хандан Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахам түлшний талаарх тавьсан асуулгын хариуг сонсоно.

Асуулгад Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн хариулна аа. Индэрт урьж байна.

**Б.Чойжилсүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдол болон сайжруулсан шахмал түлштэй холбоотой асуудлаар тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгын хариуг та бүхэнд танилцуулъя аа.

Асуулга нэг. Улаанбаатар хотын утааны нөхцөлийн талаар:

Улаанбаатар хотын агаарын чанар, гэр хороолол, авто зам, орон сууцны хороолол үйлдвэрийн дүүрэг орчмын 18 цагт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий, азотын исэл,

рм-2.5, рм-10 тоосонцор болон нүүрстөрөгчийн дутуу ислийг автомат багажаар тодорхойлж байна. 2022-оос 2023 оны халаалтын улиралд рм-2.5 тоосонцрын агууламж 65 микрограмм метр куб, рм-10 тоосонцрын дундаж агууламж 107 микрограмм метр куб байгаа нь Багануурын нүүрс түлж байсан байх үетэй харьцуулахад 50 хувиар бага байна аа.

Асуулга 2.

Утааг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, тэдгээрт зарцуулсан төсөв, хөрөнгө оруулалт, татаас болон тэдгээрийн эх үүсвэрийн талаар:

Эхний асуулгад хариулъя. Гэр хорооллын айл өрхүүдэд цахилгаан халаагуур ашиглах техникийн боломж бүрдүүлэх ажлын хүрээнд.

Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн 86.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2017-оос 2019 онуудад Улаанбаатар хотын 41964 гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлснээр цахилгаан хангамжийн найдвартай байдал дээшилж сүлжээний горим ажиллагаа оновчтой болж айл өрхийн цахилгаан хангамж сайжран шугам сүлжээний алдагдал буурч айл өрхүүд 4 квт чадалтай цахилгаан халаагуураар гэр орноо халаах нөхцөл бүрдсэн.

2.Халаалтын зуух төвлөрсөн дулаанд холбох ажлын хүрээнд:

Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2017-оос 2020 онуудад нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа 236

халаалтын зуухыг зогсоож, 336 иргэн, ААН-ийн барилга объектыг төвлөрсөн дулаан хангамжид холбосон байна аа.

Гурав дахь багц ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхүүдэд шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлэх ажлын хүрээнд.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор батлагдсан Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журмаар 2017 оноос хойш эхлэн агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа гэр хорооллын хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний тарифт хөнгөлөлт үзүүлж байна аа. Нийслэлийн гэр хорооллын хэрэглэгчдийн оройн 21 цагаас өглөөний 06 цагийн хоорондох хэрэглээг 220 вольтын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 700 квт цаг, 380 вольтын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 1500 квт цагийг тус тус 100 хувь хөнгөлж, 1 сарын хэрэглээний дээд хязгаараас илүү хэрэглэсэн цахилгааны тарифыг 50 хувиар хөнгөлж байна аа. Мөн Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 318 дугаар тогтоолоор аймгийн төвүүд болон 10 мянгаас дээш хүн амтай сум суурин газрын гэр хорооллын бүс дэх 2 тариф тоолууртай айл өрхийн шөнийн тарифыг 50 хувиар хөнгөлж байна. Цахилгааны тарифын хөнгөлөлтөд улсын төсвөөс 2017-оос 2022 онуудад өссөн дүнгээр 52.2 тэрбум төгрөг 2023 оныг хүлээгдэж байгаа. Өссөн дүнгээр гүйцэтгэл 85.8 тэрбум төгрөг ариуулахаар байна.

Асуулга гурав. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулагдсанаар утаа буурсан эсэх тухай болон энэ хугацаанд угаартаж амиа алдсан болон эм эмнэлгийн тусламж авсан иргэдийн талаар.

Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглож сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлснээр РМ-2.5 тоосонцрын агууламж 65 микрограмм метр куб, РМ-10 тоосонцрын дундаж агууламж 107 микрограмм метр куб байгаа нь Багануурын нүүрс түлж байх үетэй харьцуулахад 50 хувиар буурч хүхэрлэг хий 91 микрограмм метр куб болж нэмэгдсэн байна.

Иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, мэдээллээр хангах, хяналт тавих, яндан зуухны засваржуулах үйлчилгээг үзүүлэх, заавар зөвлөмжийг өгч ажиллах, хэрэглэгчдээс ирүүлж буй санал гомдлыг хүлээн авах зорилготой Хэрэглэгчдэд үйлчлэх төв ажиллаж байна аа. Тус төвөөс 7 дүүргийн гэр хорооллын 182100 өрхөөс зуухны нөхцөл байдлын судалгаа авахад 127108 өрх нь чанарын шаардлага хангахгүй, битүүмж алдагдсан, стандартын шаардлага хангахгүй зуухтай байгаа нь иргэд угаарын хийн хордлогод өртөх гол шалтгаан болж байна аа.

Угаарын хийн хордлогод 2019 онд 2780, 2020 онд 786, 2021 онд 426, 2022 онд 256 иргэн угаарын хордлогод өртсөн мэдээлэл байна аа.

Асуулга 4.

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн төсөлд улсын болон орон нутгийн төсвөөс оруулсан хөрөнгө оруулалт, зарцуулсан зарцуулсан зардал түүний задаргаа.

Тавантолгой түлш ХХК нь 2018-аас 2022 онуудад сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн төсөлд Эрдэнэс Тавантолгой ХК болон БОАЖЯ-аас

нийт 823.6 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд 236.9 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад 586.7 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан.

БОАЖЯ-ны 67.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах медлинг тээвэр, барьцалдуулагч, шуудай угаарын хийнээс урьдчилан сэргийлэх хүрээнд айл өрхүүдэд мэдрэгч болон бортого худалдан авч суурилуулах хөрөнгө оруулалтад зарцуулсан байна аа.

Нийслэлийн төсвөөс сайжруулсан шахмал түлшний тээвэр, борлуулалтын урамшуулал, түлшний хадгалалтын зардал болон хяналт шалгалтын зардалд 2019 онд 14 тэрбум төгрөг, 2020 онд 15.4 тэрбум төгрөг, 2021 онд 26.9 тэрбум төгрөг, 2022 онд 28.8 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ.

#### Асуулга 5.

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг цаашид хэрхэн ажиллуулах тухай болон түүний үр ашиг, нөлөөний талаар.

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийн бүрэн автоматжуулсан бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангаж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, түлшний чанарыг сайжруулах замаар үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тавантолгой түлши ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрт өргөтгөл шинэчлэлт хийж үйлдвэрийн 2 шугамын хүчин чадлыг 50 тонн цагт хүргэснээр нэг тонн шахмал түлшний өртөг 36100

төгрөгөөр буурч үйлдвэрлэлийн зардал 8.6 хувиар буурна аа.

Энэхүү өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэнээр СХД-т байрлах баруун бүсийн үйлдвэрийг үе шаттайгаар зогсоох, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна аа. Цаашид шахмал түлшний түүхий эдийг солих, түүхий эдээр хүрэн нүүрсийг 550-аас 700 градус хуурай пирализын аргаар гарган авсан хагас коксожсон түүхий эдэд шилжих нь агаарын бохирдлыг бууруулах дараагийн арга хэмжээ байна аа.

#### Асуулга 6.

Импортлон оруулж ирэх гэж буй коксожсон нүүрсэнд зарцуулагдах мөнгө түүний задаргааны талаар.

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 132 мянган тонн хагас кокс импортлоно. 2023-аас 2024 оны халаалтын улирлын 12, 1 дүгээр саруудад нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэхээр төлөвлөж байсан боловч нээлттэй сонгон шалгаруулалт удааширнаар дээрх хэмжээний хагас кокс татан авах Тавантолгой түлши ХХК-д хагас кокс шахмал түлши үйлдвэрлэх цаг хугацааны хувьд боломжгүй болсон. Мөн 31.9 тэрбум төгрөгөөр 24.5 мянган тонн хагас кокс болон асаагч худалдан авч Улаанбаатар хотын Хан-Уул, Налайх дүүрэг болон Дархан-Уул аймгийн гэр хорооллын 26825 айл өрхөд нийлүүлэхээр төлөвлөн 2023 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр хагас кокс худалдан авах нээлттэй тендер зарласан ч НЗД-ын хөтөлбөрийн хүрээнд гаргах үнэт цаасыг олон нийтэд санал болгох хугацаа тодорхойгүй болсноор 2023-аас 2024 оны халаалтын улиралд хагас коксожсон шахмал түлши хэрэглэх боломжгүй болоод байна аа.

*Асуулга 7.*

*Импортлох түлшийг иргэдэд борлуулах түгээх схемийн талаар.*

*Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас нийт 24500 тонн хагас кокс худалдан авах бөгөөд үүгээр 20 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэхээр төлөвлөж, үйлдвэрлэсэн түлшийг 2023-аас 2024 оны халаалтын улирлын 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 45 хоногийн хугацаанд Улаанбаатар хотын Хан-Уул Налайх дүүрэг болон Дархан-Уул аймгийн гэр хорооллын 26825 айл өрхөд нийлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хагас коксжсон шахмал түлшийг нэг тонн тутамд 150 мянган төгрөгөөр иргэдэд борлуулахаар төлөвлөсөн боловч 2023-аас 2024 оны халаалтын улиралд хагас коксжсон шахмал түлш хэрэглэх боломжгүй болсныг дурдсан.*

*Асуулга 8.*

*Импортлох түлшний нийлүүлэгч техникийн үзүүлэлтүүд болон ахуйн нөхцөл туршин туршилт, мэргэжлийн байгууллагын өгч буй дүгнэлтийн талаар.*

*2023 оны 2-оос 4 дүгээр сард Тавантолгой түлш ХХК болон төр хувийн хэвшлийн лабораториудад хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилт үйлдвэрлэсэн түлшинд лабораторийн шинжилгээ хийж, галлагааны туршилт хийх, холбогдох үнэлэлт дүгнэлт гаргах ажлуудыг зохион байгуулсан.*

*Хагас коксжсон шахмал түлшний 18 дээжийг лабораторийн түлшинд болон дөл, зуух, ханан пийшинд нам даралтын зуухуудад 97 удаагийн галлагааг хийж туршсан. Хагас коксжсон шахмал түлшийг Монгол*

*Улсад үйл ажиллагаа явуулж буй итгэмжлэгдсэн 5 лабораторид шинжлүүлсэн.*

*Лабораторийн шинжилгээний дүнгээр хагас коксжсон түлшний техникийн үзүүлэлт утаанд агуулагдах хорт хийн хэмжээг медлингээр үйлдвэрлэсэн түлштэй харьцуулахад дэгдэмхий 51.9 хувиар, хүхэр 57.7 хувиар, үнслэг 37.2 хувиар тус тус бага хаягдал утаанд агуулагдах тоосонцрын хэмжээ 72.6 хувь хүхэрлэг хийн хэмжээ 85.5 хувь, угаарын хийн хэмжээ 10.8 хувь, азотын исэл 23.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна аа.*

*Асуулгад хариулж дууслаа.*

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

**Л.Мөнхбаатар:** *Чойжилсүрэн сайдад баярлалаа.*

*Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.*

*Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, НЗД-ын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Одсүрэнгийн Номинчимэг, ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд, ЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батмөнхийн Насантогтох, ЦУОШГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Лхамжавын Оюунжаргал, Тавантолгой түлш компанийн гүйцэтгэх захирал Цэрэнсамбын Даваацэрэн, НЭМҮТ-ийн захирал Сүрэнжавын Өнөрсайхан, Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Баясгалангийн Батшагай, Нийслэлийн агаар орчны*

бохирдолтой тэмцэх газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Баасанжавын Угтахбаяр нар оролцож байна аа.

Асуулгын хариулттай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй. Бат-Эрдэнэ гишүүн, Алтанхуяг, Гочоогийн Ганболд гишүүнээр тасаллаа.

Одоо Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуултаа асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа.

Тэгэхээр зэрэг энэ Улаанбаатар хотын нөхцөл байдалтай холбоотойгоор бид нар ер нь нэлээн асуудлуудыг л гаргаж тавьж байсан л даа. Хэдийгээр хөдөө орон нутгийн тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн ч гэлээ гэсэн тухайлах юм бол энэ гэр хорооллыг хотын салхиныхаа доод тал руу, Налайх, Багахангай чиглэл рүү гэр хорооллыг төлөвлөх тийм бололцоо байх уу гэдэг ийм л саналыг тавьж байсан. Тухайн үед Улаанбаатар хотын удирдлагуудын зүгээс энэ хотын дэд бүтцийг нягтруулах ийм хөтөлбөр ярьж байсан. Энэ бол байж хэрхэвч таарахгүй гэдэг энэ тодорхой Улаанбаатар хотын энэ дагуул хотуудыг байгуулах хэрэгтэй гэдэг ийм саналыг тавьж байсан. Цаашилах юм бол энэ оюутны кампусыг байгуулахтай холбоотой ийм саналыг тавьж нэлээн эрчимтэй ажиллаж байсан ийм хүмүүсийн нэг юм аа. Тухайн үеийн Ардчилсан нам, шударга ёс эвсэл засгийн эрх барьж байх үед Оюунгэрэл, Болд сайд нарын хамт бид нар бүүр Багануурын хуучин дивизийн тэр бүс нутаг руу энэ оюутны кампус байгуулах тухай асуудлыг ярьсан.

Ингээд нэг төрийн бодлого бол тийм залгамж чанар байхгүй тэгсхийгээд л мартагддаг орхигддог ийм зүйл л дээ. Цаашилах юм бол одоо Алтанхуяг Ерөнхий сайдаар ажиллаж байх үед энэ хуралд сууж байна. Тэгээд энэ нөгөө Багануураас нүүрс Улаанбаатарт орж ирээд Улаанбаатар хотын утааны бохирдол нэмэгдээд байсан учраас, нэг.

Хоёрдугаарт бол нөгөө зүүн талаас би Хэнтийгээс наашаа явдаг учраас энэ зам том том машинуудаар няц дараад болохгүй. Тэгээд энэ асуудлыг тухайн үед бас тавьж байсан. Ингээд бол бид нар 2017 оны 11 сард өдөр болгоны нэгдсэн чуулган дээр 2 ажлын хэсгийг байгуулахыг шаардаж байсан. Нэг нь бол энэ Оюу Толгойн ордод Монголын эрх ашгийг хангуулах асуудлыг түр хороо байгуулж энэ ажлын хэсэг байгуулж асуудлыг авч үзье ээ.

Нөгөөдөх нь бол энэ Улаанбаатар хотын агаарын бохирдолтой холбоотой асуудлаар өдөр болгон шаардаж шахаж байж ажлын хэсэг байгуулсан.

Тэгээд ажлын хэсэг байгуулаад Баатарбилиг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг бид нар байгуулаад ингээд ажилд орсон чинь зэрэг нөгөө Цэвэр агаар сангийн хөрөнгө мөнгийг хэчнээн тэрбум төгрөгийг завшаад алга болоод хүмүүс нь шорон оронд ороод алга болчихсон. Нөгөө утаатай дайн зарлах тухай асуудал ерөөсөө бүүр ган хийх хүн нэг ч байхгүй болчихсон. Ийм нөхцөл байдалд манай ажлын хэсэг үзээд 2 хуульд өөрчлөлт оруулаад Улсын Их Хурлаас мөн 2 тогтоол батлуулсан. Нэг нь бол Засгийн газар руу үүрэг чиглэл өгсөн тогтоол батлагдаад ингээд Хүрэлсүхийн Засгийн газар бол түүхий нүүрсийг Улаанбаатар хотод

оруулахгүй тухай ийм шийдвэр гарч энэ сайжруулсан түлштэй холбоотой ийм ажлуудыг.

**Л.Мөнхбаатар:** Ер нь асуулт 3 минутад багтдаг дэгтэй байна өөр дэгтэй хариулъя.

Эрчим хүчний сайд санал юм уу тэ хариулах юм уу? 3 минут шүү. Хариулт нь 5 минут байгаа юм. Тайлбар хангалтгүй гэж үзвэл нэг минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж болно гэж байгаа юм.

Зөвхөн дэгээрээ асуулга тавьсан гишүүн төгсгөлд нь үг хэлнэ. Тийм тэгэхээр 3 минутдаа л багтааж асууна гэсэн үг. Нэмээд нэг минутад авах боломжтой дэгтэй гэсэн үг.

Бат-Эрдэнэ гишүүнийх санал гэж ойлгох уу тэ?

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Улаанбаатарын утаатай холбоотой асуудлаар утаатай утаагүй гэх 2 асуудлаар 2 үнэн гарчхаад байна л даа.

Нэгдүгээрт нь эрх баригчид болохоор утааг яллаа гэсэн 2020 оны сонгуульд утааг ялчихлаа. Гэтэл нөгөө талд нь бодит амьдрал дээр иргэдийн энэ энгийн мэдрэхүйгээр ялсан нөгөө утаа нь улам өтгөрөөд байгаад байдаг, иргэд нь хордоод байдаг бүүр угаартаж тэнд үхээд байдаг. Тэгээд аль нь яг үнэн юм бэ гэдэг асуудал бүх хүний тийм хариулт нэхэж байна л даа. Тэгээд аль нь үнэн юм? Утааг ялчихсан юм уу? Аль эсвэл нөгөө талд нь тэр утаа арилаагүй байгаа гээд байгаа нь үнэн юм уу? Тэгэхээр энэнд л уг нь нэг бас тодорхой зарим мэдээллүүд авах гэж асуулга тавьсан. Асуулгын хариу хэт ерөнхий

ийм л зүйлүүд л ирлээ л дээ. Сүүлд нь тэр шийдэл болоод зүйлүүдийг нь харахаар хагас коксжсон түлш импортоор оруулж ирнэ л гэнэ, туршина л гэнэ. Тэр чинь лабораторид хулгана дээр харах дээр хүртэл туршичихаад амьдрал дээр уг нь хэрэгжүүлдэг бодлого баймаар юм.

Ард иргэд дээрээ туршина гэдэг нь юу гэсэн үг юм. Туршина гэдэг нь утааг ялаагүй гэдгийгээ одоо нотолж байгаа хэрэг юм уу? Гэж ойлгох уу? Дахиад л тэр сүүлд бас 20 мянган айлд халаагуур тавина л гэсэн байна лээ. 2017-оос 2022 онд бараг 40 мянган айлд тавьсан нь одоо 20 мянган айлд тавихад нөгөө нэг эрчим хүч нь хаанаа байгаа юм. Эрчим хүч нь тэг зогсолт болох гэж байна л гэх юм. Нөгөө нэг энэ бүхний чинь цаана нэг л ийм бодлогын шийдлүүд нь яг хаанаа яваад байгаа юм бэ?

Тэгээд энэн дээр нэг ганц 2 асуулт байна л даа. Зөвхөн Тавантолгой түлш компанийн тайланд сонсож байхад 1 их наяд гарны алдагдал яригдаж байна лээ. 800 гаруй тэрбум болчихсон, бусадтайгаа нийлээд 1 их наяд гарчихсан. Зөвхөн сүүлийн сая утааг ялсан тэр үйлдвэрүүд дээр гэсэн үг шүү дээ. Энэ 1 нэг их наядад чинь нөгөө алдагдсан боломж гээд нэг юм ярьдаг, 1 их наядад чинь хэрвээ хамгийн энгийн харьцуулалтаар ипотекийн зээл олгосон бол ипотекийн зээлийн тэр 6, 8 хувийг нь зөвхөн хүүгийн зөрөөг олгосон бол олон 10 мянган айл орон сууцтай болчих байж. Зөвхөн энэн дээр Улаанбаатар хот чинь 180 мянган яндан гэдэг юм байна лээ. Бараг энэний чинь 50 хувийг шийдэх мөнгө тэнд ингээд үргүй зарцуулагдчихаад байгаа юм биш үү?

Тэгэхээр энэ алдагдсан боломжийн нөгөө талд энэнээс илүү шийдэл та нар гаргаж л уг нь бодлого болсон л баймаар юм. Зөвхөн энэ чинь өөрөө 50 хувиар өөрийг нь бууруулчих л



байсан юм биш үү. Тэгэхдээ энд бид нар 1 их наяд төгрөгөөр байшин барих тухай яриагүй. Зөвхөн хүүгийн зөрүү, хүүгийн хөнгөлөлтийн тухай гэдгийг бас тодруулж заавал хэлэх ёстой. Өнөөдөр зөвхөн 2024 оны төсөв дээр ипотекийн зээлийн Монгол банк авна Засгийн газар авна гээд байгаа дээр чинь бараг зуухан тэрбум төгрөгийн л асуудал явж байгаа. Гэтэл нөгөө талд нь ийм их мөнгө үндсэндээ ямар ч үргүй ингээд зарцуулагдчихаад туршилтын тухай ингээд яриад яваад байдаг.

Өөр нэг тэр асуулга дээр гарсан нэг асуулт байсанд хариулт харагдахгүй байна лээ. Ер нь хэчнээн хүн сая 2019 оноос хойш хэчнээн хүн хордож угаартаж нас барчхав. Нас барахын.

**Л.Мөнхбаатар:** Тийм яах вэ дараа нь та тодруулж нэг минут асууж болно. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн асуултад хариулъя аа.

**Б.Чойжилсүрэн:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя аа. Утааг яллаа гэж яриагүй. 2020 оны өмнө утааг бууруулсан нь тодорхой буурсан шүү дээ. Багануурын түүхий нүүрс түлж байсантай харьцуулахад бол бүх тоон үзүүлэлтүүд 2 дахин ба түүнээс ч илүү магадгүй 60, 70 хувь буурсан нь үнэн. Тэгэхдээ энийг бид нар тэгж улс төржүүлмээргүй байна. Хүрэлсүхийн Засгийн газар энэ ажлыг бол маш сайн зохион байгуулсан шүү дээ. Хот даяар бол бүх юу хүмүүсийг Төрийн албаныхныг дайчилсан, хяналт сайн тавьсан, зоригтой том шийдвэр гаргасан үр дүнгээ өгсөн. Тэр жишээлбэл энэ сайжруулсан шахмал түли юу хэрэглэж эхлэхээс өмнө Багануурын нүүрс бараг 1.2 сая тонныг хэрэглэж байсан юм байна лээ. Тэр 2019-өөс 2020 оны өвөл бол галлагааны улиралд 340 орчим мянган тонн

сайжруулсан шахмал түли хэрэглээд утаа бол тодорхой хэмжээнд буусан том үр дүн гарсан гэдгийг бүгд мэдэж байгаа.

Энэ туршина гэдэг үг нь болохоор одоо ингээд медлингээр хийсэн түли маань 340000-ыг жилдээ хэрэглэж байгаа үед бол утаа мэдэгдэм буучихсан байсныг бид бүгдээрээ санаж байгаа шүү дээ. 600000-ыг жилдээ хэрэглээд эхлэхлээр бас тодорхой хэмжээний утааг нэмж бууруулах шаардлага үүссэн учраас энэ хагас кокс гэдэг бүтээгдэхүүнээр медлингийн оронд түүхий эд болоод шахмал түли үйлдвэрлэе гэдэг ийм саналыг орчны бохирдлыг бууруулах үндэсний хороон дээр гаргаад энэ үндэсний хороо дэмжээд Тавантолгой түли компани дээр туршилтыг хийж 80 тонныг оруулж 4 төрлийн хагас коксыг оруулж ирж түли хийсэн. Ийм үр дүнтэй байгаа юм.

Судалгаагаар энд утааны чанаруудыг утаа бууруулдаг нүүрсний бүтээгдэхүүнтэй элементүүд дэгдэмхий тоосонцор эд нар нь бол 50-аас дээшгүй хувь бууж байгаа нь ойлгомжтой байгаа. Ийм л зүйл. Энэ туршина гэдэг үгийг бол зүгээр улс төр ойлгосон юм байлгүй жоохон улс төржүүлээд ингээд буруу тал руу нь мушгиад явчихсан. Гутал үйлдвэрлэсэн ч туршиж үзээд чи нэг гадуур өмсөөд яваад үзээдэх л дээ. Нэг чийг авч байна уу үгүй юу гээд ингэдэг гэдэг биз дээ. 42 размын гутал өмсдөг хүнд 40 размын гутал авааччихаад май энийг өмс гээд гэхгүй шүү дээ.

Тэгэхээрээ тодорхой хэмжээний энэ туршилт Налайх дахь туршилтын арга хэмжээ бол хийхээс ондоо аргагүй. Яг Улаанбаатар хотод тохирсон энэ хагас коксжсон түлж гаргаж явъя гэдэг ийм л зорилго 50-аад явж байсан.

Харамсалтай нь энэ шүүмжлэл дагуулаад байгаа учраас энэ жилийн хувьд бол энэ галлагааны улиралд энэ асуудлууд хэрэгжихгүй болчихсон байгаа гэдгийг хэлье ээ. Энэ

Тавантолгой түли компани их наяд төгрөг зарцуулав гээд ингэж байна. Нэг талаас бас нэг зүйлийг бид нар яг энэ бодит байдалтайгаа ойлгох хэрэгтэй. 1 их наяд төгрөг гээд ингэх юм бол магадгүй өнөөгийн ханшаар 5 мянгаас 6 мянга шахам айлыг орон сууцад аль юу оруулах хэмжээний мөнгө юм байна лээ. 5 мянгаас 6 мянга. Яг өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод бол манай цахилгаан эрчим хүчний хэрэглээн дээр 196 мянга орчим хэрэглэгч байна. Нэг айлд нэг хэрэглэгчийн цаана 2 айл дамнаад хэрэглэдэг гэх юм бол 220-оос 230 мянган айл гэр хороололд байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ 220 мянгаас саяын таны ярьж байгааг 6 мянгыг нь орон сууцад орууллаа гэж бодоход цаана нь дахиад 214 мянган гэр хороолол яндан үлдээд энэ Улаанбаатар хотын утаанд бол дорвитой нэмэр үзүүлэхгүй байсан учраас л энэ түлшийг сайжруулсан шахмал түли үйлдвэрлэсэн ийм л шийдвэр гаргасан юм байна лээ. Бусад бүх улс энд дэлхийн улс орнуудын дагаж яваа жишигийг л дагаж гаргасан шийдвэрүүд байгаа гэсэн үг. Хамгийн богино хугацаандаа бол түлшээ ойрын хугацаандаа бид нар нэг сайжруулаад дунд хугацаанд, урт хугацаандаа бол бүх айлуудыг орон сууцад оруулах чадвал бүгдийг нь газжуулах ийм байдлаар л утааг бүрэн ялах байх. Ийм л шийдэлтэй байна. Бүх улс орнууд энэ замыг туулж өнгөрсөн юм байна.

Бид нар бас Монгол Улсын хувьд яг энэ замаар явчихвал яасан юм бэ гэсэн ийм бодолтой ийм саналтай байна.

**Л.Мөнхбаатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя. Нэг минутад багтаана.

**О.Цогтгэрэл:** Тэр түрүүний асуултаас тэр нас барсан хордсон, угаартсан хүмүүстэй холбоотой мэдээллийг нэмээд өгөөрэй. Төгсгөлд нь сая та тэр 1 их наядаар 5-аас 6 мянган орон сууц гэж та ямар тооцоо хэлээд байна. 5-аас 6 мянган орон сууцыг бүгдийг нь бариад үнэгүй айл оруулах тухай яриа биш шүү дээ. Зөвхөн тэр санхүүжилтийн хүүг нь ипотекийн зээлийг нь 6, 8 гэж байгаа зөрөөний тухайд л би яриада байна л даа.

Тэгэхээр та наад тоо чинь 5-аас 6 мянга биш 50-аас 60 мянга болж гарна шүү дээ. Та энэ тоогоо тодруулж хэлмээр байна. 5-аас 6 мянган байр бариад үнэгүй оруулах тухай яриагүй. Энд хэн ч энэ эрүүл ухаантай хүн өнөөдөр энд яриада суухгүй шүү дээ.

Хоёрдугаарт нь тэр яагаад 2019 онд 300 мянга байж байгаад 2020 онд 300000-ыг хэрэглэж байгаад 2021 онд 600 мянган тонныг түли болж ингээд огцом нэмэгдчихдэг юм.

Энэний чинь цаана арай тэр гадна дотноос түли оруулж ирдэг гэдэг олон янзын яриа энэ үед чинь арай хамаарах юм биш биз дээ? Хятадаас оруулж ирдэг л гэдэг билүү, яадаг ч билээ сошиалаар баахан юм явдаг. Нэг жилийн хооронд.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулъя эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Цогтгэрэл гишүүн ээ. Яг хачирхалтай нь яг ийм тоо гарсан байна лээ. Тавантолгой түли компанийн захирал Даваацэрэн

захирал энд сууж байна. Та жил жилд хэрэглэсэн түшинүүдийн хэмжээг хэлээд өгөөдхөөч? Шалтгаан бол бас эхний жилүүддээ бол тэр хяналтыг их сайн тавьж байсан юм байна лээ. Одоо 2019-өөс 2020 оны галлагааны улиралд бол хяналтыг сайн тавьж байсан. Ажлын хэсгийн 82.

**Л.Мөнхбаатар:** Нэмээд ажлын хэсгээс хариулчихъя. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Дараа нь эрчим хүчний чиглэлээс бас нэг асуулт асуугаад байна шүү дээ тэ 20 мянган халаагуурт ингээд тараахаар ямархуу эрчим хүчний хүчин чадал бололцоонууд байгаа юу гэсэн асуултыг бас асууж байна. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Нэр албан тушаалаа эхлээд хариулаарай.

**Д.Баярболд:** ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Баярболд байна.

НЭМҮТ-ийн Хор судлал шуурхай удирдлагын албанд 2023 оны 1 дүгээр сарын 1-ээс 11 дүгээр сарын 24-ний өдрийн 12 цагийн байдлаар нийслэлийн 7 дүүрэг, 15 аймагт нийт улсын хэмжээнд 2674 хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. Үүнээс эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буцсан 2196, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан 419, одоо хяналтад хэвтэж байгаа 2 хүн байна. Нас барсан хүн 57 байгаа. Ингээд энэ эдгээр 2023 онд тэгээд энэ дээр бид шалтгааныг нь аваад үзээд энэ өртөж ирж байгаа хүмүүсээс шалтгааныг судалж аваад.

**Л.Мөнхбаатар:** Даваацэрэн захирал хариулъя. Ажлын хэсгийн хэд байгаа юм. 82 дугаар микрофон өгье.

**Ц.Даваацэрэн:** Сайн байцаана уу та бүгдийн амар амгаланг айлтгая аа.

Ер нь тоо бол 2019 оноос хойш өнөөдрийн хооронд бол айл өрхийн тоо бол өсчихсөн байгаа. Энэ хэмжээгээрээ дагаад хэрэглэгчийн түвшний тоо нэмэгдсэн. 2019 оны манай хийсэн судалгаагаар бол 159346 өрх байсан 2019 оны өвөл. Энэ манай нэг бодитой худалдаж авсан тоогоор ярьж байгаа шүү дээ манай компанийн 159346, 2019 оны өвөл. Тэгвэл яг өнөөдөр 2023 онд 199868 айлд картаа тараачихсан борлуулалтаа хийгдээд явж байна. 2019 оны тэр 2020 оны шилжих өвөл 159 мянган айлд 360 мянган тонн шахмал түлш борлуулсан яг одоо бол 100, 200 мянган айлд 540000-ыг борлуулж байна.

**Л.Мөнхбаатар:** ЭХЯ-аас хэн хариулах юм? Тэр 20 мянган халаагууртай холбоотой юмыг нь хэн хариулах юм? 84 дүгээр микрофоныг өгчихье. Ажлын хэсэг гүйцээгээд хариулъя.

**Д.Баярболд:** Монгол Улсад 2017 оноос 2023 оны 11 дүгээр сарын 13-ны байдлаар химийн бодисын хордлогод нийтдээ 10746 тохиолдол бүртгэгдсэний 78 хувийг бол угаарын хийн хордлого эзэлж байгаа. 2023 оны 11 дүгээр сарын 23-ны байдлаар 2665 тохиолдол 54 нас баралт бүртгэгдсэн нь бол өмнөх оны үе үеэс 48 хувиар сүүлийн 5 жилийн дунджаас 34 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа. Шалтгааныг нь авч үзвэл иргэдийн мэдлэг, хандлага, дадал дутмаг энэ угаарын хий мэдрэх төхөөрөмжөө салгасан, зуухны битүүмж алдагдах ялангуяа яндангаа хөөлөх, сойлтыг шалгаагүй галлагааны дэс дараалал буруу, энэ бороо цастайд.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг асуултаа асууя. Та дэгээрээ ийм байна. Хариулт 5 минутаас илүүгүй байна. Хариулт нэмж хариулах шаардлага байна гэж үзвэл нэг минутаас илүүгүй байна гэсэн дэгтэй юм. Тийм Норовын Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

**Н.Алтанхуяг:** Энэ Цогтгэрэл гишүүний асуулгад хариулж байгаа юм. Тэгээд би их тодорхой юм асууя, нэгдүгээрт ямар ямар үзүүлэлт нь энэ нийтлэг гэдэг юм төлснөөс хойшоо ямар ямар үзүүлэлтүүд хэвийн байх ёстой хэмжээнээс их болчихоод байгаа юм бэ? Азот, хүхэр, тоосонцор яг энэ 3 дээр хэлчхээрэй. Би тэр 3-ыг л гэж ойлгоод байгаа юм.

Хоёрдугаарт нь тэмээн дээр ямааны гарз гэж одоо энд хэн Даваацэрэн хэл дээ. Танайх энэ 2 үйлдвэр хэдэн тэрбум төгрөгөөр боссон юм? Өнөөдөр би сая орж ирэх замдаа өөрөөс чинь асуухаар 880 тэрбумын өртэй 1 их наядын өртэй тэгээд бас хэдэн тэрбумаар босчихоод байгаа ийм үйлдвэр юм. Энэ дээр нэг тодорхой тоо хэлээд өгөөч.

Гурав дугаарт нь Чойжоо сайд хэлэх юм болов уу? Энэ өвөл яг юу төлөх юм бэ? Маш тодорхой хэлээд өг. Маш тодорхой гэр хороололд яг ийм юмыг нь төлнө гээд хэлээд байна.

Дөрөвдүгээрт нь та нар энэ эрүүл мэндийнхэн хэлээдхээч утаа буурах юм уу? Энэ жил энэ өвөл буурах юм уу буурахгүй юм уу? Яг хариулт яг тодорхой хэл буурна, буурахгүй. Ийм нэг хэдэн асуулт хариулаадах. Бат-Эрдэнэ аварга та дахиад нэг юмыг би ер нь энэ нэхэл хатуутай үзэх гэж байгаа шүү. Энэ өвөлжингөө. 2012 оны 9 сарын 30-нд хагас коксын 210 мянган тонныг үйлдвэрлэдэг үйлдвэр ашиглалтад орох

ёстой. Цоожоо нэмээд хариулчих. Тэр 2 дугаар цахилгаан станцын хашаан дотор барьсан сав байшин хэний мэдэлд байна тэрийг дуудлага худалдаагаар худалд гэж манай засаг шийдсэн юм. Яагаад гэвэл 17 тэрбум төгрөг авчхаад 210 мянган тонн хагас кокс хийнэ гээд чадаагүй байхгүй юу. Тэгээд би энэ Засгийн газрынхаа тогтоолыг аваад ирсэн юм. Тэрийг нь дуудлага худалдаагаар худалд.

Хоёрдугаарт нь шал буруу юм хийсэн. ДЦС-ын 2-ыг нь 1, 5 дугаар зуухыг нь аваачаад өөрчлөөд хагас кокс үйлдвэрлэнэ гэсэн чадаагүй. Тэрийг нь буцааж хэвэнд нь оруул гэдэг манай Засгийн газрын тогтоол байгаа.

Гуравдугаарт нь тэр 17 тэрбум төгрөгөө буцааж төл гэсэн. Энэ ер нь эзэн байна уу? Энэ хэн хийж байгаа юм. Энэ 4 сард манай 5 сард гаргасан юм байна лээ. 11 сард нь нөгөө эхлэхээс өмнө намайг огцруулсан шүү дээ. Тэгээд та нарын түүх ярих гэж байгаа бол энийгээ хэлнэ. Түүнээс Багануурын нүүрс түлээд байсан юм бол байхгүй шүү дээ.

Харин Багануурын нүүрсийг чинь Багануур дээр нь шигшиж авчирч байгаад бүхэл бүтэн нүүрсийг нь авчраад түлж байсан. Ер нь тэгээд энэ хар эрүүл мэндийнхэн хэлчих. Өмнөх юмнаас ямар ямар үзүүлэлтүүд нэмэгдчихээд байгаа юм. Би шууд та нарт нэг хар хэлчихье. Би бас олон хүнтэй уулзъя. Ерөөсөө хүхэр чинь ихэсчхээд байна, хордоод байна хүмүүс үхээд байна. Энэ өвөл энэ хүүхдүүдээ яах юм гэж би асуусан шүү дээ. Ингээд л машиныхаа утаа, хүхрийнхээ хордолтод дуусах юм уу энэ улс орон. Надад энд нэг хариулчихаар би нэмээд асууя.

**Л.Мөнхбаатар:** Ингээд ажлын хэсгээс бас мэргэжлийн хүмүүс нь хариулаарай. Чойжилсүрэн сайд эхэнд нь хариулах юм уу? Сүүлд нь юм уу? Төгсгөлд нь хариулчих. Төгсгөлд нь хариулчих. Ажлын хэсгийн гишүүд хариулъя. Ажлын хэсгийн 88 дугаар микрофоныг өгье. Нэр албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

**Л.Оюунжаргал:** Өдрийн мэнд ЦУОШГ-аас Оюунжаргал. Манайх яг энэ хяналт мониторинг хийдэг байгаа. Улаанбаатар хотын хэмжээнд 18 автомат станц дээр. Түрүүний хэлсэнчлэн яг 4 үзүүлэлтээр нь тоосонцрын РМ-2.5 тоосонцор 2016 онтой харьцуулахад 58 хувиар буурсан байна. РМ-10 тоосонцор 60 орчим хувиар буурсан байна. Хүхэр болохоор харин 2 дахин нэмэгдсэн. Азот болохоороо яг хэвийн хэмжээндээ орчим 39 байсан бол 40 орчимдоо байгаа. Тэгэхээр хүхэр дээр нэг их өөрчлөлт байхгүй. Тоосонцор бол буурсан. Азот дээр өөрчлөлт байхгүй. Хүхэр бол нэмэгдсэн. Нөгөө 2 нь буурсан байгаа. Тэрийг бусад юунууд ярих байх аа.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг өгье. 86 юм уу? 84 юм уу? Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг өгье.

**С.Өнөрсайхан:** НЭМҮТ-ийн захирал Өнөрсайхан байна. 25-аас дээш насны хүн амын цусны даралт ихсэлт өвчний шалтгаан өнгөрсөн энэ 2018, 2019 оны энэ түүхий нүүрсийг хэрэглэж байсан үеийнхийг бодох юм бол буурсан үзүүлэлттэй байгаа. Хүн амын зүрхний шигдээс өвчний нас баралтын шалтгаан мөн энэ өмнөх 2022 онд 1 дүгээр сард хамгийн өндөр байдаг байсан. Өмнөх онтой харьцуулахад бүх саруудад буурсан үзүүлэлттэй байна. 25-аас дээш насны хүн амын уушгины архаг бөглөрөлт өвчний шалтгаант нас

баралтын тохиолдол өндөр хэвээрээ байснаа хэвийн буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөхөөс үзэхэд бол бид нар 25-аас дээш насны хүн амын уушгины хавдрын шалтгаант нас баралт бол хэвийн байна. Өндөр хэвээрээ байна гэсэн энэ 4 үзүүлэлттэй холбоотой өвчлөлүүдийн хоорондын харилцан хамаарлыг гаргасан. Угаарын хий яагаад ингээд өндөр угаарын хийд өртөлт их өндөр байна вэ гэхээр энэ бол нүүрсний чанарын асуудалтай бол хамааралгүй юм байна. Хэрэглээтэй холбоотой байна гэдэг судалгааны дүнгүүд гарч байгаа.

Яагаад гэвэл Налайхад хэрэглэсэн 8 мянган хүн амтай хотод 45 л тохиолдол бүртгэгдэж байгаа. Тэнд угаарын хийн мэдрэгчийг маш сайн байрлуулж авах арга хэмжээг сайн авсан учраас энэ дээр угаарын хийн хордлого бол бүртгэлийн тоо бага байгаа. Улаанбаатар хотод ялангуяа СХД-т бол их хэмжээний хордлого угаарын хийн хордлогууд бүртгэгдээд байгаа нь хэрэглээтэй буюу яндангийн зуухны битүүмжлэл, тэр яндангаа буруу сойлт хийсэн ийм шалтгаанууд гарч ирж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Өөр нэмж оруулах юм байна уу?

Чойжилсүрэн сайд хариулчихъя.

**Б.Чойжилсүрэн:** Цогтгэрэл гишүүний асуултад нөхөөд хариулчихъя.

Цогтгэрэл гишүүн ээ 2019 оноос өмнө яг үнэндээ бол угаартаж байсан хүмүүсийг ингэж тооцоолж олон нийтийн анхааралд өртөж байгаагүй юм байна лээ. Одоо ингээд энэ орчны бохирдлыг бууруулах үндэсний хороон дээр ирээд энэ асуудлаар ингээд

сонирхоод үзэхээр одоо бол сүүлийн жилүүд 2019 оноос хойш нэлээд угаартаж байгаа хүмүүсийн тоо бууж байгаа гэдэг ийм мэдээлэл өгдөг юм байна лээ.

Хоёрдугаарт одоо та өөрөө мэдэж байгаа. Хэрвээ энийг ипотекийн зээлд зарцуулсан 150 сая төгрөгөөр 6 мянган айлд л өгөх байсан нь мөнгө л дөө. 900 тэрбум төгрөг гэдэг маань. 150 сая төгрөгөөр 6 мянган айлд өгөх зөвхөн ипотекийн зээлийн хэмжээ гэсэн үг. Зээлийн хэмжээ гээд ярьж байна шүү дээ. Зээл болгоод өгсөн болбол. Тэгэхээр тэр 50, 60 мянга гэдэг бол худал тоо. Тийм үржигдэх тийм чадвар манай эдийн засагт байхгүй. Тэгэхээр магадгүй тэр 220 мянган гэр хорооллын айл маань 214 мянга л болох байсан байгаа байхгүй юу.

Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Энэ өвөл медлингээр үйлдвэрлэсэн шахмал түлш түлнэ. Урьд нь үйлдвэрлэж байсан медлингээр үйлдвэрлэсэн шахмал түлшээ түлнэ. Утаа буурах тухай яг асуудал дээр бол өнгөрсөн жилтэй харьцуулахад буух уу, эс буух уу гэдгийг урьдчилан хэлэх бололцоогүй байна.

**Л.Мөнхбаатар:** Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье 82 уу тэ? Асуултад хариулаарай.

**Ц.Даваацэрэн:** Алтанхуяг гишүүний асуултад хариулъя.

Манай нийт Эрдэнэс Тавантолгой компаниас манайд өгсөн нийт санхүүжилтийн л 888 гэж би танд хэлсэн. Нийт санхүүжилт энэ нь дандаа зээл явж байгаа. Үүнээсээ 350 тэрбум төгрөг нь бол манайд капиталжих буюу үндсэн хөрөнгө. Энэ нэг үйлдвэрийн бүтээн босголтуудад оруулсан хөрөнгө

оруулалтын ажил явж байгаа. Эхний энэ олон уул хувьцаа эзэмшигчдийн нөгөө хувьцаануудыг ерөөсөө капиталжаагүй учраас энд манай бүх Эрдэнэс Тавантолгойгоос авсан санхүүжилт бүгд өр болж харагдаж байгаа. Үүнээсээ бол нөгөө яг үндсэн хөрөнгө болоод манай 51 хувийг Эрдэнэс Тавантолгой, 39 хувийг Эрчим хүчний яам, 10 хувийг Төрийн өмчийн хороо эзэмшиж байгаа хувьцааг. Гэхдээ энэ хувьцаанууд бол одоогийн байдлаар нэг капиталжиж албан ёсоор нөгөө хөрөнгө оруулалтын зээл маань ингэж хөрөнгө оруулалт болж капиталжаагүй учраас бүгдээрээ л яг өгөх ёстой өр байна.

Гэхдээ яах вэ хөрөнгө оруулалтын зээл гэсэн үг л дээ. 350 тэрбум. 529 нь юу болж байгаа юм одоо манай үйл ажиллагааны алдагдал буюу хуримтлагдсан алдагдал явж байгаа. Энэ хуримтлагдсан алдагдал яагаад их хэмжээгээр ингэж явж байна гэхлээр зэрэг ковидын үеэр бид нар 300 гаран тэрбум төгрөгөөр, 300 гаран мянган төгрөгөөр нэг тонн шахмал түлшийг үйлдвэрлээд зарим айл өрхөд 37.5, зарим айлд 75 мянгаар ингэж борлуулж байсан 2, 3 жил энэний зөрөө алдагдал манайд хуримтлагдсан алдагдал болж ирсэн.

Энийгээ бид нар хэрэгсэл давамгайлалтай энэ бичилтээ хийж шийдээгүй зөвхөн өр хэлбэрээрээ бүгд ингээд явж байгаа. Санхүүжилтийн хувьд дээд 2-ын хаашаан дотор байж байгаа хуучин үйлдвэрийн объектуудыг ТӨХ-ноос манай өнгөрсөн жил манай мэдэлд шилжүүлсэн. Хуучин бол байсан шугамуудыг нь манайх янзлаад энэ ашиглалтад оруулчихсан явж байгаа. 4.3 цаг тооны хүчин чадалтай 2 шугам байсан. Одоо бол 15 цаг тооны хүчин чадалтай 2 шугам ажиллаж байгаа. Энэ жил, тийм. Хуучин объектдоо байгаа, тэр объектыг нь газартай нь хамт ТӨХ-ноос манайх руу өнгөрсөн жил

манайд шилжүүлсэн байгаа бүрэн хүлээж авсан. Тэгээд ажиллаж байгаа 2 шугам.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асууж болно. Нэг минутад багтаана.

Алтанхуяг гишүүн тодруулж асууя.

**Н.Алтанхуяг:** Тэр өөрөө хаанах гэхихлээ 88 цаг уур. Тэгээд энэ Цогтгэрэл гишүүнд ирсэн энэ асуулгын хариу байгаа юм. Энэ дотор ингээж байгаа байхгүй юу. Юу билээ тэгээд уурхайн нүүрсийг түлж байх үед бол ийм байсан юм аа. Болохоор агаарын чанарын үзүүлэлт 50 хувиар буурсан боловчиг азотын давхар исэл 16 хувь, хүхэрлэг хийд 51 микро грамм метр кубээр их байсан гэж байгаа. Одоо өөрийн чинь хариулт дээр зөрж байна. Дахиад би энэ дээр улаанаар тэмдэглэхчлээ.

Тоосонцор хэвийн хэмжээтэй гэсэн чинь энд ингээж байгаа. Сайжруулсан түлш хэрэглэснээр нийслэлийн агаарын бохирдол түүхий нүүрс түлэхтэй харьцуулахад 2 дахин буурсан хэдий ч тоосонцор хүхэрлэг хийн хэмжээ агаарын чанарын стандартаас өндөр хэвээр байна. Тоосонцор гэж нэмэгдэж байгаа. Би тэнд 3 үзүүлэлтээр хэвийн хэмжээнээс хэтэрчхээд байгаа юм байна. Чойжоо сайд энийг та нар медлэнгээ төлөх юм бол өчнөөн хүн дахиж.

**Л.Мөнхбаатар:** Өнөрсайхан даргаас асуусан юм уу? НЭМҮТ-ийн захирал Сүрэнжавын Өнөрсайхан асуултад хариулъя.

Ажлын хэсгийн 88 дугаар микрофон асуултад хариулъя.

**С.Өнөрсайхан:** Энэ нөгөө хэдэн оныг давсан бэ гэдгээсээ хамаараад байгаа байх гэж бодож байна. Би болохоор яах вэ 2022 он жилийн дүнгээр нь танд сая танилцуулчихлаа. Ер нь стандартаасаа ерөнхийдөө дандаа их байгаад байгаа. Гэсэн хэдий ч яах вэ яг тэр нөгөө түлш хэрэглэж байсан кэйс өмнөхтэй харьцуулаад би сая хэлсэн. Тэр нь болохоор нэг нь тоосонцрын чинь РМ-2.5, РМ-10 гээд 2 үзүүлэлтээр хэмжээд байгаа юм. Энэ 2 нь болохоор нэг нь 58 нэг нь 60 орчим хувиар буурчихсан байгаад байхгүй юу хувиар. Хүхэрлэг хий нэмэгдсэн гээд би түрүүн хэлсэн тэ. 2 дахин шахам нэмэгдчихсэн байгаа. Азотын хий дээр болохоор яг юуны өмнө болохоороо 38-аас 39 байсан бол одоо 36-аас 40 байна гэдэг чинь бараг л ойролцоо орчимдоо л гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр манайхаас гарсан. Тэгэхдээ тоо нь жоохон өөр хэзээ авсан бэ гэдгээсээ хамаараад жоохон нааш цаашаа байгаад байгаа байхгүй юу. 2021 оны тоо байж магадгүй байна.

23 оны эхний хэдэн сарынх орчихсон тоо.

**Л.Мөнхбаатар:** Одоо Жамбын Батсуурь гишүүн асуултаа асууя.

**Ж.Батсуурь:** Санал байхгүй зөвхөн асуулт, зөвхөн асуулт. Саналтай гэсэн шүү дээ. Ийм том сэдвийг гуравхан минутад асууна ч гэж юу байх вэ? Гэхдээ энд утааг бууруулъя гэсэн санал санаачилга гэхээсээ илүү бүгд л нэг арьсаа хамгаалсан байдалтай асуудалд хандаж байна аа.

Нөгөө кинон дээр гардаг Баяраа өөрөө ширээн дээрээс унасан гэдэг шиг л. Энэ нас барсан 57 хүн ер нь өрхөө бүтээснээсээ, нүүрсээ буруу түлснээсээ л явсан болохоос л гэсэн л байдалтай хандах гэж байна. Тэгээд ирсэн асуулгын хариунууд өгч байгаа

хариултуудтай чинь бүгд зөрж байна. Тэгээд бас энэ асуултуудыг төөрүүлж байна. Манай түрүүчийн гишүүд гуравхан минутад юу эсийг асуухав. Жишээлэх юм бол 1 их наяд төгрөг, 1 их наяд төгрөгийг Цогтгэрэл гишүүн бүр ойролцоогоор 25-аас 30 сая төгрөгийн дэмжлэг үзүүлчихсэн бол нэмээд 40 мянган айлын орон сууц орчих боломжтой байжээ л гэсэн санааг илэрхийлэнгүүт тавхан мянга шүү дээ гэсэн байдлаар хандаж байна.

Дээр нь та бүхэн энэ их наяд дээр халаагуур, гэрийн дулаалга, зуух яндан, утаагүй нүүрс, сайжруулсан нүүрс гээд бас тийм хэмжээний мөнгийг зарцуулсан. Тэрийгээ зарцуулахдаа дандаа сонгуулийн өмнө жил өгдөг. Одоо та нар зуух яндан тараах гэж байгаа. Ерөөсөө Улаанбаатарын утааг багасгачихъя гэсэн санаагаар биш. Энэ хүмүүсийг нэг энэ жил нэг хуураад өнгөрөөчихье. Энэ сонгуульдаа нэг саналыг нь авчихъя гэсэн байдлаар хандахлаар чинь 57 хүн нас барахгүй яах юм бэ. Сая сайд ярьж байна буураад буураад 57 гэж байна.

Тэгэхлээр өмнөх жилүүдэд 57-оос илүү хүмүүс жил болгон нас барж байсан л гэсэн үг. Тэгээд асуудалд дандаа бодитоор биш хандаж байна. Гадаа утаа буураагүй шүү дээ. 60-аас 70 хувь буурсан гэж аль амаараа хэлж чадаж байгаа юм. Бид нар Улаанбаатар хотдоо төөрөх гэж байна. Утаанд төөрөх гэж байна. Хөдөө яваад ороод ирэнгүүт Налайхын наад уулзвар дээрээс баруун талд орж ирээд шууд зүгээр байгаа хүмүүсийн толгой тархи нь өвдөж байна. Даралт нь ихэсчихнэ. Ингэж байхад хэв нэг одоо энэ телевизээр утаа 60-аас 70 хувь буурчихсан, өвчлөл буурчихсан, тэр дотор нь байдаг хими янз бүрийн хортой бодис нь буурсан гээд ингээд худлаа яриад байгаа юм.

Асуудлыг даван туулах хэмжээнд бид нар яг ийм ажил хийж байна аа.

Дээр нь халаагуур тарааж байна. Монгол Улс цахилгааны эх үүсвэргүй гээд сайд нь зарлаад байгаа шүү дээ. Тэгээд хотод яагаад халаагуур тарааж байгаа юм? Эх үүсвэргүй юм бол нэгдүгээрт.

Хоёрдугаарт хотод халаагуур тараачхангуутаа зүүн бүсийг цахилгаанаар хязгаарлаж байна. Чи үхэхээс би үх гэсэн байдалтай хандаж байна. Тэгэхлээр энэ алсын хараатай төрийн бодлого биш байна. Алсын хараатай. Тэгэхлээр яг бодит байдлаар бодит байдлаар бид нар 2024 оны эцэс гэхэд бид нар хүн үхүүлэхгүй. 2023-аас 2025 онд хүн үхүүлэхгүй гэсэн ийм бодит та нар.

**Л.Мөнхбаатар:** Жамбын Батсуурь гишүүний асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Батсуурь гишүүн ээ их наяд шахуу төгрөг зарцуулагдаад байгаа нь үнэн. Харамсмаар их мөнгө мөн. Сая Цогтгэрэл гишүүний асуултад би хариулахдаа айл болгонд 25-аас 30 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхэд бас орон сууцтай болохооргүй юм байна лээ л дээ. Тэгэхээр энэ дээр одоо хэдүүлээ маргаад яах вэ. Утаа буурсан буураагүй талаар бас маргаад яах вэ. Тэртээ тэргүй сонгууль болох гэж байгаа юм чинь бид нар бодит байдалд Багануурын нүүрстэй харьцуулахад буучихсан нь ойлгомжтой шүү дээ.

Халаагуур тараах талаар бол ингэж байгаа мэдээлэл Орчны бохирдлыг бууруулах үндэсний хурааг сая 11 сарын 1-ний өдөр татан буулгасан. Тэгээд 1 сарын 1-ээс



Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудлыг Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газар хариуцахаар болж байгаа. Тэгэхээр энэ халаагуурын талаар бол хотын орлогч дарга Номинчимэг байгаа. Та нэмэлт мэдээлэл өгчих үү?

Асуултад нэмж хариулъя. Номинчимэг дарга хариулъя. Хэд байна танайх ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**О.Номинчимэг:** Батсуурь гишүүний асуултад хариулъя.

Бид нар хотын шинэ удирдлагын баг ингээд томилогдоод сар гаруйхан хугацаанд ажилдаа ороод мэдээж нийслэл хотынхоо иргэдэд тулгамдаж байгаа энэ асуудал руу анхаарал хандуулж ажиллаж байгаа. Тэгээд бидний хувьд бол мэдээж энэ үр дагавартай нь үзэгдэлтэй нь тэмцэхээсээ илүүтэйгээр учир шалтгаантай нь тэмцэж түүнийг бууруулах чиглэлийн бодлогоо гаргаад явж байгаа. Энэ маань бид нарын дэвшүүлж байгаа гэр хорооллыг орон сууцжуулах бодлого 2024 оноос 2025 онд бид энэ Сэлбэ дэд төв, Баянхошуу дэд төв дээрээ түшиглэсэн орон сууцыг барихаар үүнтэй холбоотойгоор бид нэгж талбаруудыг чөлөөлнө. Газар чөлөөлөлт явагдана. Эхний ээлжид Сэлбэ дэд төв дээр 12 мянган айл өрхийн орон сууцыг барих энэ төслийг санаачилгыг гаргаад хуулийн төслөө бас боловсруулаад Улсын Их Хуралд ингээд хэлэлцүүлээд явж байгаа.

Ер нь бид энэ утаатай бол яндангаа цөөлж байж нүүрснээсээ салж байж л хамгийн зөв шийдэл бол тэр байгаа. Тэгэхээр нэн тэргүүнд бидний бодлогын чиглэл бол гэр хорооллыг орон сууцжуулах түүнд тохирсон дэд бүтэц хэсэгчилсэн дэд

бүтцүүдийг тавих гэсэн ийм чиглэл рүү явж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй. Халаагуур тарааж байна гэж байна. Энэ бол ташаа мэдээлэл ээ? Ер нь бид нар бас айл өрх хүүхдүүдийнхээ судалгааг шууд хийж нөхцөл байдалтай танилцаж байгаа. Одоо гэр хороололд маань түрүүн Чойжилсүрэн сайдын хэлснээр ерөнхийдөө 196 мянган орчим цахилгааны гэрээтэй. Бодит амьдрал дээр бол 220-оос 230 мянган айл өрх бол ингээд амьдарч байгаа гэсэн тооцоолол байдаг.

Эндээс бол одоогийн байдлаар 10 гаруй мянган айл өрх бол бүрэн цахилгаан халаагуур руу өөрөө шилжсэн байна. Энэ бол өөрөө зах зээлийн жамнаараа айл өрхүүд маань өөрөө яндангаасаа татгалзаад цахилгаан халаагуур хэр хэрэглэх энэ чиглэл рүү өөрсдөө явсан байгаа.

Тэгэхээр энэ бол өөрөө жам ёсоороо явж байгаа. Айл өрхүүдийн шилжилт юм. Нийслэл хотын зүгээс бол одоогоор цахилгаан халаагуур тараагаагүй байгаа. Үндэсний хороо Орчны бохирдолтой тэмцэх үндэсний хорооноос бас санаачилга гаргаад 2017 оноос хойш энэ гэр хороолол дахь шугам сүлжээ цахилгааны дэд бүтцүүдийг сайжруулах төсөл 3 үе шаттай хэрэгжсэн. Энэ төслүүдийн хүрээнд тэр гэр рүү орж байгаа од шугам сүлжээг сайжруулаад цахилгаан халаагуур тавих энэ судалгаа шинжилгээ хийгээд энэ төсөл нь явж байсан. Энэ үндэсний хорооны татан буулгах чиг үүрэг нь манайтай ирж байгаатай холбогдолтойгоор бид нар бол энийг судалж одоогоор бол судалгааны түвшиндээ ер нь бол цахилгаан халаагуур эрчим хүчний эх үүсвэрээрээ айл гэрийн дулаан цахилгааныг шийдэх нь яндангаа цөөлөх, нөгөө талаараа утаагаа бууруулах шийдэл болох юм

гэдэг байдлаар ингээд тооцоо судалгаа гаргаад явж байгаа юм аа.

**Л.Мөнхбаатар:** Асуулт асууж хариулт авлаа. Та тодруулах юм уу? Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууя.

**Ж.Батсуурь:** Би ингээд зарим хариултуудыг чинь ойлгохгүй байна л даа.

57 хүн нас бараад нас баралтын тоо нэмэгдээд байхад утаа буурсан 70 хувь буурсан гээд гүрийгээд байгаа байхгүй юу. Дээр нь энэ хордлогод орсон хүмүүсийн чинь тоо нэмэгдээд байна шүү дээ. Тэгэнгүүт утаа багассан гээд байх юм, нэгдүгээрт. Энэ чинь ганцхан минут болохлоор бас л асууж болохгүй байна л даа. Дээр нь цахилгааны эх үүсвэр байхгүй ээ. Монгол Улс зарим газраа хэрэглэ та нар ингээд цахилгаанаа хэмнэ гээд байгаа юм. Хөдөө орон нутгийг хязгаарлаж байна. Тэгэнгүүт Улаанбаатар хотыг цааш нь цахилгаан руу оруулна гээд байх юм. Тэгээд чи үхэхээс би үх ер нь хөдөөг таслаад хотыг цахилгаанаар халаачихъя гэж байгаатай ингээд бодлого нь зөрөөд байгаа байхгүй юу.

Би шинэ удирдлагын багийг дөнгөж ажлаа авч байгаа ойлгож байна. Гэхдээ энд ерөөсөө цахилгааны ямар ч илүүдэл зүйл байхгүй. Бид одоо ингээд дууслаа гэж байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөө нөгөө талд нь нөгөө гараараа болохлоор цахилгаан.

**Л.Мөнхбаатар:** Чойжилсүрэн сайд тодруулгад нэмж хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Батсуурь гишүүн ингэж байгаа. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад энэ жилийн хувьд цахилгаан эрчим хүчний тухайд шүү. Дунджаар 86 мвт- аар өндөр явж

байна. Өчигдөр жишээлбэл 1483 мвт-аар болж өссөн. Өдөр өдөртөө нөгөө өнгөрсөн жилийн мөн үетэй одоо бид нар энэ 27-ны өдөр 11 сарын 27-нд энэ сонгино дэд станц дээр байгаа цэнэгт хураагуурыг 80 мвт-аар оргил ачаалалд оролцохоор цэнэглэж эхлэх гэж байна. Энэ ажил хийгдээд явах юм бол бас тодорхой хэмжээний эх үүсвэр ингээд өсөлтийг бол нэмэгдэнэ.

Хоёрдугаарт Дорнодын эрчим хүчний Дорнодын цахилгаан станцын өргөтгөл 50 мвт-ын ажил явж байгаа. Хятадын хөгжлийн банк санхүүжилтээ зогсоогоод манай Хөгжлийн банктэй холбоотой сөрөг мэдээллүүд их гарсан учраас бол.

**Л.Мөнхбаатар:** Ингээ Чойжилсүрэн сайд нэмээд хариулчихъя. Нэг минутад багтаагаад. Сая тэр зүүн аймгуудын эрчим хүчийг хязгаарласантай холбоотой асуулт асуугаад байгаа юм байна.

**Б.Чойжилсүрэн:** Зүүн аймгууд дээр удахгүй Дорнодын цахилгаан станц 50 мвт-ын өргөтгөл ашиглалтад орно оо. Тэгэхээр энэ ерөнхийдөө бид нар бол энэ өвлийг бол нэг энэ 2 эх үүсвэрээр нэмж давах байх. Ирэх жил 3 дугаар улиралдаа багтаад Бөөрөлжүүтийн цахилгаан станцын нэг блок 150 мегаваттын блок ашиглалтад орно. 2025 оны 5 сард дахиад нэг блок ашиглалтад ороод ерөнхийдөө тэр 2025 оны 5 сараас эхлээд Монголын эрчим хүчний системд суурилагдсан хүчин чадал нь хэрэглээгээ нэг жоохон гүйцээж урд нь орж эхлэх ийм л дүр зураг байгаа юм. Хязгаарлахгүйг хичээнэ ээ.

**Л.Мөнхбаатар:** Дараагийн гишүүн асуултаа асууя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Агаар орчны бохирдол, түгжрэл гээд олон зүйлийг бид нэлээдгүй урт хугацаанд ярьж байгаа юм. Холбогдох арга хэмжээнүүд авагдаж байгаа. Зарим талаар арай дээр нааштай гэж хэлж болмоор үзүүлэлт гарч байгаа.

Зарим талдаа дор ч үзүүлэлт гарч байгаа. Бидний алдаа юунд байсан бэ гэхээр зэрэг аливаа зүйл өөрөө даацтай чадамжтай байдаг юм гэдгийг ерөөсөө тоогоогүй улс байхгүй юу. 500 мянган хүн амтай хот байна гэж тооцсон бүх төлөвлөлтийг эвдээд 1.5 сая хүнтэй болтол нь төвлөрлийг бий болгосон нь энэний том гажиг. Ерөөсөө угаасаа. Аливаа асуудал хүндэрлээ гээд л юмыг шийдэх ёстой гээд л энд нь асуудлуудыг нэмж шинэчлэх замаар яваад байсан нь улам энэ хүндрэх асуудлуудыг ужгируулсан юм аа. Одоо энэ алдаагаа засах гэж оролдож байгаа. Засах ёстой. Энэ их том төвлөрлийг задлах ёстой. Тэгж байж наадах чинь бас нэг ийгээс арай дээр болно л гэж ингээж хараад байна.

Тийм учраас энэ орон нутгуудынхаа хөгжлийг хангаж тэнд таталцал бий болгох замаар наашаа явдаг урсгалыг нь ядаж зогсоогоод эндээс нь жоохон зөрүүлээд урсгал гаргавал арай л дээр л болно доо. Би тэгж л хардаг юм. Юм ярьж болно байшин ч барьж болно, систем ч холбож болно. Энергийн чинь эх үүсвэр хаа байна аа? Цахилгаан дулааны чинь эх үүсвэр байна уу? Тэрийгээ даах юм уу? Тийм учраас би юу гэж хэлэх гэж байна гэхээр зэрэг Улаанбаатар хотын агаар орчны бохирдлыг бууруулъя гэж ярих гэж байгаа бол хэдүүлээ энэ төвийн эрчим хүчнийхээ системийг

хэдэн он гэхэд хэдэн мегаваттаар нэмэгдүүлж чадах юм. Тэрийг дагаад хэчнээн орон сууц барьж болох юм бэ? Тэрүүнийг дагуулаад хэдий хэмжээний шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл хийж чадах юм гэдэг юмаа л хооронд нь уялдуулж зөв төлөвлөж байж энэ бодитой ажил болно.

Бид нарын эрхэм зорилго ерөөсөө л энэ. Тэгэхээр энийг хийх гэж байгаа юм гэж хэлээд ганц том юм ярьчихаад энэ иргэдийн эрүүл мэндээр тоглоод суугаад байж таарахгүй ээ. Тийм учраас тэр мартагдаагүй хуучин юм байна уу? Мартагдсан хуучин юм байна уу? Шинэ юм байна уу? Агаар орчныг бохирдуулж болдог бүхий л арга хэмжээнүүдийг тодорхой тодорхой хэлбэрээр нь авч хэрэгжүүлэх ёстой. Энэ түлшнийхээ бүтцийг ч сайжруулах л ёстой. Түлж байгаа зуухныхаа нөхцөлийг ч л сайжруулах ёстой. Байж байгаа эх үүсвэрийнхээ нөөцөд тулгуурлаад нэг хэсэг дээр нь цахилгаан халаадаг юмыг ч л бий болгох ёстой. Тодорхой дулааны нөхцөл байдлынхаа нөөцийг шавхаад зарим дээр нь дэд төвүүд байгуулах замаар энийг нь ч хийх л ёстой. Нөгөө талд нэг анхаарах ёстой зүйл. Энэ Улаанбаатар хотын гэр хороолол яндангийн тоог ядаж нэмэхгүй, тэгээд бууруулах арга хэмжээ авахгүйгээр бид.

**Л.Мөнхбаатар:** Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн асуултад хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Батжаргал гишүүний асуултад хариулаад аягүй үнэтэй зөв саналууд хэлсэнд талархаж байна. Батжаргал гишүүн ээ 2035 он хүртэл бид нар цахилгаан эрчим хүчний тухайд тааз хийж үзлээ. Одоо бид нар 1264 мвт-ыг бол нөгөө түлшний юу нүүрсний цахилгаан станцууд дээрээ 300 гаруй мегаваттыг нь бол сэргээгдэх дээр ингээд оёчихсон байна. 2035 он

хүртэл манай цахилгаан эрчим хүчний хэрэглээ одоо байгаагаасаа 2.4 дахин нэмэгдэх юм байна лээ. Тэгэхээр энэ хэрэглээг нэмэхийн тулд бид нар ямар эх үүсвэрээр энэ шаардлагууд цахилгаан эрчим хүчийг хангах вэ гэдэг ийм тооцоолол хийгээд явсан. Одоо хамгийн эхний ээлжид энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станц 2024 ондоо багтаагаад нэг блок нь 2025 ондоо багтаагаад нэг нь орчих юм байна 300мвт. Дахиад энэ цахилгаан хөрөнгө оруулагч нар нь дахиад 300мвт-ын 2 блок барья. Зөвшөөрөл өгөөдхөөч гээд ярьж байна. Бид нар энийг судлаад явж байна.

Гуравдугаарх нь Тавантолгойн цахилгаан станцыг 300мвт 150, 150-аар 2 гээд ингээд 300мвт-ын асуудлыг яриад явж байна. Гендер нь зарлагдсан 2 оролцогч орж ирээд харамсалтай нь хоорондоо шүүхдэлчихлээ. Энэ асуудал ингээд нэг удахгүй нэг талдаа гараад явчих байх.

Багануурын цахилгаан станцыг 700 мвт-аар нэмэгдүүлэх ажил явж байгаад зогсчихсон байсан. Одоо буцаад сэргэсэн. Шинэ хөрөнгө оруулагч нар идэвхтэй 2 шинэ хөрөнгө оруулагч нь идэвхтэй ирж уулзаж байгаа. Энэ бол 2026 ондоо багтаагаад эхний 400, 200-гаар 2 блокийг нь ашиглалтад оруулчихъя. Үлдсэн 300-г нь бол 2029 юм уу 2030 онд ашиглалтад оруулна гээд. Ийм байдлаар бид нар цахилгаан эрчим хүчний хэрэглээг бол хангачих юм байна.

Баруун бүсдээ бол Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц ажил нь ингээд гэрээ нь зурагдаад ажил нь эхэлж байгаа. Зүүн бүсдээ Дорнодын цахилгаан станц ашиглалтад орж байгаа гэх мэт төслүүд явж байгаа. Одоо хамгийн хүндэрсэн сэдэв бол Улаанбаатар хотод бол хамгийн тулгамдсан сэдэв бол Улаанбаатар хотын дулаан хангамж хүрэлцэхгүй

байгаа. Энийг нэмэгдүүлэх тал дээр ТЭЦ 3-ын өргөтгөлийг ярьж байгаа. ТЭЦ 2 дээр дахиад 300мвт-аар цахилгаан 340 мегаваттаар дулааны хэрэглээг нэмэгдүүлье гэсэн ийм ажлууд хийгдэж байна. Амгалан дулааны станц дээр 116 гига килокалори цаг өргөтгөлийг энэ 1 дүгээр сардаа багтаагаад 2024 оны 1 дүгээр сард багтаагаад бид ашиглалтад авахаар ийм ажлууд хийж байгаа.

Тэгэхээр одоо бидний энэ юу нэмж бий болох цахилгаан эрчим хүч, дулааны хэрэглээг бид нар ингэж огцом нэмэгдүүлэхгүй бол бүх авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд үр дүнгүй болно. Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

**Ж.Батжаргал:** Тийм учраас л нэг ойрын 3 жилд гэдэг юм уу тов тодорхой энэ эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх тэрнийг дагасан бүтээн байгуулалтуудыг хийх төлөвлөлтөө тодорхой болж хөрөнгө санхүүгийнхээ эх үүсвэрийг тэр рүүгээ чиглүүлэх зайлшгүй шаардлагатай. Энэ дээр бол ёстой үндэстнээрээ нэгдэх ёстой гэж би ингэж л ойлгодог, нэг.

Хоёрдугаарт нөхцөл байдал үнэхээр ийм. Ийм хүнд байна. Наад хүхрийн чинь үзүүлэлт үнэхээрийн тэгж өсчхөөд байгаа юм бол энэнээс иргэд урьдчилан сэргийлэх чиглэлээр юу хийж болох юм. Тэр мэдээлэл юмнуудаа олон түмэндээ сайн өгмөөр байна. Энэ хүүхэд багачууд, энэ өтгөс буурлуудыгаа бас нэг арай эрүүл агаартай нөхцөлд амьдрах бололцоог нь бүрдүүлж зарим тохиолдолд энэ сургууль юмнуудынхаа хичээллэлт юмнууд дээр зохицуулалт хийх ёстой. Тэгж байж л бид энийг дайна шүү дээ. Нэгэнт бий болчихсон байгаад байгаа юмыг. Өнөөдөр.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулах уу? Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг өгье. Асуултад хариулъя.

**Л.Оюунжаргал:** Энд ерөөсөө яригдаад байгаа зүйл маань тэр 2.5, 10-ын бохирдол хаанаас үүсдэг юм гэхээр нүүрснээс үүсээд байгаа юм. Тэрний бохирдол бол нэгэнт нь сайжруулсан нүүрс хэрэглэсэн тохиолдолд арилад тэрний дагасан өвчлөл буураад байгаа юм. Гэтэл тэрийг дагаад нөгөө SO<sub>2</sub>-ын асуудал яриад байна. Хүхрийн оксид. Тэр маань өөрөө ямарваа нэгэн юманд шатааж л байгаа бол үүснэ. Юу ч шатаасан үүснэ.

Ямар нэгэн л бүтээгдэхүүн ч түлээд л байвал үүсээд байна. N<sub>2</sub> нь хаанаас үүсдэг юм гэхээр автомашины утаанаас үүсээд байгаа юм. Тэр эх үүсвэр чинь байгаад байгаа. Бид нар юм шатаагаад л байвал хэчнээн технологио сайжруулаад байсан ч гэсэн л үүсээд байна. СО угаарын хий хаанаас үүсээд байна вэ гэхээр нөгөө нүүрстөрөгчийнх нь агууламж түлш нь сайжраад байхаар ихсээд байдаг тэрэнд дагаварлагдаж байгаа хүчилтөрөгчийн агууламж өндөр ороод тэгээд нөгөө хэрэглээн дээрээ үүсээд байгаа.

Тэгэхээр 1 сард хамгийн өндөр үүсдэг. Ерөөсөө бид нарын судалгаануудаас бас харагдаад байгаа. Хүйтний улирал хэрэглээтэйгээ холбоотой. Тэгэхээр бид нар энэ нэг сард бол угаарын хийн хордлогын асуудлууд.

**Л.Мөнхбаатар:** Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууя.

**Н.Ганибал:** Өнөөдөр уг нь энэ утааны асуудлыг ярьж байхад Нийслэлээс сонгогдсон Их Хурлын гишүүд маань байхгүй байна. Ганицхан манай Оюунчимэг гишүүн бас

Жамбалын Ганбаатар гишүүн 2 л байж байна л даа. Гэхдээ Оюунаа чи ингээд утаа маш сайхан байна. Алга болсон ингээд энэ Засгийн газрыг магтав аа. Яагаад гэхээрээ яг энэ 4 жилийн өмнө утааг ялсан гээд та хэд маань сонгогдсон байхгүй юу даа. Нэн ялангуяа Нийслэлээс сонгогдсон МАН-ын гишүүд бол баясгалантайгаар инээмсэглэсэн зургууд нь хүртэл одоо байгаа шүү дээ. Тийм фэйсбүүк ухаад үзэх юм бол. Одоо тэгээд тэрэндээ ингээд ханачихсан ингээд суугаад ингээд энэ өнөөдрийн хуралд суухгүй байгаа байхгүй юу. Энэ уучлаарай би дараа нь энэ асуудлуудаа ярих байх. Тэгээд уг нь яг Оюунчимэг шиг ингээд бүгдээрээ суугаад, энэ асуудлуудаа яриад, энэ болохгүй байгаагаа өнөөдөр шийдэх ёстой байхгүй юу? Ярилцах ёстой, тэгээд харамсалтай байна. Тэр хүмүүс өнөөдөр утааг ялан дийлсний үр дүнд гишүүн болсон хүмүүс шүү дээ. Тэгээд өнөөдөр энэ нөхцөл байдал нь тэр тухайн үеийн нөхцөл байдлаасаа дордсон байна аа.

Энэ шийдлүүдийг улам сайжруулаад явах ёстой хүмүүс маань өнөөдөр энэ танхимд нэг ч алга.

Хоёрт нь, хамгийн гол асуудал нь тэр үед одоо тэр утаа ялсныг Монгол даяар л өөрсдөө яриад, баахан троллууд ажиллуулаад, бараг л ер нь одоо ер нь Энх-Амгалангийн оронд очлоо гээд бүгдээрээ л ярьсан шүү дээ тэр хүмүүс. Тэгээд өнөөдөр энэ асуудал нь хүндрэнгүүт зугтаадаг нөгөө фронтоо хаяад зугтаадаг ийм л хүмүүс болчихлоо. Энэ асуудлуудыг ер нь хэн ярилцах ёстой юм, хэн шийдэх ёстой юм? Хэн ард түмний төлөөлөл юм? Энэ асуудал байна. Үнэхээр бас эмгэнэлтэй байна аа.

Тэгэхээр энэ асуудлууд дээр бид нар мөн чанарыг нь ярих гээд зөндөө оролдчихсон л доо. Та нар ингээд зөвхөн

ингээд сошиалаар ингээд утаагүй өдрийн зураг авчхаад тэрийгээ ингээд утаа ариллаа гээд тавиад байна, наадах чинь буруу. Энэ чинь хэдий ингээд түли ашиглаж эхэлснээс хойших тэр хүхрийн исэл чинь нэмэгдээд энэ эрүүл мэнд үхлийн нэмэгдэл чинь ихсээд байна. Энийгээ та нар яагаад тооцохгүй байгаа юм бэ? Зөвхөн үзэгдэх харагдах байдалд нь анхаараад яг бодит тэр хор хөнөөлийн асуудлыг яагаад ярихгүй байгаа юм бэ гэсэн бид нар өнөөдөр бүгдийг нь ингээд шийдсэн л гээд байсан.

Харамсалтай нь өнөөдөр бодит цаг хугацаатайгаа ингээд нүүр туллаа. Өнөөдөр бас хөршөөсөө энэ түли оруулж ирэх асуудлыг ярьж байна. Тэр үед ч гэсэн ер нь өмнөд хөршөөс ер нь түли оруулж ирээд та бүхэн маань тараачихсан юм биш үү. Яг сонгуулийн өмнө. Тэр чинь бараг батлагдаж байна шүү дээ. Энэ яагаад ингээд үйлдвэрлэсэн түлиний хэмжээ жилийн дотор 2 дахин нэмэгдэв гэдэг асуудал чинь хүртэл энэ асуудлын маань гогцоо байна шүү. Энийг ер нь бол энэ шалгуулмаар байна. Шалгах ёстой нэг сэдэв энэ мөн байна даа.

**Л.Мөнхбаатар:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн хариулъя. Ажлын хэсэг нэмж болно.

**Б.Чойжилсүрэн:** Ганибал гишүүн ээ энэ тэр 2019 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ энэ шахмал түли үйлдвэрлэдэг бол гарцаагүй үр дүнгээ өгөөд ард түмэн тэрийг үнэлсэн гэдгийг та өөрөө яриад байна шүү дээ. Тэгэхээр одоо энийгээ маргахаа больё. Том нэг алхам хийчихсэн. Сайн алхам нэгийг хийчихсэн. Одоо бид нар таныг 2 дахь юу шүүмжлэлийг хүлээж авч байна.

Одоо дахиад энэ түлиээ дахиад сайжруулах хэрэгтэй, дахиад хөгжүүлэх хэрэгтэй. Энэ дээр бол цаг алдсан юу зүйл байгаа. Энэ шүүмжлэлийг бол бид нар хүлээж авч байна.

Хоёрдугаарт тэр үхэл нэмэгдсэн гэж яриад байна. Үхэл нэмэгдээгүй. Угаартсан хүмүүсийн тоо нэмэгдээгүй. Тэр урьд нь бол энэ шахмал түли үйлдвэрлэхээс өмнө бол энийг тийм тусгайлан тийм юу нэмэгдсэн гэж яриагүй буруу мушгиад байх шиг байна. Тийм юм байгаагүй. 2019 оноос бол буурсан уу л гэхээс биш нэмэгдээгүй.

**Л.Мөнхбаатар:** Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууя.

**Г.Ганболд:** Манай манай АН-ынхан жоохон шийдэл л яримаар байгаа юм л даа. Зовлон яриад байх юм бол хажуудаа сууж байгаа сая Алтанхуяг гуайгаас та нар асуух ёстой юм байгаа юм шүү дээ. Алтанхуяг гуай бол Ерөнхий сайд байхдаа яг энэ зовлон дундуур нь өөрөө ороод гарсан хүн ингээд шал шал гээд суугаад байгаа нь надад инээдтэй сонсогдож байгаа юм. Тухайн үедээ хамгийн их мөнгө зарсан Засгийн газар бол Алтанхуяг Ерөнхий сайдын Засгийн газар шүү дээ. Цэвэр агаар сан гэж байсан. Хэдэн 100 тэрбум төгрөгийг тухайн үед нь ямар ч өргүй зарцуулаад тэгээд хэдэн хүн шоронд яваад дууссан шүү дээ. Та нар мэдэж байгаа шүү дээ.

Хийсэн ажил нь юу гэхээр зэрэг хэдэн зуух авчирсан. Тэгэнгүүтээ тэрэндээ түлэх гэж Багануураас баахан цэргүүдээр нүүрс шигшүүлж авчирч түүхий нүүрс түлүүлсэн. Ямар ч үр дүн байхгүй. 2019 он гэхэд ер нь бол та бид нар мэдэж байгаа шүү дээ. Өмнөх машинаа хардаггүй л байсан шүү дээ. Би хөдөөгөөс орж ирэх гээд л энэ 22-

ын товчооны хавьцаа бол өмнөх машинаа мөргөчих гээд л явж байсан.

Энэ дээр бол сайжруулсан түлш дээр үр дүн гарсан уу гарсан. Одоо бол харин энэ манай ажлын хэсгийнхэн ер нь энэ Улаанбаатар хотын хүн амын тоо хэрэглээ хэр нэмэгдэж байгааг бас давхар ярих ёстой байхгүй юу. Энэ азотын хий, хүхрийн хүчил нэмэгдээд байгаа юм чинь хэрэглээ нэмэгдээд байвал тэр чинь нэмэгдэнэ шүү дээ. Тэгээд энэ чиглэлийн юмнуудыг бас нэг жаахан яримаар байгаа юм аа.

Тэгэхээр би Чойжилсүрэн сайдаас хоёр, гуравхан зүйл асууна аа. Орчны бохирдлын үндэсний хороогоо яагаад татан буулгачхав аа. Энэ агаарын бохирдол чинь ерөөсөө ганцхан Улаанбаатар хотын асуудал биш шүү дээ энэ чинь. Аймгийн төвүүдийн агаарын бохирдол бас л Улаанбаатар хот шиг боллоо. Энэ Үндэсний хороогоор чинь 5 төгрөг шийдүүлээд тэрний дийлэнхийг нь Улаанбаатар хотод зарахаас гадна тодорхой хэсгийг нь орон нутаг руу өгч байсан юм аа.

Тэгэхээр энэ Үндэсний хороо татан буугдчихаар одоо ингээд хөдөө орон нутгуудыг ингээд хаячхаж байна уу? Энийг хариуцах эзэн тэрэнд тавих хөрөнгө мөнгө ер нь хаана байх вэ? Улаанбаатар руу 27.5 тэрбум төгрөгтэй нь тэгээд хот руу энэ хороог нь татан буулгаад явуулчих шиг л боллоо гэж би ойлгоод байгаа юм.

Сая төсвийн үеэр энэ орон нутгийн асуудлын хөрөнгө мөнгө нь ер нь хаанаас олдох юм яаж шийдэх юм. Энэ дээр та нэг тодорхой хариулт өгөөч.

Хоёрдугаарт нь би Энэ Хятадын Элчин сайд Хятад улсад байгаа Монгол Улсын Элчин сайдад би нэг хүсэлт өгсөн

юм аа. Агаарын бохирдлыг нь Улсын Их Хурлын түр хорооны даргын хувиар Хятадын бас энэ ТӨК энэ агаарын бохирдлыг шууд явуулын машинаар ингээд хэмждэг тэгээд Монгол Улсад бус ба замын хүрээнд 4 машин үнэ төлбөргүй хамаагүй нэг нь тэрбум орчим төгрөгийн өртөгтэй машин өгье гээд Түр хорооноос бид нар албан ёсны бичиг явуулаад тэгээд Хятадын Элчин сайдыг нэг тэр газарт нь албан ёсны бичиг өгчих гэхээр өгөхгүй байгаад байх юм. Та энийг нэг хөөцөлдөөдхөөч.

Би энийг амин хувьдаа авах гээгүй. Одоо энэ хүмүүсийн ярьж байгаа юм байна шүү дээ. Энэ манай лабораториуд өөрсдөө ерөөсөө маш буруу зүйл гаргаад байна аа. Орчин үеийн тэр явуулын лаборатори тэр яваад бүх газруудад машинаар явж үзээд ямар ямар.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Эрчим хүчний сайд Чойжилсүрэн хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Ганболд гишүүний асуултад хариулъя.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасан. Сая би танд хэлсэн. Нийслэл хотын агаарын бохирдлын асуудлыг бол 2024 оны 1 сарын 1-ээс эхлээд нийслэл хотын Засаг дарга хариуцаад авч явахаар ийм ойлголцолд хүрсэн Засгийн газар дээр 2 дугаарт бусад орчны бохирдлын асуудлыг бол Байгаль орчны яам өөрийн тусгасан төсвийн хүрээнд хариуцаад явахаар шийдэж байгаа гэсэн үг. Ганц агаарын бохирдол биш хөрсний бохирдол, усны бохирдол гээд бусад бүх асуудлыг бол Байгаль орчны яам энийг хариуцаад явна аа. Улсын хэмжээнд.

Хоёр дахь таны саналыг ойлголоо. Бид хөөцөлдье.

**Л.Мөнхбаатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Баярлалаа. Өнөөдөр бид нар их чухал асуудал хөндөж байна. Гэхдээ энэ дэндүү бас оройтож ярьж байгаа л даа. Бид нар 10 сарын эхээр чуулган эхлэх үед төсөв орохоос өмнө энэ Улаанбаатар хотын утаа энэ жил бас нэлээд хэцүү хүнд нөхцөлд орох магадлал өндөр байна аа.

Тийм учраас эртхэн төсөвлөөд төсөвт, нийслэлийн төсөвт, улсын төсөвт хэдийг нь яаж суулгах вэ одоогоос юуг нь хийх вэ? Нөгөө Тавантолгой түли түлинийхээ чанарыг яаж сайжруулах вэ гээд ярьж байсан. Тэр үед Чойжилсүрэн сайд ч гэсэн бас түлиний чанар дээр ийм ийм өөрчлөлт хийвэл зүгээр байна гээд асуудал орж ирж байсан ч тэгээд л сошиалаар нэг хэсэг баахан яриа өрнөөд л тэгээд л таг зогсчихсон.

Нөгөө нэг шийдвэрлэх ёстой мөнгө нь ч яваагүй. Тавантолгой түли компанийн захирал энд сууж байна. Түлинийхээ чанар дээр сайн хариулт ч өгч чадахгүй энд байж байна л даа. Ингэж болохгүй ээ. Өмнө нь яг 2018 онд Хүрэлсүх Ерөнхий сайд дээр ажиллаж байх үед гаргасан тогтоолоор Тавантолгой түлинд хатуу хяналт тавиад тэр цавуулаг зүйл нь ямар ямар бүтээгдэхүүн тэнд орох вэ яг аль өрхөд гар дээр яаж хүргэж өгөх вэ, түүхий нүүрс, хил гааль, энэ хороодоор орж ирэхгүй байх гээд бүгд шат шатдаа маш сайн хариуцлагатай байсан. Утаа үнэндээ тэгэхэд буурсан бодит үнэн.

Тэгээд дараа нь яасан үйлдвэр нь ажиллахаа байсан. Үйлдвэрийн чанар муудсан доголдсон гээд ингээд явчихсан нь бол бас үнэн байхгүй юу. Одоо тэгээд энэ бие биетэйгээ статистик мэдээлэл

солилцож ингэж өнгөрснийг ярьж суух цаг биш ээ. Тэнд хүмүүс эрүүл мэндэд нь аюул занал учраад байна шүү дээ. Угаартаж 57 хүн нас барсан гэж байна. Ямар ч шалтгаан байлаа гэсэн ингэх ёсгүй зүйл 1 дүгээрт.

Хоёрт нь хорт хавдрын өвчлөлөөр Улаанбаатар хотын бараг бүх хүн энэ байдлаар утаа үргэлжлээд байвал бүгд бараг өвчилнө. Гэхдээ энэ нь өнөө маргааш гарчих юм биш 10 жилийн дараа, 15 жилийн дараа ямар байдалд хүрэх вэ гэдгийг бүүр шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хавдрын эмнэлгийнхэн эмч нар гаргаад ирчихсэн байна шүү дээ.

Эрдэмтэд одоо яг энд нөлөөлөх хүнд нөгөө бусад төрлийн өвчнүүд маш их нэмэгдэж байна гэж байгаа шүү дээ. Тэгээд би энэ Улаанбаатар хотод шинэ бүрэлдэхүүн сая бид нарт танилцуулга хийхэд өмнө нь ч гараад ирчихсэн энэ судалгаанууд аль эрт байгаад байна шүү дээ. Шалтгаан юу юм бэ?

Утааны гэхээр л гэр хороолол 56 хувь, энэ автомашин 28.9 хувь бусад нь бусад зүйлүүд байгаа юм. Тэгэхээр 2 том шалтгаан энэ байна гэж хэлээд гэр хороололоо хурдан орон сууцжуулъя. Дэд бүтэц татъя аа. Айл өрхийг бүгдийг нь тэр өндөр байшинд оруулах бололцоо байхгүй бол бүгдээрээ хашаанд нь хаус бариад амьдрах бололцоог нь бүрдээд хэсэгчилсэн дэд төвүүд татъя гээд бид нар ярьсан хийсэн зарим нэг зүйлийг нь.

ЧД-ийн тэр 20 дугаар хороо Хөтөлд бид 300 айлыг сервис төв байгуулаад хашаандаа хаус бариад өнөөдөр бас бололцоотой, тэр урт яндангүй нүхэн жорлонгүй ингээд амьдарч байна. Өнөөдөр тэд дахиад 1 зуух нэмж нөгөө шинээр ингэж тавиад айлуудыг боломжтой ингээд утаа яндангаас салах бололцоо нь бүрдчихсэн байхад энэ зүйлээ л хурдан хийх хэрэгтэй



байна. Сэлбэ дэд төв болоод Баянхошууг ашиглаад 16 мянган айл өрхийг 2024-өөс 2026 онд орон сууцжуулах төлөвлөгөөгөө хотын шинэ удирдлага.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Хариулсны дараа тодруулах шаардлага байна гэж үзвэл нэмж асууж болно. Хэн хариулах вэ? Чойжилсүрэн сайд хариулах уу?

Дандаа санал байна гэж байна шүү дээ. Орон сууцжуулахаа тэгвэл Номинчимэг дарга товчхон хариулчихъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**О.Номинчимэг:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тийм ээ тэгээд бид нарын бас яг энэ мэдээж бид нар бодлогоо гаргахдаа тооцоо судалгаан дээр тулгуурлаж түүнийг хамгийн үр ашигтай ямар арга замаар хэрэгжүүлэх вэ гэдгээ л төлөвлөдөг. Тэгэхээр нийслэл хотын агаарын бохирдлын 55 хувь болон 39 хувь гээд хамгийн том 2 бохирдуулагч бол гэр хороолол болон авто тээвэр. Тэр дундаа 10 нас 10 жилээс дээш насжилттай авто тээвэр болон бүрэн бус техникийн үзүүлэлттэй ийм автомашинуудаас үүдэлтэй байна гэдгээ тодорхойлж гаргасан. Үүндээ ч чиглэсэн бодлогын арга хэмжээг авахаар хуульдаа бид тусган өргөн барьсан байгаа.

Орон сууц Сэлбэ дэд төв болон Баянхошуу дэд төв дээр тулгуурласан орон сууц барих энэ төлөвлөгөөг бол бид нар эрчимтэй явуулж байна. Нийслэл хотын 2024 оны төсвийг бид өчигдөр ИТХ-даа өргөн барьсан. Бидний энэ жилийн 2024 оны төсвийн гол бодлого ерөөсөө агаар, орчны бохирдолтой тэмцэж, гэр хорооллыг орон сууцжуулах Улаанбаатар хотын зам тээврийн нөхцөл байдал, нийтийн

тээврийг сайжруулах, нийгмийн хүртээмжтэй үйлчилгээ буюу сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг дээшлүүлэх, төр хувийн хэвилийн тэгшилэлийг сайжруулах замаар нийслэл Улаанбаатар хотын эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх гэсэн ийм 4 чиглэл ерөөсөө чиглэгдэж байгаа.

Ингээд 2024-өөс 2025 онд бид Сэлбэ дэд төвөөс ер нь ажлаа эхэлнэ гэж төлөвлөж байна. Нийт 2 мянган нэгж талбайг газар чөлөөлөлт хийнэ. Газар чөлөөлөлтдөө бид одоогоор 150 тэрбум төгрөгийг төсөвлөөд үүнээсээ гадна мэдээж дэд төвийнхөө инженерийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг сайжруулах ажлыг бас хийнэ. Үүн дээрээ тулгуурлаад орон сууцаа барих энэ ажлуудыг хийхээр төлөвлөж оруулсан байгаа.

**Л.Мөнхбаатар:** Нэмээд хариулъя. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье. Нэр албан тушаалаа хэлээд асуултад хариулъя.

**Ц.Даваацэрэн:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Яг энэ Тавантолгой түли компанийн гаргаж байгаа шахмал түли гэж яг юу вэ гэдгийг бүгдээрээ сайн ойлгох хэрэгтэй. Нэг их олон юм найруулаад, хутгаад ингээд хийдэг тийм нарийн технологи байхгүй шүү дээ.

Ерөөсөө л энэ Тавантолгой түли компаниас гарч байгаа шахмал түли бол 96 хувь нь медлинг Өмнөговь аймгийн Тавантолгойн нүүрсний орд дээр Энержи ресурсийн баяжуулах үйлдвэрээс гарсан завсрын бүтээгдэхүүн эрчим хүчний нүүрсийг 96 хувь дээр нь энд авчраад нөгөө нунтаг хэсгийг нь бүхэл болгох үүднээс л 4 хувьд нь барьцалдуулагч сольдог. Барьцалдуулагч маань юу юм бэ гэхлээр

ерөөсөө эрдэнэ шишийн ургамлаас гаргаж авсан хүнсний эрдэнэ шишийн ургамлаас гаргаж авсан цардуулд суурилсан ийм л бүтээгдэхүүн байгаа.

Энэ бүтээгдэхүүн барьцалдуулагч ерөөсөө энэ бүтээгдэхүүний дөрөвхөн хувьд ордог. Тэгэхээр үндсэн шалтгааны энэ утаа гэдэг юм уу энэ рүү бол барьцалдуулагчаар дамжиж нөлөөлөх бол маш бага. Тийм учраас ерөөсөө энэ бид нар түүхий нүүрс түлж байснаа одоо бол медлинг түлж байгаа гэж шууд ойлгож болно.

Тэгэхээр зэрэг энэ 2-ын зөрөө асуудлыг 1 дүгээрт энэ технологийн горим алдсан энээ тэрээ гээд илүү дутуу бодис сольдог юм уу илүү дутуу юм нэмдэг хасдаг тийм зүйл огт байхгүй. Ерөөсөө л медлинг гэдэг нь нүүрс түүхий нүүрсээ медлинг гэдэг угаасан эрчим хүчний нүүрсээ түлж байгаа л гэж ойлгох хэрэгтэй.

Тэгэхээр энд бол барьцалдуулагч яагаад хольдог юм гэхлээрээ нунтаг хэсгийг бүхэл болгож шатах процесст нь нунтаг нүүрс шатдаггүй гэдгээ бүгдээрээ мэднэ шүү дээ. Их нунтаг нүүрсгүй гэдгээ. Энийг чинь шатдаг процесст нь ойрхон болгохын тулд л бага хэмжээний барьцалдуулагч хольж байгаа юм аа.

Хоёрдугаарт Улаанбаатарын хот энэ байж байгаа энэ утааг ганцхан Тавантолгой түлшний энэ шахмал түлштэй ойлгоод байж болохгүй шүү дээ. Улаанбаатар хот өнөөдөр түүхий нүүрснээсээ салаагүй байгаа. 174 жижиг уурын зуух энд ажиллаж байна. Энэ дээрээ өнгөрсөн жилийн тооцоогоор 140 мянган тонн Багануурын түүхий нүүрс оруулж ирж түлсэн шүү дээ. Тэгээд энэ жил дахиад энэ 174 ААН-дээ Эрчим хүчний яамаар

дамжуулаад нийслэлийн агаарын бохирдолтой газраас 110 мянган тонныг төлөхөөр Багануурын нүүрсний уурхайтай гэрээ хийгээд оруулаад эхэлчихсэн байна.

Тэгэхээр энэ чинь 140 мянган тонн Багануурын хөндийн түүхий нүүрс чинь өнөөдрийн манай гаргаж байгаа шахмал түлшний 240 мянган тонн шахмал түлшнээс гарах дэгдэмхий бодистой тэнцэхүйц хэмжээний ийм дэгдэх бодистой утааг бол 140 мянган тонн Багануурын нүүрс гаргана шүү дээ. Тэгэхээр энэ утаагаа бид нар ганцхан шахмал түлш рүү буруутгаад байж болохгүй байх. Өнөөдөр дээрээс нь одоо энэ агаарын бохирдолд орж байгаа хүхэрлэг хийн хэмжээ бол ганц энэ түлшнээс биш бас энэ авто машины дизель түлшнээс их гарч байгаа.

Дизель түлшний стандарт маань энэ Европт бол Евро-2, Евро-3-аасаа бүгд татгалзаад Евро-5 руу шилжчихсэн байна шүү дээ. Энэ чинь Дизель түлшнээс гарч байгаа хүхэрлэг хийн хэмжээ бол стандартаас хэмжээ илүү их нөлөөлөөд байна гэдэг агуулгаараа Европын холбоо бүүр энэнээс татгалзсан явж байгаа. Тийм учраас бид энэ Улаанбаатарын утааны бүтэц чинь яг юу юм бэ гэдэг дээр бас зөв ойлгох ёстой байх. Энэ мэдээж бас шахмал түлшний нөлөө байгаа. Гэхдээ түүхий нүүрсний нөлөө бас бас байна.

6 сая тонн түүхий нүүрс өнөөдөр энэ 3 том станц дээр түлж байгаа. Энэ 3 том станцыг чинь ялангуяа ТЭЦ-3-ын яндангаас энэ шүүлтүүр нь бол энэ орчны бохирдолд бас нөлөөлөхгүйгээр хэмжээний тэгж шүүж чадахгүй байгаа шүү дээ. Энэ бүх энэ суурин станцуудаар ингээд энэ агаарын бохирдлууд ингээд хэмжиж байгаа станцуудыг ингээд харахад бол ТЭЦ-3-ын районы тэндээс гарч байгаа утааны

хаягдаж байгаа хэмжээний районд бол агаарын бохирдлыг илүү их байгаа шүү дээ. Ялангуяа тоосонцрын хэмжээ бол бүүр илүү их байдаг.

Тэгэхлээрээ зэрэг энэ автомашинаас гарч байгаа угаарын хий, станцуудаас гарч байгаа хий, түүхий нүүрс түлж байгаа жижиг уурын зуухнуудаас гарч байгаа хийнүүдийг бүгдээрээ тооцож үзэх хэрэгтэй л байх л даа ганц одоо Тавантолгой түвшинээс гарч байна гэж ойлгохгүй байх гэж бодож байгаа.

Хоёрдугаар асуудал энэ микинээр Багануурын нүүрснээс дэгдэмхий хий буюу угаарын хий утааны хий бол харьцангуй 2 дахин бага. Гэхдээ хүхэр хүхэрлэг хийн хэмжээ бол Багануурынх 0.6 байдаг бол энэ медлинг дээр бол 0.9-1 байдаг.

Тэгэхээр энэ хүхэрлэг хийг цаашидаа бууруулах тал дээр бол тодорхой арга хэмжээ авах ёстой. Гэхдээ хүхэрлэг хийн хэмжээ Европын болоод одоо олон улсын батлагдсан стандартад нэг байдаг юм байна лээ. Манайхаар бол MNS 5679 гэсэн стандартаар 1.1 гэж баталсан, өнгөрсөн жил 1.3 гэж баталсан байсан юм байна лээ. Энийг энэ жил бид нар сайн шаардлагыг өндөр болгоод 1.1 болгоод буулгачихсан энэ хүрээндээ бол байгаа гэж ингэж ойлгож болно оо.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асуух уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Даваацэрэн дарга баахан том томьёо ярьчихлаа л даа. Би Тавантолгой түши компани дээр удаа дараа очиж ажиллаж байсан. Түшиний чанар муудаад байна гэдгийг иргэд ярьж байгаа. Би өөрөө ЧД-ийнхээ энэ гэр хорооллын айл өрхүүдээр ороод үзэхэд

бид нарт бүүр бутлаад өмнө нь ийм байсан одоо ийм байна гээд үзүүлж байгаа. Та өөрөө айллуудаар яв, 1 дүгээрт.

Хоёрдугаарт түүхий нүүрсний тухай мэдээж яриад ч хэрэггүй шүү дээ. Асар их хор учруулж байгаа гаргаж байгаа. Гэхдээ хүмүүс хөлдөж үхэхгүйн тулд зарим нь төлж л байна л даа. Төлүүлэхгүй байх нөхцөлийг төр өөрөө л хийх ёстой гэж бид яриад байна танд тэгэхээр та ажлаа сайн хийхийг би танаас хүсэж байна. Энэ утаа чинь иргэдийн эрүүл мэндэд аюул учруулж түгжэрэл тэвчээр барж байгааг бид нар мэднэ шүү дээ.

Төрөөс бодлогоор арга хэмжээ аваад байгаа хэр нь мөнгө дунд шатдаа очоод буруу зам руу урсаад байна. Тэрийг л бид нар яриад байгаа юм. Энэ дээр та өөрөө анхаарч ажиллаач гэж танаас хүсмээр байна.

Тэгээд одоо нийслэлийн төсөв 2012 онд 12 сард нийслэлийн төсөв хэлэлцэнэ. Ирэх 7 хоногоос бараг хэлэлцэх байх сая өргөн барьж байна лээ. Тэгэхээр би нийслэлийн удирдлагуудаасаа энэ газар чөлөөлөлтөд гэр хорооллоо орон сууцжуул.

**Л.Мөнхбаатар:** Тодорхой санал хэллээ. Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрэм, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны Захирагчийн ажлын алба, Соёлын төвийн ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Та бүхэнд улсын их сургалтын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөрт нь өндөр амжилт сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе өө.

Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьшаа:** Бид нар энэ Улсын Их Хурал жил бүхэн л энэ утааны тухай ярьж байна. Шийдлийн тухай ч ярьдаг, үр дүнгийн тухай ч ярьдаг. Тэгээд л энэ сайн болж өгөхгүй л байгаа гэсэн ийм ойлголттой байгаа. Тэгэхээр энийг нэг их улс төржөөд бид нар хэрэлдээд, тэр нь сайн, муу энэ тэр гэх юу байх вэ. Ер нь энийг бол бас бодит нөхцөл байдал дээр технологийн шийдэл дээрээ, орчны нөхцөл дээрээ, улс орныхоо эдийн засгийн нөхцөл дээрээ бид дүгнэлт хийх ёстой гэж бодож байгаа юм.

Тэгэхээр энэ нүүрсний хулгай луйвар гээд Улсын Их Хурлын Түр хороо байгуулагдаад энэ асуудал яригдаад энэ Тавантолгойн нүүрсний экспорттой холбоотой асуудал яригдаж байхад энэ Хятад руу Тавантолгойн нүүрсийг өгөөд Хятадаас эргэж экспортлсон. Ийм сайжруулсан түли кокс ирүүлсэн тухай мэдээлэл байгаа. Ер нь хэчнээн тонн нүүрс ирсэн юм бол. Тэрийг нь хэрэглэдэг юм уу? Энэ ер нь хэр бодитой мэдээлэл вэ гэдэг талаар нэг хариулт авмаар байна.

Хоёрдугаарт нь одоо бид нар нэг сүүлийн энэ утаа гэдэг юм чинь 20 гаруй жилийн өмнөөс л Улаанбаатарын төвлөрөл бий болж л энэ яригдаад л үе үеийн Засгийн газруудын үед л энэ толгойны өвчин болоод л хэн нэгнийгээ сайн муугаар яриад л улсын төсөв хөрөнгө яриад л ингээд байж байдаг. Гэтэл энэ газар хангах энэ төсөл энэ тухай нэг яригддаг. Энэ төсөл чинь ямар шатандаа явж байна аа? Мөн ураны эрчим хүчийг ашиглаж 3 дахь

орны технологийг ашиглаж энэ Улаанбаатар хотын эрчим хүчний эх үүсвэрийг шийдэх асуудал яригддаг.

Энэ тухай сүүлийн үед бас төр засгийн хэмжээнд гадаад бодлогын хэмжээнд ч яригдсан. Тэгээд энэ Засгийн газар энэ асуудлаа Улсын Их Хуралд оруулж ирж яагаад энийг шийдүүлэхгүй байгаа вэ? Энэ талаар нэг мэдээлэл авъя. Энэ асуудлыг ер нь энэ нүүрс биш, энэ газрын технологи, газаар хангах эх үүсвэр түүнчлэн ураны эрчим хүчийг ашиглаж 3 дахь орны техник технологи, хөрөнгө санхүүгийн байдалтай эдийн засгийн зөв бодлогын хүрээнд энэ түншлэлээ явбал бид энэ чинь л хамгийн зөв шийдэл байгаа шүү дээ.

Энийгээ бид нар өнөөдөр яагаад шийдэхгүй байна. Засгийн газар Энэ талаар ямар бодолтой байна аа? Энийг Улсын Их Хурлаар энэ онд багтааж оруулж ирнэ гэсэн ийм яриа яригдаж байсан. Энэ яагаад орж ирэхгүй байна. Энийгээ ингэж яаравчилж шийдэж энэ утааны асуудал, эдийн засгийн асуудал, энэ хүн амынхаа эрүүл мэнд, энэ эрчим хүчний хангалтын асуудлыг шийдэх шийдэл байгаа л гэж би ойлгож байгаа. Энэ талаар хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Сайд хариулах уу? Ажлын хэсэг эхэлж хариулаад юу яах юм уу? Ажлын хэсгээс хэн хариулах юм? Даваацэрэн дарга хариулах юм уу? Хэд хэдэн асуулт асуулаа шүү дээ. Ажлын хэсгийн 82 дугаар микрофон. Эрчим хүчний яамнаас хариулчихъя.

**И.Лувсанцэрэн:** Манай дээр энэ жилийн туршилтад хэрэглэсэн импортоор зүгээр туршилт нөгөө лабораторийн туршилт хийх гэж оруулж ирсэн 80 тонн орж ирээд лабораторийн туршилт хийсэн. Энэ

хэрэглээ зөвхөн лабораторийн түвшинд л туршигдаад үзэж хараад ингээд жоохон үлдсэн 29 тонн. Энэ бол манай складад хадгалаатай байж байгаа. Энийг ард иргэдэд ер нь худалдаанд алийг ч гаргаагүй.

Тийм учраас энэ хагас коксыг оруулж ирээд борлуулчихсан зарчихсан гэсэн асуудал бол энэ буруу. Энэ буруу ойлголт гэж хэлэх гэж байна. Ер нь бол 80 тонныг оруулж ирээд Эрчим хүчний яаман дээр байгуулагдсан ажлын хэсгийнхэн бол ер нь энэ шахмал түлшний түүхий эдийг цааш нь ер нь юугаар хийх вэ яаж түлшний чанарыг сайжруулах вэ гэдэг туршилтын ажлыг энэ бараг бүтэн жилийн хугацаанд өнгөрсөн жилээс хийсэн. Тэгээд үүний үр дүнд бол ер нь хагас кокс руу бид нар медлингийн хагас кокс болгож л ер нь дотооддоо хагас кокс үйлдвэрлэж энэ цаашидаа шахмал түлшнийхээ чанарыг илүү сайжруулах юм байна л гэдэг дээр ажил дэд хэсгийнхэн санал нэгдсэн юм.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулъя.

Эрчим хүчний сайд Чойжилсүрэн.

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүний асуултад гүйцээгээд хариулъя аа.

Энэ туршилтыг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос төсвийг нь гаргаж санхүүжүүлсэн. Яг тэр бид нарын ингээд энэ туршилт хийсэн юу Компани дээр бол Тавантолгой түли компани дээр хийсэн. 4 тонн бас бэлэн түли бас оруулж ирсэн байх ёстой үйлдвэрээс. Энэ галлагааны туршилт хийхийн тулд ийм түлшнүүд бий. Энэ газрын асуудлын талаар танд нэг мэдээлэл болгоод өгье. ОХУ Хятад хооронд 50 тэрбум шоо метр куб жилдээ газ нийлүүлэх энэ том

төсөл яригдаж байгаа юм. Жилдээ 50 тэрбум.

Манай хилээс хойшоо 1800-аад километр Ямалийн ордоос манай хил дотуур мянга орчим яваад манай хилээс хойшоо 4 мянга гаруй яваад манай дээр 1100 орчим километр яваад манай хилээс урагшаа гараад Бээжин хот ортол бас 1700, 1800 км явах ийм том төсөл юм байна. Энэ ОХУ талаасаа Газфром хувьцаат компани, Хятад талаасаа бол нөгөө Си Эм Пи Си гэдэг бас ялгаагүй ийм ТӨК энэ ажлуудыг хэлэлцээд явж байгаа. Магадгүй хэлэлцээр амжилттай энэ 2 хөршийн маань хоорондох хэлэлцээр амжилттай болох юм бол манай улсаар дамжаад энэ газрийн хоолой тавигдана.

Энэ тохиолдолд гэрээ байгуулагдсанаас хойш бол Монголын тал болон Оросын нутгаар явах Хятадын нутгаар явах энэ төслийн бүх ТЭЗҮ-үүд тооцоолууд техникийн нөхцөлүүд төслийн урьдчилсан судалгаанууд бараг бэлэн болоод дуусаж байгаа юм байна лээ. Гэрээ байгуулснаас хойш 4.5 жилийн дотор ашиглалтад оруулна гэдэг ийм тооцоо байгаа юм байна лээ. 2024 ондоо бид нар хэрвээ хамгийн өөдрөгөөр тооцоолох юм бол 2024 ондоо багтаад ОХУ, Хятад улс хооронд хамгийн том худалдан авагч нь Хятад улс учраас манайх гуравдагчаар бас энд газыг худалдан авахаар ийм саналуудыг тавьчихсан байгаа.

Энэ төсөл хэрэгжсэн тохиолдолд 2028 оны төгсгөл, 2029 он гэхэд Монгол Улс газтай болж магадгүй. Ийм урьдчилсан баримжаа ажлын үйл явц нь иймэрхүү байгаа юм байна лээ гэдгийг хэлье ээ. Цөмийн эрчим хүчний талаар та асууж байна. Энийг яриад эхлэх юм бол энэ 5 минутад багтахгүй байх. Зүгээр цөмийн эрчим хүчний талаар

Цөмийн эрчим хүчний комисс гэж байгаа Монгол Улсад.

Яг сайд нь хариуцсан сайд нь бол Боловсролын сайд Энх-Амгалан сайд хариулах ёстой. Танд шаардлагатай мэдээллүүдийг бид нар бичгээр хүргүүлье.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл үг хэлье.

Зөвхөн асуулга тавьсан гишүүн үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Би бас үгээ давтаад л хэлье. Эсрэг тэсрэг нэг асуудал дээр хувь нь үнэн гэж байхгүй ээ. Утааг ялсан гэдэг нь үнэн юм уу гэдэг асуудлыг л бас би бас түрүүний асуулгын эхэнд хэлсэн.

Үнэхээр энд ярьж байгаа хүмүүсийнхээр энд ярьж байгаа хүмүүсийнхээр тэр эрүүл мэндийн салбарынхан энэ асуулгын хариунд ирүүлснийг би дахиад уншиж үзүүлье л дээ. Сайжруулсан түли хэрэглэснээр нийслэлийн агаарын бохирдол түүхий нүүрс түлх үеийнхтэй харьцуулахад буурсан хэдий ч тоосонцор, хүхэрлэг хийн хэмжээ, азотын давхар исэл стандартаас хэт өндөр хэвээр байна л гэж байна. Нөгөө нэг ялсан малсан гэдэг худлаа юм байна.

Эрүүл мэндийн сайдын нэг ярианд гарч байна лээ. Агаарын бохирдлоос болж тэр уушгитай холбоотой амьсгалын замын өвчлөлийн бараг 40 хувь нь агаарын бохирдлоос болж байна гэдгийг Их Хурал дээр ярьж л байсан. Тэгэхээр тэр ялсан гэдэг шоу байжээ, худлаа юм байна аа. Сая энэ мэдээлэл өгч байгаа хүмүүсийн хэлж байгаагаар өнөө жил зөвхөн 23 онд чинь дахиад

хүйтэн сар гаран дутуу байна. Өнөө жил 57 иргэн нас барчхаад байгаа. Утаанаас болоод, түвшнээс болоод, угаарын хийнээс болоод.

Хоёр мянга гаран иргэн эмнэлэгт угаарын хордлогоос болж 2 мянга гаран иргэн эмнэлгийн тусламж авсан гэж байна. Тэгэхээр бид нарын нөгөө нэг бодит байдлыг бас бүгдээрээ харж л байна. Тэр ялсан энэ тэр гэж шоуддаг үр дүн нь ингэж шал худлаа байдаг олон зүйл л энэний цаана ингээд л тодорхой л болж байна л даа. Олон зүйл энэний цаана тодорхой болж байна. Тэгээд энэ бодлогын энэ алдаанууд энэ дээр их байжээ. Зөвхөн сая 1 их наядын асуудал ярьж байна. 1 их наядыг өнгөрсөн хугацаанд зарцуулсан. Энэ чинь зөвхөн энэ Тавантолгойн түли гэдэг компанитай холбоотой 1 их наяд гарны татаасын асуудал ярьж байгаа юм.

Энэ нь тэр цахилгаан, дулаанд өгсөн татаасууд, халаагуурын 40 мянган айлд халаагуур гэж тайлан дээр явж байна лээ. Энэ бүгд аль нь ч энд хамаараагүй. Энэ 1 их наядын чинь цаана агаарын бохирдолтой холбоотой дахиад асар их мөнгө бий. Зөвхөн энэ мөнгө нийлэхэд чинь өөрөө зүгээр зуу шахам мянга, магадгүй 60, 70 мянган айлын ипотекийн хүүгийн зөрөөг өгөөд байранд оруулчих боломж байжээ. 180 мянган яндан байгаа бол бараг энэний чинь талыг нь энэ өнгөрсөн хугацаанд шийдчих л байсан юм байна шүү дээ.

Энэнээс илүү бодлогын шийдэл гаргаж байна гэж л энэ үйлдвэр энэ тэр чинь улс төрийн шоу болж яваа биз дээ. Гэтэл үр дүн нь хаана байгаа юм. Нас баралт нэмэгдэж байгаа гэж байна. Угаарын хордлогоос болж жил бүхэн нас баралт нэмэгдэж байгаа.

Тэгэхээр үнэхээр энэ харагдах үзэгдэх нь арай багассан байж магадгүй

тэр хорт чанар нь улам ихэсчихсэн байгаа юм биш үү? Энэ сайжруулсан түлшний чинь. Тэгээд яагаад хүний нас баралт яагаад ихсээд байгаа юм? Тэгэхээр энэ бүгд ингээд нэгтгээд дүгнээд хэлбэл энэ нүүрсний утаа маань явсаар явсаар байгаад бодлогогүй утаа байсан юм байна. Явсаар явсаар байгаад энэний цаана асар том ийм авлигалын асуудал гарч ирж бас нэг авлигалын утаа болж утааны авлигал гэдэг бас нэг том сэдэвтэй Монголчууд нийтээрээ зууралдаж бас эхлэх нь ээ.

Тэгэхээр ерөөсөө яг энэний цаана бид нар энэ төртэй холбоотой төрийн оролцоотой холбоотой олон ажлууд яаж явдгийн жишээ л дахиад энд гарч байна л даа.

Ер нь хүн төрөлхтөн зах зээлийн эдийн засгийн харилцаанд ороод нэг ийм түлшний асуудлыг төр нь хийдэг хэдэн мянган хүн цуглуулчхаад техник технологи байхгүй бараг гараар шахуу шуудайгаар үүрээд ингэж хийдэг орчин үеийн 21 дүгээр зууны ийм үйлдвэр бараг байдаг ч юм уу, үгүй ч юм уу бүү мэд. Хэдэн 100 хүн, хэдэн мянган хүн л ажилладаг юм гэнэ лээ. Нэг нүүрс авчраад нунтаглаад, шахаад, хэвлээд гаргаж байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэний цаана үнэхээр зөвхөн нэг асуудал ч гэсэн энэ төрийн бодлогогүй нь бид нарын буруу зүгт яваад байгааг нь төр улам том болоод байгаагийн, ТӨК-удын татаас гэдэг ямар үргүй зүйлд зарцуулагддаг хэдэн их наядын асуудал тэгээд үр дүн нь ямар байдгийг нь л бодит үлгэр дуурайллыг, бодит үлгэр болоод үр дүнг бид нар ингээд л харж байгаа нь харамсалтай байна аа.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэлээс Монгол Улсын ерөнхий сайдад хандан

тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

*Ажлын хэсэгт баярлалаа.*

*Одоо хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.*

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Оюунчимэг гишүүн.

Оюунчимэг гишүүн санал хэлье.

**М.Оюунчимэг:** Би нөгөө төсвийн ажлын хэсгийн гишүүний хувьд нэг санал хэлж байгаа юм. Энэ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 14.1.56 төсөл арга хэмжээний Эрдэнэбүрэн гэснийг Эрдэнэбулган гэж редакцын засвар хийх саналтай байна. Яагаад гэвэл энэ сумын нэр нь Эрдэнэбулган гэсэн байгаа Хөвсгөл аймгийн.

**Л.Мөнхбаатар:** Төсвийн тухай хуульд заагдсан Соёлын төвийн барилга 250 суудал, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум гэж залруулж унших нь байна. Ингээд эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2.Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

**Холбогдуулан боловсруулсан:**

4.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

**Дагалдан гарсан:**

5.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

6.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

7.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

8.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

9.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

12.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

13.Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

14.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

15.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

16.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

17.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль



*/Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*18.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*19.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*20.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*21.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*22.Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*23.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*24.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*25.Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*26.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*27.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*28.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*29.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*30.“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.*

*31.“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй*

байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

32. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

1. “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Та эцсийн найруулга дээр саналтай байгаа юм уу?

2. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна

уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Даргын зөвлөл Улсын Их Хурлын даргын өрөөнд хуралтай. даргын зөвлөлийн гишүүд.

**Г.Занданшатар:** 2023 оны намрын

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА